# ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу ХЭРЭГЖИЛТ /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **1.1. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ, СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, САЛБАРЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.1-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***1.1.1.Салбарын хууль тогтоомж, стратегийн дунд, богино хугацааны нэгдсэн бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах*** | | | | | | | |
| 1. | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.<br>*/Алсын хараа-2050 3.1.2, ТТШТББ /2015-2030/ 3.2, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.1, МУЗГҮАХ 2020-2024 2.5.1, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.1./* | Үйл ажиллагааны зардал | Шинээр боловсруулсан, шинэчлэн найруулсан хуулийн төслийн тоо- 5<br><br>Дагалдах хуулийн төслийн тоо-89 | Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлж, 31 удаа нэмэлт, өөрчлөлт орсон, шинэчилсэн найруулга хийгдэж байгаагүй. | Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Хуулийн төсөл хэрэгжсэнээр дараах эерэг үр дүн гарна. Үүнд:<br>✓ Нийгмийн даатгалын харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулах;<br>✓ НД-ын сангийн санхүүгийн чадавх сайжирч, тогтвортой байх нөхцөл бүрдэнэ<br>✓ НД-ын сангийн хөрөнгийг санхүүгийн олон хэрэгсэлд оруулах боломж бүрдэж, хяналт сайжирна<br>✓ Нэрийн дансны орлогыг үе шаттай мөнгөжүүлж хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлнэ<br>✓ Мөнгөжүүлсэн орлогын тодорхой хувийг Хуримтлалын нэгдсэн санд байршуулах замаар эрүүл мэнд, боловсрол, орон сууцны санхүүжилтийн эх үүсвэрт зарцуулах нөхцөл бүрдэнэ<br>✓ Нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогын тодорхой хэсгийг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.<br>✓ Нийгмийн даатгалын үйлчилгээ бүрэн цахимжина<br>✓ Тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлдэг болно<br>✓ Төлсөн шимтгэлтэй уялдаатай тэтгэвэр авах шударга тогтолцоо бүрдэнэ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Тэтгэвэр авагчийн тэтгэврийг нас барсан эхнэр эсхүл нөхрийн авч байсан тэтгэврийн 20 хувиар тооцон нэмэгдүүлэх;<br>✓ Шимтгэл төлсөн жилтэй уялдаатай тэтгэмж авах нөхцөл бүрдэнэ<br>✓ Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй<br>✓ Ажлын байраа хадгалсан, Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээ нэмэгдэнэ<br>✓ Тэтгэмжийн даатгалын болон ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн харилцааг нэг хуулиар зохицуулна<br>✓ Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажлын байрнаас хамааран ялгаатай төлөх боломж бүрдэнэ.<br>✓ Ажлын байраа хадгалсан, Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээ нэмэгдэнэ.<br>✓ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар ажил олгогч, даатгуулагчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын үйл ажиллагаа тогтмолжино. | |
| 2. | Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ.<br>*/Алсын хараа-2050 3.1.10, МУЗГҮАХ 2020-2024 2.5.7, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.5./* | Үйл ажиллагааны зардал | Шинэчлэн найруулсан болон шинээр боловсруулсан хуулийн төслийн тоо-2, дагалдах хуулийн төслийн тоо-19 | 2012 оноос хойш хууль шинэчлэгдээгүй | Хуулийн төсөл боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Нийгмийн халамжийн шинэчилсэн найруулгын төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/2831 дугаар албан бичгээр хүргүүлсэн байсан.<br>2022 оны 8 дугаар сард Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ЗГХЭГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн ХЭГ/1996 дугаар албан бичгээр буцаан ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан яам, агентлагийн ажлын хэсэг 2023 оны 3-4 дүгээр сард Нийгмийн халамжийн тухай хуулийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинэчилсэн найруулгын төслийг дахин сайжруулах, холбогдох баримт бичгийн тоо мэдээллийг шинэчилж Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцоог дахин боловсруулж ажиллав.<br>2023 оны 9 дүгээр Дэлхийн банкны ТСТББТ-ийн хүрээнд Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэл дээр дотоодын зөвлөхийг ажиллаж байна. Энэ хүрээнд дээрх хуулийн төслүүд дээр ажиллаж саналын хувилбарыг боловсруулсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд шинээр орсон хуулийн хэрэгжилтийн үнэлгээний судалгаа болон дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцооллыг боловсруулахад хамтран ажилласан.<br>Хуулийг төслүүдийг 2023 оны 11 дүгээр сарын 15,16-ны өдөр ХХҮЕГ-аас зохион байгуулсан 21 аймаг, 9 дүүргийн халамжийн сан, олголт хариуцсан мэргэжилтнүүдэд, 23, 24-ний өдөр Багануур, Хэнтий аймгийн ХХҮ-ний газар, хэлтсийн мэргэжилтэн, сум, хорооны нийгмийн ажилтнуудад, 12-р сард нийслэлийн төсвийн 6 дүүрэг болон ШШГЕГ, СЭМҮТ, ОБЕГ, мэргэжлийн холбоод зэрэг бусад оролцогч талуудаар хэлэлцүүлж санал авч тусгалаа. Мөн түүнчлэн халамжийн тогтолцооны өнөөгийн байдал, шинэчлэх хэрэгцээ шаардлага болон шинэчлэлийн үзэл баримтлалын талаар бодлого боловсруулагчдад зориулсан гарын авлагыг боловсруулж хэвлэхэд бэлэн болгов.<br>Хуулийн төслүүдийн үзэл баримтлалын төслийг 2023 онд багтаан ХЗДХ-ийн яаманд дахин хүргүүлж батлуулахаар ажиллаж байна.<br>Мөн Нийгмийн халамжийн хууль эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Алдар цолтой ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг шинэчлэн боловсруулан 2023 онд батлуулж, хуулийн төслийг боловсруулан хэвлэл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нөлөөллийн ажил хийсний үр дүнд ядуу өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэх, бэлэнчлэх сэтгэлгээгээ бууруулах, амьжиргаагаа дээшлүүлэх хандлагыг нэмэгдүүлж, улмаар халамжийг хавтгайруулалгүйгээр зөвхөн зорилтот бүлгийн иргэдэд хүргэх шаардлагатай гэсэн олон нийтийн ойлголт хандлагыг дээшлүүлсэн.<br>Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн зарим зүйл, заалтын зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор нийгмийн халамжийн зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэн баталсан.<br>Уг хууль батлагдсанаар нийгмийн халамжийн тэтгэвэр авах ахмад настны нас, нийгмийн даатгалын тэтгэвэр авах ахмад настны наснаас бага буюу 55, 60 нас байсныг жил бүр 3 сараар нэмэгдүүлэн болсон 65 нас болгон өөрчилсөн.<br>Мөн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийн иргэдийг анхан шатанд олон нийтийн оролцоотойгоор тодорхойлдог Амьжиргааг дэмжих зөвлөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулсан.<br>Уг хуулиудыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс улсын хэмжээнд мөрдөж эхлэхтэй холбоотой нийгмийн халамжийн салбарын төв, орон нутгийн нийт албан хаагчдад мэдээлэл, зөвлөмж өгөхөөр ХНХ-ын сайдын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/2680 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлэв. | |
| 3. | Нийгмийн халамжийн шинэчлэлд тусгасан зорилтот өрхийг чадавхижуулах халамжийн үйлчилгээний загвар тодорхойлох зорилгоор АХБ-ны төслийн | ОУБ-ын төсөл, хөтөлбөр 1.7 сая ам. доллар | Туршилтын хөтөлбөрт хамрагдсан 1520 өрхөөс амьжиргаа нь дээшилсэн өрхийн тоо | Сонгогдсон өрхийн амьжиргааг дэмжих тусгайлсан хөтөлбөр байгаагүй | Туршилтын хөтөлбөрийг 2023 оны турш хэрэгжүүлж, хамрагдсан өрхийн 80-аас доошгүй хувийн | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хүрээнд “Төгсөлтийн аргачлал” туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд 2022 оны 6 дугаар сараас эхлэн нийслэлийн ЗДТГ, Монголын улаан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжлэгтэйгээр “Төгсөлтийн аргачлалыг хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр”-ийг нийслэлийн 3 дүүрэгт туршин хэрэгжүүлнэ. *\/Алсын хараа-2050 3.1.5, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.4, МУЗГҮАХ 2020-2024 2.5.9, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.5.\/* | | | | амьжиргаа нь дээшилсэн байна. | загалмай нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж байна. 2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>- АйАрЭм судалгааны байгууллагын оролцоотойгоор зах зээлийн судалгааг 2022 оны 12 дугаар сараас эхлүүлж, сонгогдсон өрхүүдийн эрхлэх боломжтой аж ахуй эрхлэлтийн урт болон богино жагсаалтыг гаргуулах ажлыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэв. Уг судалгааны дүнд хөдөлмөр эрхлэх боломжтой 24 чиглэлийг тодорхойлж, тухайн чиглэл бүрээр нарийвчилсан тооцоолол, судалгаа гаргасныг 2023 оны 5 дугаар сард хүлээн авсан.<br>- Туршилтын хөтөлбөрийн хүрээнд баримтлах “Төгсөлтийн шалгуур үзүүлэлтүүд”-ийг эцэслэн боловсруулж, Төслийн захирлаар батлуулсан.<br>- Сонгогдсон өрхүүдийн хөдөлмөр эрхлэхэд бэлэн байдлын (бизнес профайлинг) үнэлгээг хийж, тэдний нийгмийн идэвх оролцоог сайжруулах, тэдэнд тохирох бизнесийг санал болгож түүнд нь зохих дэмжлэг үзүүлэх зорилгоор бүлгийн болон цогц сургалт, уулзалтууд, улмаар судалгааг 4 дүгээр сард зохион байгуулсан.<br>- Бизнес профайлинг хийсний үр дүнд хөтөлбөрт хамрагдах 1520 өрхөөс нийт 1281 өрх орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх бизнес сонголтыг хийсэн. Харин өрх ямар нэг бизнес сонгоогүй 241 өрх байна.<br>- Бизнес эрхлэх хүсэлтэй 1281 өрхөд орлогоо нэмэгдүүлэх, тухайн өрхөд бизнес эрхлэхэд шаардагдах орлого олох зориулалт бүхий тоног төхөөрөмжийг худалдан авах олгох ажлыг зохион байгуулан ажилласан. Өнөөдрийн байдлаар Монголын улаан загалмай нийгэмлэг нь хөтөлбөрт хамрагдсан 1,277 өрхийн гишүүний ур чадварыг хөгжүүлэх, чадавхжуулах, сургалтуудыг хийж, оёдлын үйлдвэрлэл, хоол, хүнс цагаан идээ, хүнсний ногоо хэрчиж, савлах үйлдвэрлэл, хүлэмжийн ногоо тариалах тоног төхөөрөмж зэрэг 12 төрлийн багц тоног төхөөрөмжийг олгоод байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангана. *Алсын хараа-2050 2.3.6, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.4, МУЗГҮАХ 2020-2024 2.5.7, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.7/* | Дэлхийн банкны төсөл 4500$ | -Судалгаанд хамрагдсан өрхийн тоо | Аргачлал 2017 оноос хойш шинэчлэгдээгүй. | -Төрийн захиргааны мэдээлэл солилцох боломжийг судалсан байна.<br>-Судалгаа хийсэн байна.<br>-Судалгааны үр дүнд бүрдсэн мэдээллийн сангийн мэдээллийг бодлого хөтөлбөрт ашиглаж эхэлсэн байна. | Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хамтарсан А/84, А/89 тоот тушаалаар Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэн батлуулсан.<br>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоолоор хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан нийт хүүхдийн 91 хувьд олгохтой холбоотой “Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”-ыг боловсруулж Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/14, А/04 дүгээр хамтарсан тушаалаар баталсан юм. Уг аргачлалын дагуу хүүхдийн мөнгийг 91 хувьд олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>Мөн түүнчлэн уг аргачлалын дагуу хүнсний эрхийн бичигт хамрагддаг өрхөөс судалгаа авах ажлыг зохион байгуулж ажилласан.<br>Энэ хүрээнд:<br>• Орлогыг орлуулан тооцох аргачлал /ООТА/-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/36 дугаар тушаалыг батлуулсан.<br>• Уг тушаалын дагуу судалгааг АХБ-ны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-ийн батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулахаар ажлын удирдамж, төсвийн тооцооллыг бэлтгэж, АХБ болон Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br>• ООТА-аар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 26,900 өрхийг хамруулан улсын хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр эхлүүлсэн.<br>• Зөөврийн төхөөрөмжид зориулсан судалгааны программыг үндсэн системийн хамт ашиглалтад оруулж, 21 аймаг, 9 дүүргийн ХХҮГ/ХХҮХ-ийн дарга, мэргэжилтэн болон судалгааны багийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гишүүдэд программ хангамжийн сургалтуудыг танхим болон цахимаар зохион байгуулав. Мэдээлэл технологийн ажилтнуудад pmt2022 систем болон түүний хэрэглэгчийн болоод судалгааны модулийн ашиглалтын сургалтыг 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар 5 удаа зохион байгуулсан. Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд 26,900 өрхийн жагсаалтыг бэлтгэсэн. Өрхийн жагсаалтад орсон өрхүүдийг тоологчид хуваарилах болон газрын зурагт тэмдэглэх ажлуудыг хийлгэсэн.<br>• Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтан болон багийн ахлагч/сургагч багшийн сургалтын бэлтгэлийг хангаж, сургалтыг 5 дугаар сарын 11-13-ны өдөр 70 хүнийг хамруулан, Улаанбаатар хотод танхимаар, тоологчийн сургалтыг аймаг, дүүргийн ХХҮГ/ХХҮХ нь аймаг, дүүргийн хэмжээнд 5 дугаар сарын 21-23-ны өдөр 700 орчим тоологч, ахлагчийг хамруулж танхимаар (хувь зөвлөх цахимаар зөвлөж, чиглүүлж, зарим бүсэд дахин сургалт хийсэн) зохион байгуулсан.<br>• Судалгааны урьдчилсан дүнгээр нийт хамрагдах өрхийн 99.1% хамрагдсан байгаа бөгөөд цаашид төрийн бусад байгууллагаас шаардлагатай мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх ажил хийгдэж байна.<br>• 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс шинэчилсэн аргачлалаар өрхийн амьжиргааг тооцон хүнсний дэмжлэг үзүүлэх өрхийг тодорхойлохоор ажиллаж байна. | |
| 5. | Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэнээс бууруулахгүйгээр нэмэгдүүлнэ. */МУХТЖҮЧ 2021-2025 3.1.5, МУЗГҮАХ 2020-2024 2.5.5, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.8./* | Улсын төсөв:114.4 тэрбум.төг | Тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлийн хэмжээ | 2020 оны Тэтгэврийн хэмжээ-188.000 төг | Тэтгэврийн хэмжээг 288000 төгрөгт хүргэж нэмэгдүүлэх Засгийн газрын тогтоолыг батлуулсан байна. | Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр олгохоор “Тогтоолд өөрчлөлд оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 3 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 288 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 70 мянга гаруй зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн баталгааг хангах боломж бүрдсэн.<br>Халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс шинэчлэн тогтоохоор Засгийн газрын тогтоолын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төслийг боловсруулж, 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 237 дугаар тогтоолоор батлуулсан. Ингэснээр:<br>✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр 325 мянган төгрөг,<br>✓ Асаргааны тэтгэмж 275 мянган төгрөгт хүрч нэмэгдэв.<br>Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 12.3%, 2020 оноос хойш нэмэгдээгүй байсан асаргааны тэтгэмжийн хэмжээ 2.2-3.2 дахин нэмэгдэв. 2023 онд Хүн амын амьжиргааны түвшин бүсүүдийн дундаж 282,880 төгрөг байгаа ба тэтгэврийн хэмжээ энэ оны 7 сараас нэмэгдсэнээр АДТ-ээс 12.9 хувиар илүү болсон.<br>Мөн Сангийн яаманд 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хүргүүлэхтэй холбоотой халамжийн чиглэлээр дараах тооцоо, судалгаа, төсвийн саналыг бэлтгэж салбарын төсвийн төсөлд тусгуулав.<br>✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг 6%<br>✓ Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 60000 төгрөгийг 120000 төгрөгт хүргэх /улиралд нэг удаа олгож байгаа, 2012 оноос хойш нэмээгүй/<br>✓ Хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүнг 2 дахин нэмэгдүүлэхээр нийт 61.2 тэрбум төгрөг халамжийн санд нэмж тусгуулахаар төсвийн тооцоолол, саналыг бэлтгэлээ.<br>✓ Нийгмийн халамжийн салбарын өнөөгийн байдал, 2020-2023 оны хүрсэн түвшин цаашдын зорилтын талаар танилцуулга, халамжийн сангийн төсвийг нэмэгдүүлэх хөтөлбөр бүрд тайлбар, мэдээлэл бэлтгэв.<br>✓ Мөн ирэх онд тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, мөнгөн дүнг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улирал бүр олгох мөнгөн тусламж, хүнсний эрхийн хэмжээг нэмэгдүүлэх бодлогын саналыг боловсруулав.<br>✓ Алдар цолтон ахмад настанд сар бүр олгож байгаа нэмэгдлийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх төсвийн тооцоо, танилцуулга УИХ-ын тогтоолын төслийн хамт боловсруулав.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан Үр дүнд суурилсан 2024 оны төсвийн саналд нийгмийн халамжийн хөтөлбөрийн үр дүн, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг боловсруулж тусгасан. | |
| 6. | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Хүргүүлсэн санал, тооцоо, судалгааны тоо | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлээгүй байна | ЭЗХЯ-нд санал хүргүүлж, саналыг тусгуулсан байна. | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын санал, холбогдох тооцоо судалгааг боловсруулан 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мөн дээрх саналыг ЗГХЭГ МУ-ын Шадар сайд , Сангийн Яам, СХЗГ,БХБСайд, БХЯ ЭЗХЯ Азийн хөгжлийн банк гэх зэрэг 26 байгууллагад хүргүүлж ажилласан. | 100 |
| 7. | Ядуурлыг бууруулах талаар салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулна. | Үйл ажиллагааны зардал | Санал 2-с доошгүй | Шинээр хийх ажил | Ядуурлыг бууруулах чиглэлээр салбар дундын уялдааг хангах талаар холбогдох яамдад санал боловсруулж, хүргүүлсэн байна. | Хүн амын ядуурлын талаар хийсэн судалгааны үр дүн, салбарын статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, “Ядуурлын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал”-ыг бэлтгэн, яамны дотоод нэгжүүдэд танилцуулж, тэдний саналыг тусгав.<br>ҮСХ-оос хийсэн “Ядуурлын дүр төрх-2020” судалгааны болон Өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас өрхийн амьжиргаа тогтоох судалгаанд хамрагдсан өрх, иргэдийн талаарх өгөгдлийг ашиглан нарийвчилсан үзүүлэлтийг боловсрууллаа. Үзүүлэлтийн дагуу танилцуулга /PPT/ бэлтгэж, ХНХ-ын сайдад танилцуулахад бэлэн болгов.<br>Мөн Ядуурлыг бууруулах асуудлаарх салбар дундын зохицуулалтыг сайжруулах зорилгоор Ядуурлыг бууруулах үндэсний зөвлөл байгуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамны дотоод нэгжүүдээс санал авч, саналыг төсөлд тусгаад байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ядуурлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах саналыг НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн банк, Дэлхийн зөн олон улсын байгууллагуудад хүргүүлсэн.<br>Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Ядуурлыг бууруулах асуудлаарх санаачилгыг нэгтгэн төр, төрийн бус олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр дүн, туршлага, сургамжийн талаар мэдээлэл солилцох хэлэлцүүлгийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 20 гаруй байгууллагын төлөөлөл 50 гаруй хүн оролцсон.<br>Энэхүү уулзалтын үр дүнд Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааны сүлжээний эхний төслийг эхлүүлэхээр хэлэлцэн тохиролцлоо.<br>Азийн хөгжлийн банкны “Цар тахлын үед нийгмийн хамгааллын хариу арга хэмжээ авах-2” төслийн хүрээнд зөвлөх байгууллага сонгон шалгаруулж Ядуурлыг бууруулах асуудлаарх үндэсний форумыг зохион байгуулахаар ажиллаж байна | |
| 8. | Монгол Улсын Засгийн газраас бусад улстай хийх нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төслийг боловсруулах, хэлэлцээ зохион байгуулах, удирдлагын тохиролцоог эцэслэнэ. | Үйл ажиллагааны зардал | Боловсруулсан баримт бичгийн тоо<br><br>Нийгмийн хамгааллын чиглэлээр хамтран ажилласан улс орны тоо | Хэлэлцээрийн төслийг айлын талтай тохирох чиглэлээр хамтран ажилласан. | Удирдлагын тохиролцоонд гарын үсэг зурахтай холбоотой бэлтгэл ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хангаж ажилласан байна. | Монгол Улсын Засгийн газраас бусад улстай хийх нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төслийг боловсруулах, хэлэлцээ зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилт:<br>• Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд 2006 онд байгуулсан хэлэлцээрийг шинэчлэх, хэлэлцээрийн төслийг боловсруулах шинжээчдийн багийг хоёр талаас ойрын хугацаанд томилж, хэлэлцээг эхлүүлэх саналыг БНСУ-ын талд 2023 оны 03 дугаар сарын 02/697 тоот албан бичгээр Гадаад харилцааны яамаар уламжлуулан хүргүүлсэн. Солонгосын талаас холбогдох хэлэлцээрийг шинэчлэх асуудлыг 2023 оны сүүлийн хагаст эхлүүлэх саналыг ирүүлсэн тул хэлэлцээрийг шинэчлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.<br>• “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех улс хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх удирдлагын тохиролцооны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төслийн боловсруулан 2 улс зөвшилцөж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Чех Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд нар 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурснаар хэлэлцээр 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах хүрээнд БНЧехУ-ийн Нийгмийн хамгааллын газартай хамтарсан уулзалтыг 2023 оны 8, 10 дугаар сард зохион байгуулж, 2 улсын иргэдийн тэтгэвэр тогтооход шаардлагатай мэдээлэл солилцох 12 маягтыг эцэслэн тохирсон.<br>• Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хооронд нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах асуудлаар санал солилцох анхны уулзалтыг Австри Улсын Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, сувилал, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах яам, БНАУ-д суугаа Монгол Улсын элчин сайдын яамтай хамтран 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан. Уулзалтаар хоёр талын нийгмийн даатгалын тогтолцооны мэдээлэл, нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах нь нэг талаас хоёр улсад харилцан ажиллаж байгаа иргэдэд туслах, нөгөө талаас хоёр улсад давхар нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байх, аль ч улсын нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдахгүй байхаас сэргийлэх ач холбогдолтой талаар санал нэгдэж, хэлэлцээр байгуулах асуудлыг Австри талаас улс төрийн дэмжлэг авах, холбогдох байгууллагад уламжлахад дэмжигдэж 2 улс хэлэлцээрийн төсөл боловсруулах шинжээчдийн уулзалтыг 2023 оны 12 дугаар сард эхлүүлэхээр тохиролцсон болно.<br>• Энэ онд Монгол Улс Засгийн газар болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг хэлэлцэх шинжээчдийн багийн 12, 13, 14 дэх шатны хэлэлцээг хийсэн. Хамгийн сүүлд 14 дэх удаагийн хэлэлцээг Астана хотод 2023 оны 11 дүгээр сарын 28, 29-ний өдөр зохион байгуулав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Шинжээчдийн багийн уулзалтаар 13 дахь шатны уулзалтаар тохирсон заалтуудыг эцэслэх, эрх бүхий байгууллага хоорондын харилцах маягтуудыг эцэслэн боловсруулсан. Ингээд хэлэлцээрийн төсөл, маягтын төслийг шинжээчдийн түвшинд эцэслэн тохирсон болно.<br>• “Монгол Улс, Оросын Холбооны Улс хооронд Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийн 4 дэх шатны хэлэлцээг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан. Монгол-Оросын шинжээчдийн 4 дэх шатны уулзалтаар хэлэлцээрийн төслийг ажлын хэсгийн түвшинд эцэслэн тохиролцсон болно. | |
| ***1.1.2. “Цахим засаглал үндэсний хөтөлбөр” (E-MONGOLIA)-ийн хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын бүх үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах, салбарт цахим засаглалыг бүрэн нэвтрүүлэх, мэдээллийн технологийг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээллийн зохистой ашиглалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах*** | | | | | | | |
| 9. | Салбарын бүртгэл, статистикийн мэдээ, тайлангийн маягтуудын нэгдсэн стандарт загварыг мөрдүүлж, батлуулна. | Үйл ажиллагааны зардал | Боловсруулж, батлуулсан маягтын тоо -3 | 2022 онд:<br>-Залуучуудын статистикийн маягт, -Нийгмийн халамжийн статситикийн маягт батлуулсан. | Нийгмийн даатгалын статистикийн маягт, Хүүхдийн статистикийн маягт, Гэр бүлийн статистикийн маягтыг ҮСХ-ны Арга зүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлөөр зөвшөөрүүлж, батлуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 02 дугаар сарын А/25 тоот тушаалаар Хүүхдийн эрх, хамгааллын мэдээллийн санг сайжруулах, шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд “Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал түүнийг нөхөх заавар”-ыг Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран боловсруулж Үндэсний статистикийн хорооны Арга зүйн байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж, саналыг тусган тус хорооны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар 2023 оны 12 дугаар сарын 01-ний 01/3130 дугаар албан тоотоор хүргүүлсэн. Нийгмийн халамжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт халамжийн сангийн мэдээ, тайлангийн маягтын загварыг Санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар хуульчилсны дагуу “Нийгмийн халамжийн захиргааны статистикийн маягт, түүнийг нөхөх заавар”-ыг шинэчлэн батлах тухай хамтарсан тушаалыг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны 01/3025 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Нийгмийн даатгалын багц хууль батлагдан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эхлэхтэй холбогдуулан холбогдох дүрэм, журмуудыг шинэчилж байна. Үүнтэй холбогдуулан “Нийгмийн даатгалын салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, мэдээлэл цуглуулах маягт, маягтыг нөхөх заавар”-ыг шинэчлэн боловсруулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон түүний удирдамжийг ХНХС-ын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны А/165 дугаар тушаалаар батлуулав. | |
| 10. | Салбарын судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Судалгааны тоо | 2 судалгаа хийсэн. | 2 судалгаа хийгдсэн байна. | Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр нийгмийн халамж, нийгмийн даатгалын бодлогын дунд болон урт хугацааны үр нөлөөг төлөвлөх динамик загварын хөгжүүлэлтийг (программ хангамж) хийсэн.<br>Энэ ажлын үр дүнд цаашид ХНХЯ болон түүний харьяа байгууллагын ажилтнууд нийгмийн халамж, даатгалын тооцооллын загварчлалыг ашиглан бие даан бодлогын хувилбар тус бүр дээр үр нөлөөний тооцоолол хийж бодлого боловсруулах үйл ажиллагаандаа ашиглах боломжтой болж байна. Тус газраас нийгмийн халамж, нийгмийн даатгалын бодлогын дунд болон урт хугацааны үр нөлөөг төлөвлөх динамик загварыг ашиглан дараах тооцоо, судалгааг хийлээ.<br>• Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл боловсруулж батлуулахтай холбогдуулан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн тооцоолол судалгаа<br>• Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин сайжруулах, холбогдох баримт бичгийн тоо мэдээллийг шинэчилж Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцоог дахин боловсруулсан бөгөөд хууль тогтоомжийн тухай хуульд шинээр орсон хуулийн хэрэгжилтийн үнэлгээний судалгаа болон дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцооллыг боловсруулахад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран ажилласан.<br>• Цалинтай ээж хөтөлбөрийн тэтгэмжийг 1 удаа олгоход гарах зардлын судалгаа<br>• Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл боловсруулж батлуулахтай холбогдуулан нийгмийн халамжийн сангийн зарлагын хэтийн тооцоолол судалгааг хийж ажилласан. | |
| 11. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын СТАТИСТИК-ийн нэгдсэн платформын үйл ажиллагааг тогтворжуулна. | Үйл ажиллагааны зардал | Шинээр холбосон мэдээллийн сангийн болон мэдээллийн тоо | Нийгмийн даатгалын 4, Нийгмийн халамжийн 2 төрлийн 2018-2022 оны мэдээллийг оруулсан. | -Мэдээллийн сангуудыг шинээр холбосон байна.<br>-Өмнөх мэдээллүүдийг 2023 оны байдлаар шинэчилсэн байна. | Зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын сангаас үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг байршлаар болон нас, хүйс, олгосон мөнгөн дүнгээр 2023 оны 11 дүгээр сарын байдлаар mlsp.gov.mn/report/31 хаяг дээр байршуулж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээний ehalamj.mn систем болон хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем ejob.gov.mn-ийг холбож туршилтын дашбордын загваруудыг 2023 оны мэдээллүүдийг оруулсан. Мөн ehalamj.mn системийг өрхийн мэдээллийн сантай тулгаж халамж авч байгаа иргэний мэдээллийг өрхөөр гарах нөхцөлийг бүрдүүлээд байна. Цаашид tableau системээ шинэчлэх шаардлагатай байна. | 70 |
| 12. | Асрамж, халамжийн төвүүд болон тэдгээрээр үйлчлүүлсэн иргэдийн нэгдсэн мэдээллийн санг бий болгож хяналтыг сайжруулна. | Үйл ажиллагааны зардал | Гүйцэтгэгчийг шалгаруулсан байна.<br>Ажлын даалгавар боловсруулагдсан байна.<br>Хөгжүүлэлтийг эхлүүлсэн байна. | Ажлын ерөнхий даалгаварыг боловсруулан АХБ-нд албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу АХБ-ны холбогдох зөвлөхүүдтэй 3 удаагийн уулзалтыг хийсэн. Техникийн дэмжлэг үзүүлэх зөвлөхийн ажлын даалгаврыг АХБ-ны зөвлөхүүдтэй хамтран боловсруулсан. | Ажлын даалгавар боловсруулсан байна.<br>Системийн хөгжүүлэлтийн эхний шат эхэлсэн байна. | АХБ-нд асрамж, халамжийн төвүүд болон тэдгээрээр үйлчлүүлсэн иргэдийн нэгдсэн мэдээллийн санг бий болгоход дэмжлэг үзүүлэхийг хүссэн хүсэлтийг тавьснаар дээрх мэдээллийн санг бүрдүүлэх АХБ-ны буцалтгүй тусламжаар хийхээр болсон. Төслийн хүрээнд АХБ-наас томилогдсон дотоод зөвлөх П.Пүрэвбазар, гадаад зөвлөх Жош Ашиш нар ажлын даалгаврыг боловсруулсан.<br>Мөн АХБ-наас зөвлөхүүд 2023 оны 04-р сард 7 хоногийн хугацаатай Монгол улсад ажиллаж олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээний бүртгэлийн өнөөгийн байдалтай танилцан ажлын даалгавар болон ерөнхий процессын зураглалыг гаргах, аймаг, дүүргийн анхан шатны хэрэглэгчдээс санал авах уулзалтуудыг зохион байгуулсан. Дээрх уулзалтын үер болон зөвлөхүүдийг ажиллах хугацаанд нийгмийн халамжийн мэдээллийн системүүдийн талаарх мэдээлэл болон тус системийг хөгжүүлэх эхний товч даалгаврын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаарх мэдээллийг зөвлөхүүдэд өгч ажиллаа. Зөвлөхүүдийн зүгээс системийг хөгжүүлэх ажлын даалгаврыг 9-р сард боловсруулан ирүүлсэн. АХБ-наас тус систем дээр нэмэлт зөвлөх ажиллуулж нийгмийн хамгааллын мэдээллийн системүүдийн судалгааг хийх шаардлагатай гэж үзэн дотоод зөвлөх н.Уянга ажиллаж байгаа бөгөөд тус зөвлөхтэй уулзаж нийгмийн хамгааллын салбарын мэдээллийн системийн талаарх танилцуулгыг хийж шинээр хөгжүүлэх системийн эхний шат 12 сард багтаан эхэлнэ. | |
| 13. | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, E-job платформыг ашиглалтад бүрэн нэвтрүүлнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.6 /* | Дэлхийн банкны ХЭДТөсөл- 300.0 сая төг. | -Мэдээллийн сан-1<br>-Системээс үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | Онлайн портал, job matching буюу ажилд зуучлах үйлчилгээг нэвтрүүлсэн. | -Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг ашиглалтад бүрэн нэвтрүүлсэн байна.<br>-Үйл ажиллагаа тогтворжсон байна<br>-Гар утсаны програмууд хэрэглээнд нэвтэрсэн байна. | Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх зорилгоор Хиймэл оюун ухаанд суурилсан Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлж ашиглалтад оруулсан. “Ejob” платформ нь Онлайн портал, мобайл аппликэйшн, хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/ гэсэн 3 дэд систем 13 модулиас бүрдэнэ.<br>Системийн хүрээнд хэрэглэгч өөрийн анкет буюу CV-г байгууллагуудад илгээх, амьдарч буй байршлаас хамааран 1-10 км радиусын хүрээнд ажил хайх, байршлаас үл хамааран ажлын байртай болох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах боломжуудыг бүрдүүлсэн. Тухайлбал, гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэн монголд байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай системээр дамжуулан холбогдож, гэрээт ажил, үүрэг гүйцэтгэх, мөн эх орондоо эргэж ирээд ажиллах боломжийг бүрдүүлсэн.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/204 дүгээр тушаалын дагуу холбогдох ажлыг хийж, “Ejob” платформын үйл явцын талаарх тайлан мэдээг 10 хоног тутам авч нэгтгэн үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулж байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар “Ejob” платформд:<br>1. Бүртгэлтэй ажлын байрны тоо – 70293,<br>2. Ажил хайгчийн тоо – 87466, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Ажил олгогчийн тоо – 12063,<br>4. Ажилд зуучлагдсан иргэдийн тоо – 19962,<br>5. Мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо - 29065 болсон байна.<br>Системийн нэвтрүүлэлттэй холбоотойгоор иргэд олон нийтэд таниулах ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээллийн цагаар нийт 64 албан хаагчдад, “Хүртээмжтэй хөдөлмөрийн өдөрлөг”, “Ажил олгогч байгууллагууд, хүний нөөцийн захирлуудтай хийсэн өглөөний уулзалт”, “Career expo-Залуучуудын өдөрлөг”, “Төрийн бус байгууллагуудын холбоо” зэрэг томоохон арга хэмжээ уулзалтад Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформын танилцуулга мэдээллийг хийж, 25113 ажил хайгч иргэн болон 2405 ажил олгогч байгууллага руу танилцуулга, мобайл аппликейшны холбоосыг масс мессэжээр илгээсэн.<br>“Ejob” платформын баталгаат 18 сарын хугацаанд системийг сайжруулахад ХНХЯ, ХХҮЕГ болон гүйцэтгэгч байгууллага болох АйТиЗон ХХК-д мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилго бүхий мэдээллийн технологийн ахлах зөвлөх сонгон шалгаруулан ажиллаж байна.<br>Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/176 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа болон бусад арга хэмжээг цахимжуулах талаар санал боловсруулж танилцуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн 6 удаагийн хурлаар нэгдсэн санал, дүгнэлт гаргаж холбогдох газар, хэлтэст чиглэл өгч биелэлтийг хангуулан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулсан.<br>Түүнчлэн цагийн ажил зуучлалын үйлчилгээг цахимжуулах хүрээнд “Ejob” платформоор дамжуулах, төрийн байгууллагаас гаргасан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн цахим үйлчилгээ сурталчилж, гол функц болгон хөгжүүлэлтийг яаралтай хийж сайжруулахаар томоохон аж ахуйн нэгж байгууллага болон холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулан ажлын хэсгийг байгуулан санал боловсруулахаар ажиллаж байна.<br>2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээний тайлангийн 36 хөгжүүлэлт хийхээс 20 арга хэмжээний хөгжүүлэлтийг систем хөгжүүлэгч байгууллага хийж хүлээлгэж өгсөн ба үлдсэн 16 арга хэмжээг ондоо багтаан дуусгаж ашиглалтад оруулахаар бэлтгэл ханган ажиллаж байна. | |
| 14. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн статистик мэдээллийн нэгдсэн санг хүлээн авч, ашиглалтад оруулна.<br><br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.8, МУХТЖҮЧ 2021-2025 2.3.4/* | JICA ХБХЭМБНХ-ын үйлчилгээг сайжруулах 2 дахь шатны төслийн санхүүжилт | -Програм хангамж-1;<br>-Програмд бүртгүүлсэн хүүхдийн тоо;<br>-Мэдээллийн санг ашиглах журам 1;<br>-Сургалт -1. | Системийн шинжилгээг хийж, мэдээллийн сангийн програм хангамжийг эхний хувилбарыг хөгжүүлсэн. | -Програм хангамжийг нэвтрүүлсэн байна<br>-Мэдээллийн санг бүрдүүлэх ажил эхэлсэн байна. | Зорилтын хүрээнд хөгжүүлэгч байгууллагаас программын эхний хувилбарыг гаргасантай холбогдуулан системийг Үндэсний дата төв дээр байршуулах ажлыг хамтран зохион байгуулсан бөгөөд системийг cwd.mlsp.gov.mn хаяг дээр байршуулаад байна. Системийн хэрэглэгчид болох салбар комиссын холбогдох албан тушаалтнуудаас санал авах болон эхний шатны 2 удаагийн сургалтыг байгуулсан. Салбар комиссын нарийн бичиг болон гишүүдээс сургалтын үер системд өөрчлөлт оруулахаар гаргасан санал болон системийг ХУР системтэй холбох, 21 аймаг 9 дүүргийн салбар комиссын гишүүд болон нарийн бичгийн дарга нарт сургалт хийх ажил хүлээгдэж байна. | 50 |
| 15. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн санг бүрдүүлэх үйл ажиллагааг шат дараатай авч хэрэгжүүлнэ.<br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.8, МУХТЖҮЧ 2021-2025 2.3.4/* | АХБ-ны төслийн санхжүүжилт 160.7 сая төг. | Мэдээллийн сангийн ажлын даалгавар боловсруулагд сан байна. | Аргачлал, бүртгэлийн маягт боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Бүртгэлийн маягт болон аргачлалыг боловсруулж байна. | Мэдээллийн сангийн загвар бий болсон байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн санг бүрдүүлэх системийг хөгжүүлэх ажлын ерөнхий даалгаврыг боловсруулсан.<br>ХАХБХЗГ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийн маягт, аргачлал боловсруулах ажил хүлээгдэж байна.<br>Маягт, аргачлал батлагдсан дараа ажлын даалгаврын хүрээнд системийн шинжилгээ хийх, цаашлаад хөгжүүлэх ажлууд хийгдэнэ. | 70 |
| 16. | Нийгмийн даатгалын үйлчилгээг үргэлжлүүлэн үе шаттайгаар цахимжуулна. | Үйл ажиллагааны зардал | Үйлчилгээний тоо-3 | Нийгмийн даатгалын 24 төрлийн үйлчилгээг цахимжуулсан. | Нийгмийн даатгалын цахимжуулсан үйлчилгээний тоо нэмэгдэж ажил | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, И-Монгол академи хамтран “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт”-ыг e-Mongolia 3.0 системд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | */Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.3/* | | | | олгогч, даатгуулагч иргэдэд үзүүлэх үйлчилгээ чирэгдэлгүй, хялбар, шуурхай, хүнд сурталгүй болсон байна. | 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр холбосон. 103 мянган иргэн энэхүү үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн.<br>Нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээний 24 үйлчилгээг нь цахимжуулсан. E-Mongolia цахим системд 16 үйлчилгээг холбосон<br>e-Mongolia цахим системээс 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сар хүртэл 7.2 сая удаа нийгмийн даатгалын цахим үйлчилгээг авсан байна. | |
| 17. | Эмнэлгийн хуудсыг цахимаар олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.3/* | Үйл ажиллагааны зардал | Чиглэл, зөвлөмжийн тоо-2 | Эмнэлгийн хуудсыг 600 эмнэлэг цахимаар бичиж байна. | Цахим эмнэлгийн хуудас бичдэг эмнэлгийн тоо 900-д хүрсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас буюу листийг цахимаар олгох шийдвэрийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудын ашигладаг E-Health системд хөгжүүлэлт хийж цахим лист олгох нөхцлийг бүрдүүлсэн. Бүх шатлалын эмнэлэг болон өрх, сумын эмнэлгүүд, хувийн эмнэлгүүдээс нийт 1218 эмнэлэг эмнэлгийн хуудсыг цахимаар олгож байна. | 100 |
| 18. | Тэтгэврийн хувийн хэргийг үргэлжлүүлэн цахимжуулна. */Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.3/* | Үйл ажиллагааны зардал | Нийт хувийн хэргээс цахим хэлбэрт шилжүүлсэн хувийн хэргийн эзлэх хувь-10 хувь | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд нийт тэтгэвэр авагчдын 10%-ийн хувийн хэргийг цахим хэлбэрт шилжүүлсэн. | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын 10%-ийн хувийн хэргийг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, иргэд, тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар тогтоох, цахим хяналт, шалгалтыг сайжруулах, сумын төвөөс аймгийн төв рүү тэтгэврийн хувийн хэргийг шилжүүлэхгүй, зөөвөрлөх шаардлагагүй, нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэхээр баруун 8 аймгийн тэтгэврийн хувийн хэргийг 2022 оноос цахимжуулж эхэлсэн. 2023 оны 12 дугаар сарын байдлаар Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Ховд, Хөвсгөл, Увс аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нийтдээ 115,874 тэтгэврийн хувийн хэргээс 95 697 хувийн хэргийг цахимжуулж, цахимжилт 82.6 хувьтай байна. Үүнээс Увс, Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хувьд бүрэн цахимжуулж дууссан. | 100 |
| 19. | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн http://om.inspection.gov.mn системийн хөгжүүлэлтийг ашиглалтанд оруулна. | Улсын төсөв | Сайжруулж, хөгжүүлсэн систем-1 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн системийн хөгжүүлэлтийг | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн http://om.inspection.gov.mn | 2023 оны 3 дугаар улиралд багтаан туршилтын журмаар системийг ажиллуулж 12 сард багтаан хүлээж авахаар Системийн шинэчлэлд шаардлагатай 21,6 сая төгрөгийн санхүүжилтийг ХАБЭА-н Үндэсний хороогоор батлуулж, ҮОМШӨДС-аас санхүүжүүлэх урьдчилан | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хийсэн. | системийг сайжруулж, хөгжүүлэн, ашиглалтанд хүлээн авсан байна. | сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнд тусгуулсан. Шинэчилсэн системийн хөгжүүлэлтийг хийж байна. “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого”-ын статистикийн бүртгэлийн болон албан ёсны маягт, түүний нөхөх заавруудын шинэчлэлийн ажлын хэсэгт ажиллаж, маягт болон заавруудын төсөлд 2023 оны 01/3121 дугаартай албан бичгээр 16 санал хүргүүлсэн. ҮСХ-оор маягт батлагдсаны дараа Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн http://om.inspection.gov.mn системийг хүлээн авах болно. | |
| 20. | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэлийг сайжруулах зорилгоор “Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх, баталгаажуулах цахим бүртгэлийн систем” /om.inspectiongov.mn/-ийг хөгжүүлж, шилэн хяналтын системд холбон өргөжүүлж, улирал тутам дүн шинжилгээ хийнэ. | Улсын төсөв | Мэдээллийн систтемийг боловсронгуй болгох | 2020 онд Үйлдвэрлэлийн ослын хүндрэлийн коэффициентыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад барилгын салбарт 9 хүн нас барсан буюу 25.7 хувийг, уул уурхай 6 буюу 17.2 хувь, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалах алба 5 буюу 14.3 хувь байсан. | ҮОМШӨ-ийг бүртгэж, мэдээлэх системийг улам боловсронгуй болгох замаар хөдөлмөрийн хяналтын байцаагчид ослын мэдээллийг үүрэн төхөөрөмж ашиглах зэргээр онлайнаар бүртгэх, мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн байна | Үйлдвэрлэлийн ослын цахим бүртгэлийн системийг шинэчлэн хөгжүүлж төрийн цахим мэлээлэл солилцох системд холбох ажлын гэрээг “Бодь электроникс” ХХК-тай 2021 оны 12 дугаар сард /№202111014 тоот гэрээ/ байгуулан хамтран ажиллаж байна. Энэхүү гэрээт ажлын хүрээнд бүртгэлийн системийн шинэчлэл, гар утасны апп хөгжүүлэлтийг гүйцэтгэгч байгууллагын зүгээс хийж гүйцэтгэн, ХНХЯ-нд хүлээлгэж өгөхөөр 2023.12.04-ны өдрийн 23/0819 тоот албан бичгийг ирүүлсэн. ҮОМШӨДС-аас холбогдох зардлыг шилжүүлсэнээр 2 тал ажил хүлээлцэх актыг эцэслэж, шинэчилсэн системийг хүлээн авна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн систем /om.inspectiongov.mn/-ээс улирал бүр мэдээллийг татаж Үндэсний статистикийн хороо болон ХНХЯ-ны НДБХЗГ Б.Батжаргал/-д хүргүүлж ажиллалаа. | 70 |
| ***1.1.3.Салбарын судалгаа, шинжилгээний чадавхыг сайжруулах, статистик мэдээллийг эрхлэн хөтлөх*** | | | | | | | |
| 21. | Нийгмийн даатгалын сангуудын тогтвортой байдлыг хангаж байгаа эсэх талаар судалгаа хийнэ. | Үйл ажиллагааны зардал | Мөнгөн урсгалын судалгаа-12 | Сар бүр нийгмийн даатгалын сангийн мөнгөн урсгалын тооцоо судалгааг хийж удирдлагуудад танилцуулдаг бөгөөд 2022 оны | Сар бүр нийгмийн даатгалын сангийн мөнгөн урсгалын тооцоо судалгаа хийж, нийгмийн даатгалын хөрөнгийн | Нийгмийн даатгалын сангийн мөнгөн урсгалын судалгааг нийгмийн даатгалын сан тус бүрээр хийж удирдлагуудад танилцуулсан. Энэхүү судалгааны зорилго нь нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төлөвлөгөөний гүйцэтгэлийг сар бүр хийж, нийгмийн даатгалын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, санал дүгнэлт гаргаж мэдээллээр хангах ач | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдлаар нийт 12 судалгаа хийгдсэн. | зарцуулалтад хяналт тавьж, санал дүгнэлт боловсруулж удирдлагуудад танилцуулан, мэдээллээр хангасан байна. | холбогдолтой юм. | |
| **1.2. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, САЛБАРУУДЫН ЭРЭЛТЭД НИЙЦСЭН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВ, ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОЖ ХӨГЖҮҮЛЭХ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.2-ЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***1.2.1. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, стратеги хөтөлбөрийг төлөвлөх, хууль тогтоомж, бодлого, стратеги, загвах хөтөлбөр, үйл ажиллагааны төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах*** | | | | | | | |
| 22. | ”Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. */МУЗГҮАХ 2.5.4/* | НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр 60.0 сая төг. | Хуулийн төсөл-1 | Хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Үзэл баримтлалын төсөл боловсруулсан. | Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн бүрдүүлбэрийг хангаан Засгийн газарт өргөн мэдүүлсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлалыг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудтай уялдуулан шинэчлэх ажлын хүрээнд уг хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран баталхаар 2023 оны 12 сарын 01-ний өдрийн 01/3132 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Мөн хуулийн төсөл, зардлын тооцоог боловсруулан Засгийн газарт өргөн мэдүүлэхээр бэлэн боллоо.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зохицуулалтыг тусгаж байна. Үүнд:<br>- ажил олгогчид санхүүгийн дэмжлэг, урамшуулал олгохоос гадна ажлын байрыг хадгалах, хамгаалах, ялангуяа эдийн засгийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас бий болдог хямралын үед хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг Ажилгүйдлийн даатгалын тухай болон бусад хууль тогтоомжтой уялдуулан тусгах,<br>- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгохоор хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн ойрын, дунд, хэтийн хугацааны судалгааг холбогдох аргачлалын дагуу хийж, дүн, мэдээг иргэдэд түгээх замаар мэргэжил сонголтыг зөв, оновчтой хийх боломжийг дэмжих зохицуулалтыг тусгах, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - хөгжлийн бэрхшээлтэй хүн, залуучууд, эмэгтэйчүүд болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зохицуулалт хийх, дэмжлэгийн төрөл, хэлбэрийг хуульд нарийвчлан тусгах; бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хүрээнд нэр томьёог боловсронгуй болгож, холбогдох дэмжлэг, урамшууллыг оновчтой, уялдаатай, шаталсан байдлаар тодорхойлох, бизнес инкубацын үйлчилгээг орчин үеийн чиг хандлагад нийцүүлж үзүүлэх зэрэг дэмжлэг, үйл ажиллагааг хуульд тусгах зэргээр боловсруулж байна. | |
| 23. | 2023 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг орон нутгийн онцлогт тохируулан шинэчлэн батлуулна. */Алсын хараа-2050 2.6.3, 3.3.1, МУЗГҮАХ 2.5.9, МУХТЖҮЧ 2021-2025 2.6.2, 3.3.1/* | Үйл ажиллагааны зардал | ХЭҮЗ-ийн тогтоол-1 ХНХ-ын Сайдын тушаал-1 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрийг 2022-2023 онд хэрэгжүүлэхээр баталсан. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2023-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг орон нутгийн онцлогт нийцүүлэн батлуулсан байна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/ хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг дэмжих, Засгийн газар болон хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 үйл ажиллагааны 34 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугаар тоот тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлан хэрэгжүүлж байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээний хувийг ХХҮЕГ, ХБХХЕГ, ХНХСҮСИ-д тус тус хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлагнаж ажиллахыг албан тоотоор мэдэгдсэн болно. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар, хэлтсийн 160 албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг Европын холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих” төсөлтэй хамтран 2023 оны 4 дүгээр сард зохион байгуулсан. | |
| 24. | Албан бус салбараас албан салбарт шилжихтэй холбоотой авах арга хэмжээний санал боловсруулна.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.4, МУХТЖҮЧ 2021-2025 2.6.4/* | ОУХБ<br>50.0 сая төг. | Арга хэмжээ- 3<br>Зөвлөмж - 1 | ОУХБ-тай хамтран Албан бус хөдөлмөр эрхлэлтийн суурь судалгааг хийсэн. Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 7.3 хувьд нь ажилтан, 42.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 50.5 хувийг ажил олгогч бүрдүүлж байна. Албан бус салбарын ажилтанд 26-45 насныхан зонхилж байгаа бол, ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд 36-55 насныхан зонхилох хандлагатай байна. | Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар авах арга хэмжээний төсөл боловсруулж, яамны удирдлагуудад танилцуулсан байна. | Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тодорхой хүрээг хамарч буй одоо ашиглагдаж буй системүүд болон тэдгээрийн зарим модулиудыг албан бус хөдөлмөрийг албажуулахад ашиглах боломжтой байна. Одоогийн байдлаар албан бус хөдөлмөрийг албажуулах асуудал нь аль ч системийн хувьд үндсэн зорилтод хамаарахгүй байгаа бөгөөд тухайн системүүдээс албан бус хөдөлмөр эрхлэлтийн зохистой мэдээллийн сан үүсгэхэд хүндрэлтэй байна. Иймд албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэлийг нэг дор цуглуулах, боловсруулах боломжийг бий болгосон шийдэл боловсруулах, оролцогч талуудын үр дүнтэй хамтын ажиллагаа, манлайллыг бий болгох чиглэлээр ОУХБ-тай хамтран 300 мянган долларын төсөл хэрэгжүүлэхээр төслийн нэгжийг 2023 оны 8 дугаар сард байгуулсан. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албажуулах талаар төрийн бодлого нь Алсын хараа-2050, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон бусад баримт бичгүүдэд дараах байдлаар тусгагдсан.<br>Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын 8.3, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.1, 3.3 дахь зорилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.5.6 дахь заалтуудын хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлж, албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэх арга туршлагыг цахим систем болон цахим | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээнүүдээр дэмжих, хэрэгцээ шаардлагад үндэслэн цахимаар албажуулах саналыг боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг ХНХ-ын сайдын 2023 оны 10 дугаар сард А/150 дугаар тушаалаар байгуулсан байгуулсан. Ажлын хэсэг 2023.12.05-ны өдөр анхны хурлаа зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах санал авч бодлогын баримт бичиг боловсруулахаар болсон. | |
| **1.3. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ХЭТИЙН ТӨЛВИЙГ ХАРГАЛЗСАН, ХЭРЭГЦЭЭНД НИЙЦСЭН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ЗАМААР ХҮН АМЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.3-ЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***1.3.1. Хүн амын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулах, нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох;*** | | | | | | | |
| 25. | Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. */Алсын хараа-2050 3.1.4, ТТШТББ /2015-2030/ 3.2.17, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.1, МУЗГҮАХ 2020-2024 2.5.1/* | Үйл ажиллагааны зардал | Зохион байгуулсан хэлэлцүүлэг, танилцуулга, уулзалтын тоо-3 | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулсан. | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулж, саналыг тусгасан байна. | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 1 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Улмаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан 10 аймаг, нийслэлд ахмадууд, залуучууд, сайн дураар даатгуулагчид, үйлдвэрчний эвлэлийн шат шатны байгууллага, ажил олгочдын төлөөлөл, худалдаа аж үйлдвэрийн танхим, хуульчдын холбоо зэрэг газруудаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэн, иргэд олон нийтээс санал авах арга хэмжээг зохион байгуулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин баталсан. Энэ дагуу Ажлын дэд хэсгийн гишүүд хуулийн төслийн санал дүгнэлт боловсруулан ажиллаж байна. Улсын Их Хурлын D parliament цахим хуудсанд хандан 21 дэмжсэн санал, зарим холбогдох хуулийн заалтуудад өөрчлөн найруулах 22 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | саналыг тус тус ирүүлсэн бөгөөд 17,560 дэмжсэн санал өгсөн байна. УИХ-ын 2023 оны намрын чуулганаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийгмийн бодлогын байнгын хорооны дэд ажлын хэсэг 12 удаа хуралдсан. Мөн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг хэлэлцсэн. | |
| 26. | Хуримтлалын нэгдсэн санг бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ. */Алсын хараа-2050 3.1.6, 3.1.7, ТТШТББ /2015-2030/ 3.3.5,МУХТЖҮЧ 2021-2025 3.1.1,МУЗГҮАХ 2.5.3/* | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр 30.0 сая төгрөг | Боловсруулсан хуулийн төсөл-1<br>Зөвлөх үйлчилгээний тайлан-1 | Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна. | Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/64 дүгээр тушаалаар Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж хуулийн төслийг боловсруулах чиглэлээр ажлын хэсгийн хурал 3 удаа, хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулсан.<br>Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах, хууль эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2023 оны 06 сарын 07-ны өдөр байгуулсан. Тус гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан.<br>Монгол улсын онцлогт нийцсэн Хуримтлалын тогтолцоог бий болгох Хуримтлалын нэгдсэн сангийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл, хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдүүлбэрийн хамт боловсруулсан. Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Хуримтлалын нэгдсэн сангийн орлого, зарлагын хэтийн төлөвийг тооцох актуар тооцооллыг хийж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27. | Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн, саналын хувилбар боловсруулна. | Үйл ажиллагааны зардал | Санал авсан байгууллагын тоо-1 | Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоол. | Тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн, саналын хувилбар боловсруулж холбогдох байгууллагаас санал авсан байна. | Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх ажлын хүрээнд дундаж цалин болон хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтөд үндэслэн 2022 он суурьтай тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн хувилбарыг боловсруулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолоор баталсан. Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 07/1826 тоот албан бичиг хүргүүлж, хэрэгжилтийг зохицуулан ажилласан.<br>Энэ арга хэмжээний хүрээнд нийт 485.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, дундаж тэтгэвэр 683.2 мянган төгрөгт хүрсэн. | 100 |
| **1.4.НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.4-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***1.4.Нийгмийн халамжийн тогтолцоог боловсронгуй болгох, хууль тогтоомж бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ядуурлыг бууруулах салбар дундын бодлогын уялдааг зохицуулах;*** | | | | | | | |
| 28. | Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох журмыг шинэчлэн боловсруулна.<br>*/МУХТЖҮЧ 3.1.4/* | Үйл ажиллагааны зардал | ЗГ-ын тогтоолын төсөл-1 | 2017 оны Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 197 дугаар тогтоол | Тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1 дүгээр , 3 дугаар, 5 дугаар хавсралтаар баталсан журмуудыг тус тус шинэчлэн боловсруулж, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1514 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авч, саналыг тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр бэлэн болсон.<br>Гэвч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хийсэн Процессын дахин инженерчлэлийн хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв, Имонголиатай хамтран “Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах, цахимжуулах төлөвлөгөө”-г 2023 оны 11 дүгээр сард Засгийн газрын хуралдаанд танилцуулан батлуулсанаар нийгмийн халамжийн цахим үйлчилгээнд хөгжүүлэлт хийх шаардлагатай болсонтой холбогдуулан журам батлуулах хугацааг хойшлуулсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29. | Нийгмийн халамжийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох журмыг шинэчлэн боловсруулна. *ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.6/* | Үйл ажиллагааны зардал | ЗГ-ын тогтоолын төсөл-1 | 2021 оны Журам шинэчлэн батлах тухай 362 дугаар тогтоол | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмыг шинэчлэн боловсруулсан байна. | 2021 оны Засгийн газрын 362 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ыг шинэчлэн батлуулахаар тогтоолын төсөл боловсруулж, санал авахаар 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1515 дугаар албан бичгээр яамдад хүргүүлэн саналыг авч нэгтгэв.<br>Гэвч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хийсэн Процессын дахин инженэрчлэлийн хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв, Имонголиатай хамтран “Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах, цахимжуулах төлөвлөгөө”-г 2023 оны 11 дүгээр сард Засгийн газрын хуралдаанд танилцуулан батлуулсанаар нийгмийн халамжийн цахим үйлчилгээнд хөгжүүлэлт хийх болсонтой холбогдуулан журам батлуулах хугацааг хойшлуулсан. | 90 |
| **1.5.ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ, БОДЛОГО, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨРИЙН ХУВИЛБАР, ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.5-ЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***1.5.1.Хөдөлмөрийн харилцааны бодлого, стратеги, хөтөлбөрийг төлөвлөх, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, бодлогын удирдамжаар хангах, хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт харилцааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх;*** | | | | | | | |
| 30. | Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. */УИХ-ын 2021 оны 57 дугаар тогтоол 1.1/* | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Хуулийн төсөл-1 | Хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. | Хуулийн үзэл баримтлалыг батлуулж, төслийг боловсруулсан байна. | Хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/182 дугаар тушаалаар байгуулсан. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг ОУХБ-ын дэмжлэгтэй хийж, Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, хөдөлмөрийн хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон түншлэгч талуудыг хамруулан судалгааны тайланг 2023 оны 2 дугаар сард хэлэлцүүлсэн. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг шинэчлэхтэй уялдуулан 53 улсын эвлэлдэн нэгдэх эрхийн зохицуулалт, жишээг судалсан. Түүний үндсэн дээр үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуулийг шинэчлэх чиглэл, саналыг боловсруулсан. МҮЭХ-ны зүгээс хуулийн шинэчлэлийн ажлыг хойшлуулах саналыг удаа дараа ирүүлж байгаа тул түр хойшлоод байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 31. | 2021-2022 оны Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулж, биелэлтийг гаргаж Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлсэн байна. | Үйл ажиллагааны зардал | Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийн хувь | Улсын хэлэлцээрийн хэрэгжилт 80 хувь | Улсын хэлэлцээр 90 хувьтай хэрэгжсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022 оны улсын хэлэлцээрийн биелэлтийг гурван талт ажлын хэсгээр гарган, Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж, талуудад хүргүүлсэн. Хэлэлцээрийн хэрэгжилт 87 хувьтай гэж дүгнэгдсэн. Хэрэгжилт дутуу байсан арга хэмжээний биелэлтийг хангах арга хэмжээг талуудтай хамтран зохион байгуулж, 2023-2025 оны улсын хэлэлцээрт Хөдөлмөрийн хуульд заасан зохицуулалтын дагуу арга хэмжээг тусгахаар тохирсон. 2021-2022 оны Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулсан. | 100 |
| 32. | 2023-2024 оны Улсын хэлэлцээрийг байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талтын саналыг тусгасан Улсын хэлэлцээр-1 | 2021-2022 оны Улсын хэлэлцээрийн төсөл | 2023-2024 оны Улсын хэлэлцээр батлагдсан байна. | Ажлын байрыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжийг дэмжих, хөдөлмөрлөх эрхийн баталгааг хангах, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, нийгмийн түншлэлийг дэмжих чиглэлийг баримтлал болгон Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны Улсын хэлэлцээрийг 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдөр байгууллаа. | 100 |
| 33. | Салбарын хэлэлцээрүүдийг хууль тогтоомжийн дагуу бүртгэн, мэдээллийн санг бүрдүүлнэ. | Бусад эх үүсвэр 50.0 сая төг. | Хянаж бүртгэсэн салбарын хэлэлцээрийн тоо-5 | -Салбарын хэлэлцээрийн тоо-3+2<br>-Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх программ хийгдээгүй байна. | Салбарын хэлэлцээрүүдийг хянан бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд оруулсан байна. | Салбарын 12 хэлэлцээрийг хууль тогтоомжийн дагуу хянан бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Тухайлбал боловсрол, эрүүл мэнд, иргэний нисэх, соёл, тээвэр, уул уурхай, олборлолт, барилга зэрэг. | 100 |
| ***1.5.2. Төрийн албаны цалин хөлсний тогтолцоо, ангилал, зэрэглэлийг сайжруулах, нийгмийн баталгааны асуудлаар хууль тогтоомж шийдвэрийн төслийн санал боловсруулах, уялдуулан зохицуулах;*** */АХ-2050 2.6.5, МУХТЖҮЧ-2.6.5, ЗГҮАХ 2.5.5/* | | | | | | | |
| 34. | Төрийн захиргааны болон тусгай алба хаагчдын цалингийн 5 шатлалыг 1 болгож цалингийн сүлжээг шинэчлэн тогтооно. */АХ-2050 2.6.5/* | Улсын төсөв: 120.0 тэрбум төг. | Засгийн газрын тогтоолын төсөл-2 | "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоол, 2020 оны 75 дугаар тогтоол | Төрийн захиргааны болон тусгай алба хаагчдын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон Засгийн газрын тогтоол батлагдсан байна. | "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны 488 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ нь 15 зэрэглэл тус бүрт 3-5 шатлалтай, төрийн тусгай албаны цалингийн сүлжээ нь 18 зэрэглэл тус бүрт 3-5 шатлалтай буюу нийт 153 ялгаатай цалинтай байсныг өөрчлөн төрийн захиргааны албан тушаалын 15 зэрэглэлийг 10, тусгай албаны 18 зэрэглэлийг 13 болгон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нягтаршуулсан. Үндсэн цалинг мөрдөгдөж байсан цалингийн шатлалын хамгийн өндрөөр нь тогтоон нэг шатлалтай болгосон. Үр дүнд нь 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс төрийн захиргааны 1-4 дүгээр шатлалын цалингаар цалинжиж байсан 14 мянга орчим, төрийн тусгай албаны 40.7 мянга орчим албан хаагчийн цалин 12-15 хувь нэмэгдсэн.<br>Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 9-ны 452 дугаар тогтоолоор цагдаа, дотоодын цэргийн албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн баталж, цалингийн 5 шатлалыг 1 болгосон. Үүний үр дүнд 12.0 мянга орчим цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдын цалин дунджаар 30 хувиар нэмэгдсэн.<br>Түүнчлэн Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоолоо. Уг арга хэмжээний хүрээнд 22.0 мянган төрийн захиргааны албан хаагчийн үндсэн цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт хүргэсэн. | |
| 35. | Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалинг 10-аас багагүй хувиар нэмэгдүүлнэ.<br><br>*/МУХТЖҮЧ-2.6.5, МУЗГҮАХ 2.5.5/* | Улсын төсөв: 52.0 тэрбум төг. | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоол | “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтад өөрчлөлт орсон байна. | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 550.0 мянган төгрөг болж нэмэгдсэнтэй холбоотойгоор төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 1 дүгээр сарын 01-ээс 8 хувиар нэмэгдүүлсэн.<br>Түүнчлэн Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоолоо. Уг арга хэмжээний хүрээнд төрийн нийтлэг үйлчилгээний 52.0 мянган албан хаагчдын үндсэн цалин 26.0-31.0 хувиар нэмэгдсэн. 2023 онд төрийн нийтлэг үйлчилгээний 52.0 мянган албан хаагчдын үндсэн цалин нийтдээ 34.0-39.0 хувиар нэмэгдсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36. | Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн төрд ажилласан жил бүрийг үнэлж нэмэгдэл олгоно. *<br>/АХ-2050 2.6.5/* | Улсын төсөв 50.0 тэрбум төг. | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоол | Засгийн газрын тогтоолд нэмэлт, өөрчлөлт орсон байна. | Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д өөрчлөлт оруулан баталсан. Төрийн захиргааны болон үйлчилгээний албанд анх ажилд орсон албан хаагч тасралтгүй 5 жил ажилласны дараагаас ажилласан жилийн нэмэгдэл авч эхэлдэг байсныг өөрчилж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил бүрээр бодож олгодог байхаар холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Үр дүнд нь 160.0 мянган төрийн албан хаагчийн цалин хөлс 2-5 хувиар нэмэгдэж, төрийн албанд чадварлаг албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах зарчмыг хэрэгжүүлэх боломж нэмэгдэнэ. | 100 |
| 37. | Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгоно.<br>*/АХ-2050 2.6.5/* | Улсын төсөв 15.0 тэрбум төг. | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам” | “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт орсон байна. | Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний орон нутгийн нэмэгдэл олгохоор болсон. Түүнчлэн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө төрийн захиргааны албан хаагчид олгох орон нутгийн нэмэгдлийг 80 хүртэл хувиар нэмэгдүүлэх боломжтой байдлаар холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ арга хэмжээнд орон нутгийн 12 мянга орчим төрийн захиргааны албан хаагчид хамрагдаж байна.<br>Мөн Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 242 дугаар тогтоолоор Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.<br>Уг тогтоол батлагдсанаар босоо удирдлагатай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буюу улсын төсвөөс санхүүждэг байгууллагын төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг орон нутгийн төсвөөс нэмж авах боломж бүрдсэн.<br>Мөн орон нутгийн нэмэгдэл авч чадахгүй байсан хөдөө, орон нутгийн соёлын байгууллагын зарим албан хаагчид, аймгийн төвийн суманд ажиллаж байгаа ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын албан хаагчид болон хөдөө сумдад ажиллаж буй ус, цаг уурын өртөө, харуулын албан хаагчид, улсын тусгай хамгаалалттай газрын туслах байгаль хамгаалагчид 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 8-20 хувийн нэмэгдэл авах боломжтой болсон. | |
| 38. | Төрийн захиргааны албаны 15 зэрэглэлийг 10 болгон нягтаршуулна.<br>*/АХ-2050 2.6.5/* | Улсын төсөв 20.0 тэрбум төг. | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | ЗГ-ын 2019 оны 275 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” | Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоосон Засгийн газрын тогтоол батлагдсан байна. | Засгийн газрын 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 15 зэрэглэлтэй байсныг өөрчлөн 10 болгон нягтаршуулсан.<br>Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дунджаар 26-60 хувиар нэмэгдүүлэн тогтоосон.<br>Энэ хүрээнд төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 590 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт, төрийн нийтлэг үйлчилгээний /ТНҮ/ албан хаагчдын цалингийн доод хэмжээ 565 мян.төгрөг байгааг 750.0 мянган төгрөгт, төрийн захиргааны албан хаагчдын цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт, төрийн тусгай албан хаагчдын цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт хүргэсэн. Энэ арга хэмжээнд 2023 онд нийт 991.5 тэрбум төгрөг зарцуулна. | 100 |
| 39. | Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2024 онд нэмэгдүүлэх тооцоо, судалгаа хийж санал боловсруулна.<br>*/МУХТЖҮЧ-2.6.5,* | Үйл ажиллагааны зардал | Тооцоо, судалгаа-2 | 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын нэгдсэн төсвийн төсөлд 266.2 тэрбум төгрөг тусгуулсан. | Холбогдох тооцоо, судалгааг хийж санал боловсруулан, 2024 оны төсвийн хүрээний | Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэн тогтоохоор холбогдох тооцоо судалгааг хийж Сангийн яаманд хүргүүлсэн. Дараах цалин хөлсийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *МУЗГҮАХ 2.5.5/* | | | | мэдэгдэл, улсын нэгдсэн төсвийн төсөлд тусгуулсан байна. | нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд 2024 оны улсын нэгдсэн төсөвт 955.8 тэрбум төгрөгийг тусгасан. Үүнд:<br>• Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлнэ.<br>• Хөдөөгийн суманд ажиллаж байгаа 51.8 мянган төрийн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувь, аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа 53.4 мянган төрийн албан хаагчид сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тооцож орон нутгийн нэмэгдлийг нийт 105.2 мянган төрийн албан хаагчид олгоно.<br>• 21 аймаг болон нийслэл Улаанбаатар хотын Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны 3.9 мянган албан хаагчид таван жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгоно. | |
| ***1.5.3. Хувийн хэвшлийн цалин хөлсний тогтолцоо, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн норм, нормативын асуудлаар санал боловсруулах , холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;*** | | | | | | | |
| 40. | Улсын хэмжээнд 2024 онд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэх тооцоо, судалгаа хийж, санал боловсруулна. */МУЗГҮАХ 2.5.5, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль 5.1, 6.1 дэх заалт/* | Улсын төсөв 36.0 тэрбум төг. | Тооцоо, судалгаа-1 | ХНТГТҮХ-ны 2022 оны 10 дугаар тогтоолоор ХХДХ-г 2023 оны 1 сарын 1-нээс сарын 550.0 мянган төгрөгөөр тогтоосон. | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх тооцоо, судалгааг хийж холбогдох талуудтай зөвшилцсөн байна. | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 сарын 13-ны 12 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн сард 660.0 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоолоо. | 100 |
| **1.6. МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАХ, ОРОЛЦОО ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ЦОГЦ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.6-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***1.6.1. Ядуурлыг бууруулах, хүн амын насны бүтэц, насжилт, ахмад настан, хүний хөгжлийн асуудлаар бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдамжаар хангах;*** | | | | | | | |
| 41. | Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай ОУ-ын пактын хэрэгжилтэд НҮБ-аас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг | Үйл ажиллагааны зардал | -Батлагдсан төлөвлөгөө<br>-Хэрэгжилтийн тайлан, хувь | ЭЗНСЭТухай ОУ-ын пактын хэрэгжилтийн МУ-ын 5-р тайланг НҮБ-ын | ЭЗНСЭТухай ОУ-ын пактын хэрэгжилтийн МУ-ын 5-р тайланд НҮБ-ын | НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороогоор Монгол Улсын ээлжит тавдугаар тайланг хэлэлцүүлсэн тухай тайлан, дүгнэлтийг Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн хуралд танилцуулж, Засгийн газрын | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангана.<br>*/Алсын хараа 2050-ын 2.3.1, 2.3.3, МУЗГҮАХ 2020-2024 2.5.8/* | | | ЭЗНСЭХороогоор хэлэлцүүлсэн. | ЭЗНСЭХорооноос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө батлан, 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 100 хувь хэрэгжсэн байна. | хуралдааны 10 дугаар тэмдэглэл гарав.<br>Монгол Улсын тавдугаар тайланг хэлэлцэн цаашид эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бүрэн дүүрэн хангахад чиглэсэн 23 багц асуудлын хүрээнд 58 зөвлөмжийг ирүүлж, ээлжит зургадугаар тайланг 2027 оны 10 дугаар сарын 31-ний дотор ирүүлэхийг хүссэн.<br>Үүний дагуу зөвлөмжийг НҮБ-ын дэмжлэгтэй монгол хэлрүү хөрвүүлж төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна.<br>Төлөвлөгөөний төслийг ХНХЯ-ны Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлстээр хянуулж, яамдаас санал авахаар хүргүүлэв. | |
| 42. | Ахмад настанд урт хугацаанд үзүүлэх тусламж үйлчилгээний цогц загварыг тодорхойлж, туршина.<br>*/Алсын хараа 2050-ын 3.1.13, МУЗГҮАХ 2020-2024 2.5.8/* | АХБ KSTA (9928) төсөл | -Ахмад настанд урт хугацаанд үзүүлэх тусламж үйлчилгээ /АНУХТҮ/-ний цогц загвар<br>-Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт | Цогц загварыг турших арга хэмжээний төлөвлөгөөг ХНХС, ЭМС-ийн хамтарсан тушаалаар батлагдсан. | Тусламж, үйлчилгээ үзүүлэх цогц загвар тодорхойлж, сонгосон байршилд туршсан байна.<br>АНУХТҮ-г 2022-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2023 оны үйл ажиллагаа 100 хувь хэрэгжсэн байна. | Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам хамтран 3 зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны чиглэлтэй “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/127, А/333 дугаар хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна.<br>Тусламж, үйлчилгээ үзүүлэх цогц загварын хүрээнд ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний төрлүүдийг тодорхойлох зорилгоор Кейс менежментийн онол практикт тулгуурлан Монгол Улсад тохирсон “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийн үйлчилгээний дараах зааврууды боловсруулан үйлчилгээнд туршин хэрэгжүүлж байна. Үүнд:<br>• Кейс менежерийн болон ахлах кейс менежерийн ажлын байрны тодорхойлолт,<br>• Кейс менежментийн бүтэц,<br>• Олон нийттэй холбогдох тохиолдлыг илрүүлэх,<br>• Эрсдэлийн илрүүлэг, ангилал,<br>• Кейс менежментийн үйлчилгээнд бүртгэн, баримтжуулах,<br>• Эрсдэлтэй ахмад настанд хэрэгцээний цогц үнэлгээ хийх,<br>• Тусламж үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах, хянах,<br>• Багийн хурал зохион байгуулах, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Үйлчлүүлэгчийг шилжүүлэх,<br>• Тусламж үйлчилгээг зогсоох.<br>Түүнчлэн ахмад настнуудад түгээмэл тохиолддог 31 төрлийн доройтлын үед эмнэл зүй, нийгэм сэтгэл зүй, санхүүгийн үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх тухай 31 зааврыг боловсруулж, үйлчилгээнд туршин хэрэгжүүлж байна.<br>Төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаар сонгогдсон байгууллагууд нь өөрсдийн хүний нөөцийн чадавхаа үнэлж, түүнд нийцсэн төлөвлөгөөг батлан хүний нөөцөө хэрхэн чадавхжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.<br>Туршилтын төслийн гурван төв үйлчилгээ үзүүлэх туршлага, байгууллагын боловсон хүчний нөөц чадавх зэрэгт тулгуурлан УХТҮ-ний тодорхой хэлбэрүүдийг туршиж, хэрэгжүүлж эхлүүлсэн.Тухайлбал:<br>- Сонгинохайрхан дүүргийн “Ачлалт хүүхдүүд” төрийн бус байгууллага нь байнгын асаргаатай ахмадуудад төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ дүүргийн 28 дугаар хороо, ахмадын хороо, өрхийн эмнэлэгтэй хамтран идэвхтэй насжилтын хөтөлбөр үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна.<br>- Дархан-Уул аймгийн Ахмадын хөгжлийн төв нь төвд суурилсан идэвхтэй насжилт, эрүүл мэндийн сэргээн засах, нийгмийн хөгжил, оролцоо, сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үзүүлж, 7 хоног бүрийн Лхагва, Пүрэв гаригуудад 2-3 түвшний ахмад настан, тэдний асран хамгаалагчдад явуулын үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн мэдээлэл, лавлагаа зуучлал, телемедициний үйлчилгээг шинээр нэвтрүүлэхээр боловсон хүчин, анги танхим, тоног төхөөрөмжийн бэлтгэлийг хангаж ажиллаж байна.<br>- Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ИНДТ 2-3 түвшний ахмад настнуудад эрүүл мэндийн, сэргээн засах үйлчилгээг эмнэлэгт түшиглэн үзүүлж байна. Мөн тухайн суман дахь гурван өрхийн эмнэлгийн эмч, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сувилагчидтай хамтран 2-3 түвшний ахмадуудад гэрийн эргэлт/ явуулын үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Түүнчлэн эмнэлгийн байгууллагын хувьд шинэ үйлчилгээ нь сумын бүжгийн клуб, теннисний холбоо зэрэгтэй хамтран ахмадуудад зориулсан идэвхтэй насжилтын (бүжиг, өглөөний алхалт, теннис, амьдрах ухааны сургалтууд гэх мэт) дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэн ажиллаж байна.<br>Төслийн гурван байршилд ахмад настны хөгжил, олон нийтийн оролцоотой халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын төлөөллийг хамруулсан олон нийтийн нөөц боломжийн зураглал боловсруулах сургалт зохион байгуулж, тухайн орон нутагт хэрэгжиж буй төрийн, хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалтыг гаргаж, үзүүлж буй үйлчилгээ, үйлчилгээнд хамрагдахад тавигддаг шаардлага, шалгуур, санхүүжилт/ төлбөрийн асуудлыг тодорхойлсон. Эдгээр мэдээллийн үндсэн дээр ахмад настны УХТҮ-ний нийтлэг зураглалыг боловсруулж, төв тус бүр өөрсдийн үйлчилгээний лавлах боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| ***1.6.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах*** | | | | | | | |
| 43. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<br>-Дагалдан гарах хуулийн төслийн тоо<br>-Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | -Үзэл баримтлалыг батлуулсан.<br>-Зардлын тооцоог боловсруулсан.<br>-Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн.<br>-Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулсан.<br>-Хуулийн төслийг эцэслэн боловсруулсан. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдан гарах 20 хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг хамтад нь батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл, хуулийн тандан судалгаа, үр нөлөөний судалгаа, зардлын тооцоог боловсруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг дагалдан 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.<br>Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 10 удаа хэлэлцүүлсэн бөгөөд ирсэн саналыг тусган ажилласан.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгааллын сайд хамтран батлав.<br>Мөн хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх зөвшөөрөл авах албан тоот хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.<br>Хуулийн III бүлэг буюу хүртээмжтэй орчин нөхцөлийн 8-12 дугаар зүйл нь Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөлд орж байгаа бөгөөд үндсэн асуудлаар шинээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сантай холбоотой 1 бүлэг, хүний нөөц бэлтгэх, төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, салбарын нийгмийн хамгааллын асуудлаар 3 зүйл нэмэгдэж, хуулийн 70-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байна. | |
| 44. | Саадгүй байдал хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулна.<br>*/МУЗГҮАХ 2020-2024, 2.5.8/* | Үйл ажиллагааны зардал | -Саадгүй байдал хүртээмжийн тухай анхдагч хуулийн төсөл<br>-Дагалдан гарах хуулийн төслийн тоо<br>-Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | шинээр хийх ажил | Саадгүй байдал хүртээмжийн тухай хуулийн төсөл, дагалдан гарах 20 хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн байна. | “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулсан бөгөөд 6 бүлэг, 23 зүйлээс бүрдэх юм. Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 10 удаа хэлэлцүүлсэн бөгөөд ирсэн саналыг тусган ажилласан.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хамтран батлав.<br>Мөн хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх зөвшөөрөл авах албан тоот хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.<br>Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандан судалгааг эцэслэн боловсруулсан. Мөн хуулийг даган гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав. | 90 |
| 45. | Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагааг эхлүүлнэ.<br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.8, МУХТЖҮЧ 2021-2025 2.3.4, МУХТЖТ 2.5.7/* | АХБ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв | Барилгын явц 24 хувь. | Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг ашиглалтад оруулж, үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна. | Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Улаанбаатар хотод байгуулагдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын угсралтын ажлыг 2022 онд “Би энд Би” ХХК–тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 46. | Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 2,3 дугаар үндэсний тайланг НҮБ-ын Хүний эрхийн хороогоор хэлэлцүүлнэ. | Үйл ажиллагааны зардал<br>Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | -Салбар дундын ажлын хэсэг<br>-Тайлан | Тайланг НҮБ-ын Хүний эрхийн хороонд 2019 оны 10 сард хүргүүлсэн. | 2, 3 дугаар тайланг боловсруулж, НҮБ-ын Хүний эрхийн хороогоор хэлэлцүүлсэн байна. | НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын болон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 2020-2023 оны хооронд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, мэдээлэл авах тухай 01/235 тоот албан бичгийг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 36 байгууллагад хүргүүлсэн.<br>Түүнчлэн тайлан боловсруулж нэгтгэх чиг үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/47 дугаар тушаалаар байгуулан НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмж, асуулгын жагсаалт, төрийн бус байгууллагуудын хүргүүлсэн сүүдэр тайланг үндэслэн хэрэгжилтийн тайлан мэдээллийг боловсруулж НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд хүргүүлсэн.<br>Тайлан хамгаалах Засгийн газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 281 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Энэ хүрээнд Монгол Улсаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхараар ахлуулсан холбогдох яамд, агентлагийн 15, НҮБ-ын Женев дахь Монгол Улсын Байнгын төлөөлөгчийн газраас 3 төлөөлөгч, нийт 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023 оны 08 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын ээлжит 2 болон 3 дугаар тайланг хэлэлцүүлж, хамгаалсан.<br>Тус хороо 2023 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 681 дүгээр хуралдаанаараа Монгол Улсын Засгийн газарт конвенцын хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой холбогдох зөвлөмжийг хэлэлцэн баталсан.<br>Энэ хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 29-ний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн Засгийн газрын хуралдаанд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын ээлжит 2 болон 3 дугаар нэгтгэсэн тайланг хэлэлцүүлсэн тухай илтгэх хуудсыг хэлэлцүүллээ.<br>Мөн Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжийг ХНХЯ-ны харъяа байгууллагын удирдлага, алба хаагчид, төрийн бус байгууллагын төлөөлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн гишүүд, олон улсын байгууллагын төлөөлөлд хэлэлцүүлэв. | |
| 47. | ХБХЭМБНХСК-ын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ. | | Салбар комиссын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үнэлгээ, тайлан | шинээр хийх ажил | ХБХЭМБНХ-ын 8 салбар комиссын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээний ажил зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулан 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/155 дугаар тушаалаар батлууллаа.<br>Удирдамжид заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Сэлэнгэ, Дундговь аймаг зэрэг нийт 8 ХБХЭМБНХСК-ын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээг 2023 оны 06 дугаар сарын 14-25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.<br>Хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулснаар дараах үр дүн гарсан байна. Үүнд:<br>-ХБХЭМБНХ-ын салбар комиссыг ажиллах байраар хангах, хурал зохион байгуулах байрны орчин нөхцөлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхчүүдэд хүртээмжтэй, ээлтэй болгохоор чиг үүргийг комиссын дарга нарт хүргүүлснээр хурал зохион байгуулах орчин сайжирсан.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн хэргийг жигдрүүлэх, хадгалалт, архивлах талаар комиссын дүрэмд тусгайлан заалт оруулж комиссын дүрмийг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.<br>-Салбар комиссын нарийн бичгийн орон тооны болгож, албан тушаалын тодорхойлолтыг батлахаар 2024 оны төсөвт тусгуулахаар санал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оруулсан.<br>-Хүүхэд, гэр бүлийн сонирхол, хэрэгцээг харгалзаж хүүхдийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж хэвшүүлэх зорилгоор Эрт үеийн дэмжлэг, боловсролын Портеж хөтөлбөрийн зааврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдаар хамтран батлуулахаар ажиллаж байна.<br>-Дэмжлэгт хяналтын үр дүнтэй холбоотой ажил сайжруулах чиглэлийг бүх салбар комисуудад хүргүүлж, хэрэгжилтийн тайланг авч ажиллалаа. | |
| **1.7. ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.7-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***1.7.1. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах*** | | | | | | | |
| 48 | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, төслийг дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж, Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлнэ.<br>*(МУХТЖҮЧ-ийн 2.3.5, МУЗГҮАХ-ийн 2.5.8)* | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | -Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл-1<br>-Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл-1<br>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл-1<br>-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл-1<br>-Хүн худалдаалахта | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан. | Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан үзэл баримтлалын дагуу боловсруулж, 20 гаруй удаагийн хэлэлцүүлэг хийж, Засгийн газрын гишүүд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, анхан, дунд шатны салбар бүрийн нийгмийн ажилтан, 800 гаруй хүүхэд болон иргэдийг саналыг тусгасан.<br>Хуулийн төслийг Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.<br>Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцэхийг Улсын Их Хурлаас дэмжсэн. УИХ-ын хуулийн төслийн ажлын хэсэгтэй хамтран ажиллаж УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэж байна. Хуулийн төслийг 7 бүлэг, 59 зүйлтэй боловсруулсан. Дагалдан 14 хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | й тэмцэх тухай тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл-1 | | | | |
| 49. | Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн үр дагаварын үнэлгээ хийж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна.<br><br>*(МУЗГҮАХ-ийн 2.3.1)* | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | -Хуулийн үзэл баримтлал -1<br>-Хуулийн төсөл-1<br>-Журам -1 | Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг стандарт MNS:6540 2015 онд батлагдсан.<br>1. Засгийн газрын 2022 оны 97 дугаар тогтоол “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам”<br>2.Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам<br>3.Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр батлах тухай Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/38 дугаар тушаалаар батлагдсан Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр | Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн үзэл баримтлал батлуулсан байна.<br>Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг стандарт MNS:6540-г шинэчлэн батлуулсан байна.<br>“Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлуулсан байна. | Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, нөхцөл байдлын судалгаа хийж тайланд үндэслэн ХНХЯ-ны ТНБД-ын 2023 оны А/108 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж хуулийн төслийг үзэл баримтлалын хамт боловсруулсан.<br>Хуулийн төслийн шинэчилсэн найруулгаар Хүүхэд асран халамжлах үйлчилгээний тухай хууль хэмээн нэрийг өөрчилж, хүүхэд асран халамжлах үйлчилгээний төрөл, хэлбэрийг тодорхойлох, үйлчилгээний төрөл, хэлбэрийг хувилбарт байдлаар тусгах, хүүхэд асран халамжлах үйлчилгээ, хүүхэд асрагчид тавих нийтлэг шаардлагыг тогтоох, төрөөс зорилтот бүлгийн хүүхдийг хамруулах, мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх, хэрэглэх, ашиглах болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулахаар тусган хэлэлцүүлж байна. Үүнд:<br>- 2023 оны 06 сарын 14 бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг ТББ-ын төлөөлөл бүхий 70 хүнд танилцуулж санал авсан.<br>-08 дугаар сарын 31 нд Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийн гишүүдэд танилцуулж санал авах хэлэлцүүлэг хийв.<br>10 сарын 04 нд ажлын хэсэг хуульч, өмгөөлөгчдийн баг, бодлогын зөвлөхүүдтэй хамтарсан хэлэлцүүлэг хийж хуульчдаас санал авсан.<br>11 дугаар сарын 02 нд мэргэжлийн байгууллагаар хэлэлцүүлж ХНХЯ-ны ГББХЗГ-ын дарга, Хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга, мэргэжилтэн, ЗГХА-ГБХЗХГ, НГБХЗХГ, Дүүргийн ГБХЗХГ, хүүхэд харах үйлчилгээний төвүүд, өдөр өнжүүлэх төв, ТББ, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ОУБ-ын төлөөлөл, зөвлөх баг, ажлын 60 хүн оролцсон. Үзэл баримтлалын төслийг Боловсрол, эрүүл мэндийн сайдтай хамтран батлах санал сүүлийн хэлэлцүүлгээс гарсан тул эдгээр яамдын оролцоотой баримтлалын төслийг батлуулахаар ажиллаж байна. | |
| 50. | “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулна. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | -Сайдын тушаал-1<br>-Дүрэм-1 | ХНХС-ын 2019 оны А/347 дугаар тушаалаар “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрэм”-ийг баталсан. | Дүрмийг батлуулж, хэрэгжилтийг хангасан байна. | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тус хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн байдал, чиг үүргийг шинэчлэн тодорхойлж, дүрмийг Засгийн газар батлах зохицуулалтыг шинээр тусгасан. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төсөлд Захиргааны хяналтыг Хүүхдийн эрхийн улсын байцагч тавих шинэ зохицуулалтыг оруулсан. -Хүүхдийн эрхийн улсын байцаагчдын давтан сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулж, 21 хүүхдийн эрхийн байцаагчийг хамруулсан.<br>Хүүхдийн эрхийн улсын байцаагч бэлтгэх сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 25-аас 11 сарын 03-ны хугацаанд зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 14 албан хаагчид улсын байцаагчийн эрх шинээр олгож байна.<br>-Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Хүүхдийн эрхийн улсын байцаагчид болон Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нийт 150 албан хаагчдыг 2 өдрийн сургалтын хөтөлбөрийн агуулгаар сургаж чадавхжуулсан.<br>-Уг сургалтын үеэр Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрмийн төслийн хүрээг гаргах саналыг хэлэлцсэн. Энэ дагуу дүрмийн төслийг шинэчлэн боловсруулсан ба улсын байцаагчдын дунд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.<br>- Тайлбар: Хүүхэд хамгааллын тухай хууль УИХ-аас баталсны дараа дүрмийн төслийг дахин сайжруулж, батална. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 51. | Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5, 6 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийн МУ-ын ЗГ-ын тайланг боловсруулж, хүргүүлнэ. (*Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар зөвлөмжийн 49 дүгээр зүйл)* | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | -Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-1<br>-Дүрмийн төсөл-1 | Тайлан боловсруулах салбар дундын ажлын хэсэг ХНХ-ын сайдын 2021 оны А/219 дүгээр тушаалаар байгуулагдсан. | Тайланг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд хүргүүлсэн байна. | Тайлангийн төслийг боловсруулж 2022 онд бүх яам өөрийн салбар дахь “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ын хэрэгжилтийг танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Үүний мөрөөр тухайн салбарын конвенцын хэрэгжилтийн тайланд өгөх мэдээллийг бэлтгэж ирүүлсэн.<br>Ковидын-19 цар тахлаас шалтгаалан гэрээний конвенцын хороодоор хэлэлцэх тайлангийн хугацаа нэгээс хоёр жилээр хойшлогдсон талаар Гадаад харилцааны яамнаас Е/09/21/247 тоот албан бичгээр мэдэгдсэн. Иймд Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос тайлан боловсруулах асуумж болон Монгол Улсын Засгийн газрын 5, 6 дугаар тайлан хүргүүлэх, хэлэлцэх хугацааг тодорхойлж, хариу ирүүлээгүй тул тайлан хүргүүлэх асуудал хүлээгдэж байна.<br>Хүүхдийн эрхийн тухай конвенцын тайлан боловсруулах сургалтыг Салбар дундын ажлын хэсгийн гишүүдэд зохион байгуулж, тайлан боловсруулах ажлын хэсгийг дахин байгуулах болон тайланд тусгах мэдээллийг шинэчлэхээр холбогдох талуудад 2023 оны 03/3118 тоот албан бичгийг хүргүүлж, мэдээлэл цуглуулах ажлыг эхлүүлээд байна. Тайлангийн мэдээллийг шинэчлэн ажлын хэсгээр 12 дугаар сард багтаан хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | 70 |
| 52. | Хүүхдийн хөгжлийн үйлчилгээний стандартын төсөл боловсруулна. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Стандартын төсөл-1 | Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS5633:2019 | Стандартын төслийг боловсруулж, 2-оос доошгүй удаа хэлэлцүүлж санал авсан байна. | Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ, үйл ажиллагаанд тавих нийтлэг шаардлага, стандартын төслийг боловсруулсан.<br>Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох тухай хэлэлцүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.<br>Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээ болон боловсруулагдаж буй баримт бичгийн төслийг танилцуулж, санал тусгах хэлэлцүүлгийг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, хуульчдын 70 гаруй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлөл оролцсон.<br>Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага стандартын төслийг эцэслэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны 11/3247 тоот албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | |
| ***1.7.2. Гэр бүлийг бэхжүүлэх, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;*** | | | | | | | |
| 53. | “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ыг батлуулна. | Үйл ажиллагааны зардал | ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал | ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд , ЭМ-ийн сайдын 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар хамтарсан тушаал батлагдсан. | -Журмын төслийг батлуулсан байна.<br>-Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр сургалт зохион байгуулсан байна. | ХНХС, ХЗДХС, ЭМСайдын 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ын төслийг боловсруулж, улсын хэмжээнд шат дараалсан хэлэлцүүлэг хийсэн.<br>Төслийг Эрүүл мэндийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд руу 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1075 албан тоотоор хүргүүлсэн боловч Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл УИХ-аар хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан түр хүлээх чиглэлийг ирүүлсэн болно.<br>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу анхан шатанд ажилладаг 21 аймаг, 9 дүүргийн 765 Хамтарсан багийн 6008 гишүүнээр дамжуулж иргэн бүрийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, холбогдох үйлчилгээг үзүүлж байна.<br>Хамтарсан багийн гишүүдэд зориулсан арга зүйн 12 цуврал гарын авлагыг боловсруулж, НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр 2023 оны 05 дугаар сараас эхлэн 9 аймаг, 4 дүүргийн 1599 Хамтарсан багийн гишүүд болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу чиг үүргийг хариуцан гүйцэтгэдэг 168 холбогдох албан хаагчдийг чадавхжуулах кейс менементийн сургалт зохион байгууллаа.<br>Харин 5 дүүрэг, 12 аймгийн сургалтыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 54. | “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын хэрэгжилтийг хангана. | Үйл ажиллагааны зардал | ХНХС, ХЗДХСайдын хамтарсан тушаал | ХНХС, ХЗДХСайдын 2017 оны А/120, А/178 дугаар хамтарсан тушаал батлагдсан | -Журмын төслийг батлуулсан байна.<br>-Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр сургалт зохион байгуулсан байна. | 1. ХНХС, ХЗДХСайдын 2017 оны А/120, А/178 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам"-ын төслийг боловсруулж, улсын хэмжээнд шат дараалсан хэлэлцүүлэг хийсэн.<br>2. Журмын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд баталсан.<br>3. Хууль зүй, дотоод хэргийн сайд руу 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1075 албан тоотоор хүргүүлсэн.<br>1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 1/337 дугаар албан тоотоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан түр хүлээх чиглэлийг ирүүлсэн болно.<br>/Зуруулсан хувийг хавсаргав/ | 100 |
| 55. | Гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавигдах шаардлага стандартын төслийг батлуулна. *(МУЗГҮАХ-ийн 2.5.8)* | Үйл ажиллагааны зардал | Батлагдсан стандарт-1 | Стандартын төслийг боловсруулсан. | Стандартыг батлуулсан байна. | Гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага стандартын төслийг боловсруулж, холбогдох байгууллагын төлөөллөөр 5 удаа хэлэлцүүлж, саналыг тусган эцэслэн боловсруулж, батлуулахаар 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 03/3006 тоот албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Стандартын техникийн хорооны 12 дугаар сарын хурлаар хэлэлцэж батлав. Стандарт албажих журмын дагуу албажиж ойрын үед дугаар нь ирнэ. | 100 |
| **2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **2.1. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, САЛБАРУУДЫН ЭРЭЛТЭД НИЙЦСЭН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВ, ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОЖ ХӨГЖҮҮЛЭХ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨРИЙН ТААТАЙ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.2-ЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***2.1.1. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийг ажлын байраар хангах, ядуурлыг бууруулах, тогтвортой ажлын байр бий болгохыг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;*** | | | | | | | |
| 56. | Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын арга хэмжээний санал боловсруулна. | Үйл ажиллагааны зардал | Хуулийн төслийн санал-1 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр | “Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг холбогдох | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлалыг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудтай уялдуулан шинэчлэх ажлын хүрээнд уг хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран баталхаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрийг 2022-2023 онд хэрэгжүүлэхээр баталсан. | хуулийн төсөлд тусгасан байна. | 2023 оны 12 сарын 01-ний өдрийн 01/3132 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Мөн хуулийн төсөл, зардлын тооцоог боловсруулан Засгийн газарт өргөн мэдүүлэхээр бэлэн боллоо.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зохицуулалтыг тусгаж байна. Үүнд:<br>- ажил олгогчид санхүүгийн дэмжлэг, урамшуулал олгохоос гадна ажлын байрыг хадгалах, хамгаалах, ялангуяа эдийн засгийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас бий болдог хямралын үед хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг Ажилгүйдлийн даатгалын тухай болон бусад хууль тогтоомжтой уялдуулан тусгах,<br>- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгохоор хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн ойрын, дунд, хэтийн хугацааны судалгааг холбогдох аргачлалын дагуу хийж, дүн, мэдээг иргэдэд түгээх замаар мэргэжил сонголтыг зөв, оновчтой хийх боломжийг дэмжих зохицуулалтыг тусгах,<br>- хөгжлийн бэрхшээлтэй хүн, залуучууд, эмэгтэйчүүд болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зохицуулалт хийх, дэмжлэгийн төрөл, хэлбэрийг хуульд нарийвчлан тусгах; бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хүрээнд нэр томьёог боловсронгуй болгож, холбогдох дэмжлэг, урамшууллыг оновчтой, уялдаатай, шаталсан байдлаар тодорхойлох, бизнес инкубацын үйлчилгээг орчин үеийн чиг хандлагад нийцүүлж үзүүлэх зэрэг дэмжлэг, үйл ажиллагааг хуульд тусгах зэргээр боловсруулж байна. | |
| 57. | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, тооцоололд үндэслэн салбар дундын бодлого, зохицуулалтыг хангаж, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран | Үйл ажиллагааны зардал | Холбогдох салбарын яамдуудтай үйл ажиллагааг өргөжүүлж, хамтран ажилласан байна | “Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ыг боловсруулж, туршилтаар ажиллуулж эхлүүлсэн. | “Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ын тооцоололд үндэслэн Ажлын байрны шингээлт ихтэй эдийн засгийн үйл | Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загварын хөгжүүлэлтийн ажлын хүрээнд эдийн засгийн салбаруудыг мал аж ахуй, газар тариалан, худалдаа үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилгын үйлдвэрлэл, уул уурхайн үйлдвэрлэл, дулаан ба цахилгаан үйлдвэрлэл гэсэн 7 салбараар симуляци хийхийн тулд Кобба-Дугласын үйлдвэрлэлийн функцийг ашигласан. 2050 хүртэлх хугацааны дараах | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллана.<br>*/Алсын хараа-2050 2.6.10/* | | | | ажиллагааны салбарт зохистой ажлын байр бий болгох чиглэлээр холбогдох салбарын яамдуудтай үйл ажиллагааг өргөжүүлж, хамтран ажилласан байна. | таамаглалуудыг тооцоолсон байна. Тухайлбал: Монгол Улсын хүн ам, дундаж наслалт, 1 хүнд ноогдох ДНБ, нийт ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин, тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага, тэтгэврийн даатгалын сан, тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлого, тэтгэврийн даатгалын сангийн бусад орлого, албан журмаар даатгуулагчид, сайн дурын даатгуулагчид, тэтгэвэр авагчийн тоо, цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагчийн тоо, ҮОМШӨ-ний тэтгэвэр авагчийн тоо, өндөр насны тэтгэвэр авагчийн тоо зэрэг болно.<br>Манай яамнаас Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд 5-10 жилийн хугацаанд шаардагдах эрэлттэй ажил, мэргэжлийн судалгааг олон улсын арга, аргачлалын дагуу хийхээр гадаад, дотоодын зөвлөх баг шалгаруулж, судалгааны ажлыг эхлүүлээд байна. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн дунд хугацааны таамаглалыг олон улс болон хөдөлмөрийн чиглэлээр мэргэшсэн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэгч байгууллагуудын арга аргачлал, загварыг судлан харьцуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, загварын дагуу уг таамаглалыг боловсруулах зорилготой “Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал боловсруулах” ажлыг зөвлөх үйлчилгээний баг Эм Эм Си Жи ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Зөвлөх баг урьдчилсан тайланг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр танилцууллаа. Үүнд:<br>1. Хөдөлмөр эрхлэлтийг таамаглах загварын мэдрэмжийн коэффициентуудыг хүн амын шинэчилсэн тооцоололд үндэслэн дахин нягталж, тооцооллын найдвартай байдлыг шалгаж эхний үр дүнгийн уулзалтанд шаардлагатай дата мэдээлэл, тооцооллыг боловсруулсан.<br>2. ДНБ-ний таамаглалд суурилан салбарын бүтцийг тодорхойлох, өгөгдлийг салгаж, засварлаж бэлтгэх ажлын датаг засварлаж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлэн болгосон. Монгол улсын салбар хоорондын тэнцлийн мэдээлэл дээр тулгуурлан Леонтьевийн аргаар хэтийн тооцоо хийх ажлын датаг 2019 оны байдлаар бэлтгэж тооцоолол хийхэд бэлэн болгосон.<br>3. Аймгуудын датаг шахаж тэдгээрийн ДНБ-ий тооцооллыг хийхэд бэлэн болгосон. Шилжилт хөдөлгөөний датаг шалгасан.<br>4. Эдийн засгийн салбараарх ажил мэргэжлүүдийн 2035 он хүртэлх трендийг гаргаад, жил бүрийн салбар ажил мэргэжлийн матрицийг тооцоолсон. Тус матриц нь эдийн засгийн 19 салбар, 10 гол ажил мэргэжлийн ерөнхий ангиллаар хийгдсэн болно.<br>Цаашид зөвлөх баг 2023 оны 12 дугаар сарын 06-15-ны өдрийн хооронд Хөдөлмөрийн зах зээлийн таамаглалын дундын тайланг танилцуулж энэ ондоо багтаан эцсийн үр дүнг боловсруулан, хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | |
| ***2.1.2.Ажиллах хүч гадаадаас авах, гаргах бодлогыг зохицуулах, гадаадаас буцаж ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлыг зохицуулах;*** | | | | | | | |
| 58. | “Монгол Улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, батлуулна.<br><br>*/АХШХтХууль 22.1/* | Үйл ажиллагааны зардал | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | Засгийн газрын 2022 оны “Монгол Улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай” 359 дүгээр тогтоол | “Монгол Улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан бүх яамд, холбогдох газруудаас санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, батлуулсан байна. | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасны дагуу “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Монгол Улсад 2023-2025 онуудад шаардлагатай нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг аж үйлдвэрийн IV хувьсгал, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн динамик өөрчлөлт, олон улсын хөдөлмөрийн чиг хандлага болон өмнөх жилүүдийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажиллах хүчний статистик мэдээлэл болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гадаадаас авч ажиллуулах зайлшгүй шаардлагатай нарийн мэргэшлийн мэргэжилтний талаарх судалгаа зэрэгт тулгуурлан, холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгааны институтийн дэргэдэх 35 гаруй мэргэжлийн зөвлөлүүд, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон бусад оролцогч талуудаас саналуудыг нэгтгэн боловсруулж, яамдуудаас санал авч 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 359 дүгээр тогтоолоор 11 эдийн засгийн ангиллын 130 нарийн мэргэшлийн жагсаалтыг батлуулсан. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг баталснаар уг жагсаалтад заасан мэргэшлийн гадаад ажилтанг авч ажиллуулахад Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.9-д заасан зөвшөөрлийг нэмэлт шаардлагагүй авах эрх зүйн орчин бүрдсэн. | |
| 59. | “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, батлуулна.<br><br>*/АХШХтХууль 32.4/* | Үйл ажиллагааны зардал | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | Засгийн газрын 2021 оны 392, 2022 оны 292 дугаар тогтоолоор 2022 онд 23 аж ахуйн нэгж, байгууллагын 4279 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн. | “Ажлын байрны төлбөрөөс 2023 онд чөлөөлөх аж ахуйн нэгж, байгууллага, гадаад ажилтны тоог батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, батлуулсан байна. | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32.4-д заасны дагуу “Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтад гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно.” гэж заасны дагуу “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2023 оны 19, 90, 205, 331, 386 дугаар тогтоолуудаар Гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 41 аж ахуйн нэгж, байгууллагын 7242 гадаад ажилтныг 2023 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг гаргаад байна. Уг тогтоолын дагуу 2023 оны эхний 11 сарын байдлаар 34 аж ахуйн нэгж, байгууллагын 4215 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөөд байна.<br>2024 онд Гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг хэрэгжүүлэх 25 аж ахуйн нэгж, байгууллагын 10965 гадаад ажилтыг “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, яамдуудаас санал авахаар 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/3155 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Тогтоолын төслийг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Засгийн газрын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр бэлтгэл хангаж байна. | |
| 60. | Ажиллах хүч гадаадад гаргах асуудлыг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай /шинэчилсэн найруулга/ хуульд нийцүүлэн зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.<br><br>*/АХШХтХууль 6.1 /* | Үйл ажиллагааны зардал | Санамж бичгийн хэрэгжилтийг хангана. | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. | Тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн байгууллагуудын асуудлыг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай, Тусгай зөвшөөрлийн тухай хуулиудын дагуу тухай бүр хянан хэлэлцэж, ХНХ-ын сайдад танилцуулж, шийдвэрлүүлсэн байна. Шинэчилсэн хуулийн дагуу холбогдох санамж бичгийн хэрэгжилтийг хангасан байна. | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг дагаж гарах журмын тухай хуулийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинэчлэн авсан 47 байгууллагад 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хуулийн танилцуулга, цаашид анхаарах асуудлын талаар сургалт, уулзалт зохион байгуулсан.<br>Түүнчлэн НҮБ-ийн ОУ-ын Шилжилт Хөдөлгөөний байгууллага болон “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсад хүчин чармайлалтыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад "Олон улсын хөдөлмөр зуучлалын нэгдсэн системийн ёс зүйтэй хөдөлмөр зуучлал" сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад оролцсон 40 тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон дагаж гарах журмуудын талаар танилцуулсан. Мөн 2023 оны 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотод “Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн санхүүжилтээр зохион байгуулагдсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалтад Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, түүнийг дагаж гарах дүрэм журмууд, хуулийн хэрэгжилтэд анхаарах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | асуудлын талаар танилцуулсан. Сургалтад нийт 130 салбарын хяналтын улсын байцаагчид хамрагдсан.<br>-Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан дараах журмууд дагаж гарсан. Үүнд:<br>-Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32.8-д “Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхтэй холбоотой журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу журмын төслийг хуулийн нэмэлт, өөрчлөлтэй уялдуулан боловсруулж холбогдох журмын дагуу яамдуудаас санал авч Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>-Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 24.6-д “Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг эрүүл мэндийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу “Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ыг боловсруулан хамтарсан тушаал батлуулахаар Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.<br>-Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасны дагуу Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ үзүүлэх журмын төсөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах гэрээний загварыг тус тус боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/14 дугаар тушаалаар батлуулан Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдөр холбогдох баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 61. | Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний боломжит үйлчилгээний цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийнэ.<br><br>*/АХШХтХууль 9.9 /* | ХЭДС<br>150 сая төг. | -Нэмэлт хөгжүүлэлт-1<br>-Мэдээллийн сан-1 | Цахим системийн ажлын даалгаврын дагуу цахим систем нэвтрүүлж, бүрэн ашиглаж эхэлсэн. | Нэмэлт ажлын даалгаврын дагуу хөгжүүлэгч компанитай гэрээ байгуулан Нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн байна. Мэдээллийн сангийн аюулгүй байдалд хяналт тавьсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах” 233 дугаар тогтоолын 1-т “тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг” цахим хэлбэрт шилжүүлэхээр заасан. Уг тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “И-Монгол академи" улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран 2023 оны 10 дугаар сард бодлогын даалгавар боловсруулсан.<br>Тусгай зөвшөөрлийг “Тусгай зөвшөөрлийн цахим систем– www.license.mn”-д оруулах хөгжүүлэлтийг “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” улсын үйлдвэрийн газраар хийлгэж, ашиглалтад ороход бэлэн болоод байна. | 90 |
| ***2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, чанарын баталгаажилтийг бэхжүүлэх, багш, суралцагчдын судалгаа мэдээлэлд хяналт тавих;*** | | | | | | | |
| 62. | “Мэргэшлийн үндэсний хүрээг бүрдүүлэх, зохицуулах журам”-ын төслийг боловсруулж, батлуулна.<br><br>*/Хөдөлмөрийн тухай хуулийн 17.3/* | Үйл ажиллагааны зардал | Журмын төсөл -1 | “Мэргэшлийн үндэсний хүрээ” судалгаа, МУ-ын ТМБС-ын салбарыг дэмжих төсөл, 2017 он | “Мэргэшлийн үндэсний хүрээг бүрдүүлэх, зохицуулах журам”-ын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, батлуулсан байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3 дахь хэсгийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар “Мэргэшлийн үндэсний хүрээг бүрдүүлэх, зохицуулах тухай журам”-ыг боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ахлан байгуулагдсан.<br>Мэргэшлийн үндэсний хүрээг хэрхэн тодорхойлох, бүрдүүлэх, зохицуулах асуудлыг холбогдох талуудтай хэлэлцэх зорилго бүхий уулзалтыг Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт болон холбогдох мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй зохион байгуулсан. Уулзалтаас гарсан санал, үр дүнд үндэслэн уг журмын төслийг боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэсэн төдийгүй Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн индекст өөрчлөлт оруулах саналыг боловсруулж 2023 оны 01/2678 тоот албан | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгээр БШУЯ-нд хүргүүлсэн ба 2023.11.28 өдөр бүх яам, мэргэжлийн холбоод, түншлэлийн хүрээнд хамтран ажилладаг аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийг хамруулсан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, гаргасан санал зөвлөмжийг тусгуулах ажлыг зохион байгуулж ажиллаад байна.<br>Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн төсөл, жишиг аргачлал боловсруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж батлах тухай Монгол улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалын төсөлд ажиллах албан хаагчдын нэрсийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/3163 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу ажлыг зохион байгуулж, үр дүнг 2023 оны 12 дугаар сард багтаан танилцуулж, асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллана. | |
| 63. | “Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журам”-ын төслийг боловсруулж, батлуулна.<br><br>*/Хөдөлмөрийн тухай хуулийн 17.4/* | Үйл ажиллагааны зардал | Журмын төсөл -1 | “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээг баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам”, ХНХ-ын сайдын 2017 оны А/50 дугаар тушаал. | Ажлын хэсгийн гишүүд, оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, журмын төсөл боловсруулж, оролцогч талуудын санал дүгнэлтийг нэгтгэн ХНХ-ын болон БШУ-ны сайдын хамтарсан тушаалаар батлуулсан байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 17.4 дэх хэсэгт “Хүний мэргэшлийн түвшинг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулж, 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Мэргэжлийн зөвлөл, сургалтын 30 гаруй байгууллагын төлөөллүүдийн дунд хэлэлцүүлсэн байсан ч Монгол Улсын Их Хурлаар Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан. Тус хуулийн 8.3-т “Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан. Энэ хүрээнд тус | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | журмын төслийг боловсруулан хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг тусгаж ажилласан болно. “Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журам”-ын төсөл, тушаалын төслийг эцэслэн боловсруулж дуусч санал авахаар БШУЯ-нд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 01/2546 дугаар албан бичгийг хүргүүлээд байна. | |
| 64. | “Ажилтны мэргэшлийн зэрэг тогтоох, олгох, баталгаажуулах нийтлэг журам”-ыг боловсруулж, батлуулна.<br><br>*/Хөдөлмөрийн тухай хууль 103.1.2/* | НҮБХХ<br>10.0 сая төг. | Журмын төсөл -1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/124 дугаар тушаал. | Ажлын хэсгийн гишүүд, оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, журмын төсөл боловсруулж, оролцогч талуудын санал дүгнэлтийг нэгтгэн, ХНХ-ын сайдын тушаалаар батлуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/214 тоот тушаалаар “Ажилтны мэргэшлийн зэрэг тогтоох, олгох, баталгаажуулах нийтлэг журам”-ыг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.Тус ажлын хэсгийн гишүүд болон зөвлөх багтай хамтран журмын төслийг боловсруулж, 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр 50 оролцогчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, журмын төслийг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар албажуулахаар бэлтгэл ханган ажиллаж байсан боловч уг журмын төсөлд зарим нэр томъёолол зарчмын саналд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн тул зөвлөх багт буцааж дахин уулзалт зохион байгуулахаар ажиллаж байна. | 70 |
| 65. | “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл батлах тухай” Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, батлуулна.<br><br>*/МУЗГҮАХ 2.5.9/* | Үйл ажиллагааны зардал | ЗГ-ын тогтоол-1 | “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл батлах тухай” Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 58 дугаар тогтоол. | “Засгийн газрын тогтоолд нэмэлт, өөрчлөл оруулах тухай” Засгийн газрын тогтоолыг батлуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/62 дугаар тушаалаар “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийг 2023 онд зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд тогтоолын төсөл, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, батлуулахаар 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/1319 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Мөн хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай төслийг 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, ХЭҮЗ-ийн 5 тоот тогтоолыг батлуулсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 66. | Хөдөлмөр эрхлэлт, ур чадвар олгох сургалтын бодлого үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинэлэг хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.<br><br>*/МУ-ын хөгжлийн зорилтот хөтөлбөр 2020-2030/* | Дэлхийн банкны төсөл 700.0 сая.төг. | Хөтөлбөр-1 | Ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж Дэлхийн банкнаас санхүүжилт авахаар тохиролцсон. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, зорилтот бүлгийн иргэдийн ажилтай орлоготой болгох чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулсан байна. | Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтыг хөдөлмөр зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцсэн, шинэлэг байдлаар хэрэгжүүлэхээр “Эрэлтэд нийцсэн ур чадвар”-ын хөтөлбөрийн төслийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор тус хөтөлбөрийг батлуулсан. Тус хөтөлбөр нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн хүрээнд хэрэгжинэ. Тус хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, хувь хүний хэрэгцээнд тулгуурлан ажилгүй, ажил хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй, мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар болон мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах замаар ажилтай, орлоготой болгох, ажлын байраар хангах зорилготой. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамжийн төслийг боловсруулан, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 сарын 27-ны өдрийн А/145 тушаалаар батлуулж хэрэгжүүлж ажиллах байгууллагуудад хүргүүлж чиглэл өгч ажиллалаа. | 100 |
| 67. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилттэй хэрэгжүүлдэг богино хугацаанд мэргэжлийн болон зөөлөн ур чадвар олгох, аж ахуй эрхлэх сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгох, сургалтын үйл ажиллагааны тогтолцоог хөгжүүлнэ.<br>*/МУЗГҮАХ 2.5.9/* | ХЭДС 5.0 сая төг. | Хөтөлбөр -1 | шинээр хийх ажил | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, зорилтот бүлгийн иргэдийн ажилтай орлоготой болгох чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлж, 1000 | Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтыг хөдөлмөр зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцсэн, шинэлэг байдлаар хэрэгжүүлэхээр “Эрэлтэд нийцсэн ур чадвар”-ын хөтөлбөрийн төслийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор тус хөтөлбөрийг батлуулсан. Тус хөтөлбөр нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн хүрээнд хэрэгжинэ. Тус хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, хувь хүний хэрэгцээнд тулгуурлан ажилгүй, ажил хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй, мэргэшлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүнийг сургасан байна. | түвшнээ ахиулах хүсэлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар болон мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах замаар ажилтай, орлоготой болгох, ажлын байраар хангах зорилготой. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамжийн төслийг боловсруулан, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 сарын 27-ны өдрийн А/145 тушаалаар батлуулж хэрэгжүүлж ажиллах байгууллагуудад хүргүүлж чиглэл өгч ажиллалаа. | |
| **2.2. НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.4-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***2.2.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;*** | | | | | | | |
| 68. | Гадаад улстай нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулна.<br><br>*/НДТ хуулийн 2 дугаар зүйлийн 2./* | Үйл ажиллагааны зардал | Зохион байгуулсан ажил /ОХУ, БНСУ, БНУУ, БНТУ, БНЧУ, БНПУ-ын нийгмийн хамгааллын хэлэлцээр/-2<br>Судалгаа-1 | ОХУ, БНЧУ, БНПУ, БНСУ-ын нийгмийн хамгааллын хэлэлцээртэй холбоотой 9 ажил зохион байгуулж ажилласан. | Хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулах ажлын хүрээнд мэдээлэл, чиглэл, зөвлөмж боловсруулж, Консулын газар, Гадаад харилцааны яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газарт хүргүүлсэн байна. Судалгаа шинжилгээ хийж, санал боловсруулсан байна. Судалгаанд суурилж танилцуулга мэдээлэл бэлтгэсэн байна. | Монгол Улс, Бүгд Найрамдах Чех улс хоорнд байгуулсан Нийгмийн хамгааллын хэлэлцээр 2023 оны 3-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон.<br>Хоёр улсад харилцан ажиллаж, амьдарч буй иргэдийн нийгмийн баталгаа хангагдаж, тэтгэврээ шилжүүлэн авах боломжтой боллоо.<br>Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн гадаад иргэдийн судалгааны танилцуулга /2016-2022 оны байдлаар/-ыг боловсруулж, постер мэдээлэл бэлтгэн олон нийтийг мэдээллээл хангав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 69. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах зорилгоор Засгийн газрын тогтоол болон бусад журам, дүрэм, заавар боловсруулна. */ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.2/* | Үйл ажиллагааны зардал | Боловсруулж, батлуулсан тогтоол, шийдвэрийн тоо-3 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-2, тогтоол-3, ХНХ-ын сайдын тушаал-12, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол-2 | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах Засгийн газрын тогтоол болон бусад шийдвэр боловсруулж батлуулсан байна. | **1.** Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 60 дугаар тогтоолоор "Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам"-ыг шинэчлэн батлуулав.<br>2. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийг хэлэлцэн баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 361 дүгээр тогтоолоор "Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх журам"-ыг батлуулав.<br>3. Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар байгуулсан.<br>4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн "Мэргэшлийн зэрэг олгох тухай" А/06 дугаар тушаалаар нийгмийн даатгалын 516 байцаагч нарт зэргийн нэмэгдэл олгохоор шийдвэрлэсэн.<br>5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн "Нийгмийн даатгалын улсын /ахлах/ байцаагчийн эрх түдгэлзүүлэх, эрх хүчингүй болгох тухай" А/53 дугаар тушаал батлуулсан.<br>6. "Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай" Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/69, А/132 дугаар хамтарсан тушаалыг батлуулж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6450 дугаарт бүртгүүлсэн.<br>7. "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/136 дугаар тушаалыг батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6449 дүгээр бүртгэсэн.<br>8. “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/137 дугаар тушаалыг батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6459 дүгээрт бүртгэсэн.<br>9. “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнэ батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын А/143, А/376 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6474 дүгээрт бүртгэсэн.<br>10. ”Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацааг батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын А/152, А/388 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6478 дугаарт бүртгэсэн.<br>11. “Цагийн хөлсний хэмжээ, олгох журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/154 дугаар тушаалаар батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэхээр хүргүүлсэн.<br>12. Нийгмийн даатгалын улсыг байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах журам”, улсын байцаагчийн үнэмлэхний загварыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/170 дугаар тушаалаар батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэхээр хүргүүлсэн.<br>13. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгээр сарын 26-ны өдрийн 362 дугаар тогтоолоор "Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм"-ийг батлуулав.<br>14. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар "Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай", "Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох журам", "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, төлбөр олгох, санхүүжүүлэх журам"-ыг тус тус хэлэлцүүлж батлуулсан.<br>15. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар "Шимтгэлийн хэмжээг тогтоох тухай" (50000 вон), "Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай", ("Тогтоол хүчингүй болгох тухай" /НДҮЗ-09/), "Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай" (Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж), "Журам батлах тухай" (Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам)-ыг тус тус хэлэлцүүлж батлуулсан. | |
| 70. | "Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тодорхойлох аргачлалыг боловсруулж батлуулна. | Үйл ажиллагааны зардал | Тушаал-1 | Холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг зохицуулсан байна. | Хэрэгжилтийг зохицуулсан байна. | Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тодорхойлох" аргачлалыг боловсруулав.<br>Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт, зааврыг эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална" гэж, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэхь хэсэгт “Мэргэжлээс -шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацааг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж тус тус заасны дагуу 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/152,А/388 дугаар хамтарсан тушаалыг батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6478 дугаарт бүртгүүлэв. | |
| 71. | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд “Үйлдвэрлэлийн ослыг багасгах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авсны дүнд ажил олгогч 3 жил дараалан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлбөр гаргуулаагүй бол дараагийн жилд төлөх даатгалын шимтгэлийг 10 хувиар хөнгөлж болно” гэж заасны шаардлага хангасан ажил олгогчийн судалгаа хийнэ. | Үйл ажиллагааны зардал | Судалгаа-1 | 2016 онд шалгаруулж байсан. | Судалгаа хийгдсэн байна. | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2020-2022 онд (3 жил) дараалан төлбөр гаргуулаагүй ажил олгогчийн судалгааг гарган 2023 оны 11 дүгээр сарын 08-нд удирдлагуудад танилцуулсан.<br>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд 2020-2022 онд (3 жил) дараалан төлбөр гаргуулаагүй нийт 34 400 ажил олгогч 292.5 тэрбум төгрөгийн шимтгэл төлсөн бөгөөд ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт 29.2 тэрбум (292,5 тэрбум төгрөг*10%) төгрөг болж байна. | 100 |
| 72. | Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Ажил олгогч болон даатгуулагч 5 жил дараалан ажилгүйдлийн | Үйл ажиллагааны зардал | Судалгаа-1 | 2016 онд шалгаруулж байсан. | Судалгаа хийгдсэн байна. | Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу ажилгүйдлийн тэтгэмжийн даатгалын сангаас 2018-2022 онд (5 жил) дараалан тэтгэмж гаргуулаагүй ажил олгогчийн судалгааг гарган 2023 оны 11 дүгээр сарын 08-нд удирдлагуудад танилцуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй бол дараагийн жилд төлөх даатгалын шимтгэлийг 10 хувиар хөнгөлнө” гэж заасны шаардлага хангасан ажил олгогчийн судалгаа хийнэ. | | | | | Ажилгүйдлийн даатгалын санд 2018-2022 онд (5 жил) дараалан тэтгэмж гаргуулаагүй нийт 11 610 ажил олгогч 2.2 тэрбум төгрөгийн шимтгэл төлсөн бөгөөд ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт 220 сая (2.2 тэрбум төгрөг*10%) төгрөг болж байна. | |
| 73. | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалт зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Сайдын тушаал-1 | Жил бүр зохион байгуулж байна. | Улсын байцаагчийн эрх шинээр олгох, эрх баталгаажуулах, эрх цуцлах, түдгэлзүүлэхтэй холбоотой сайдын тушаал батлагдсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/156 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалт авах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсан. Ажлын хэсгийн хурлыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, Шалгалтыг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулав. | 100 |
| 74. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой 3-4 стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулахад бэлтгэнэ. | ҮОМШӨДС 30.0 сая төг. | Стандарт – 3-4 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 145 стандартыг мөрдөж байна. | Шинэчлэх шаардлагатай эхний 3-4 стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. | Хөдөлмөрийн аюлгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээрх зарим стандартуудыг шинэчлэн боловсруулахаар Төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 30 |
| 75. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг улсын хэмжээнд төлөвлөгөө гарган зохион байгуулахад хамтран ажиллана. | ҮОМШӨДС 35.0 сая төг. | Сарын аяныг зохион байгуулах ажлын чиглэл гаргасан байна. | Жил бүрийн 4 дүгээр сард зохион байгуулж байна. | Төлөвлөгөөний дагуу сарын аяныг зохион байгуулсан байна. | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2023” арга хэмжээг Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан “*Эрүүл, аюулгүй ажил- Бидний суурь эрх*” уриан дор 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төлөвлөгөө гарган ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг олон нийтэд түгээн ажиллалаа. Аяныг төлөвлөсөн хугацаанд нь амжилттай зохион байгуулсан. | 100 |
| 76. | “Эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах журам”-ын хэрэгжилтийг | ҮОМШӨДС 45.0 сая төг. | Эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага- | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/64 дүгээр | “Эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-ыг | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, идэвх, санаачилгыг дэмжих, сайн туршлагыг түгээн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангана. | | 2022 шалгаруулсан байна. | тушаалаар баталсан журам | шалгаруулж, сайн туршлагыг түгээсэн байна. | дэлгэрүүлэх зорилгоор “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах ажлыг 2012 оноос эхлэн 12 дахь жилдээ зохион байгуулав. Энэхүү шалгаруулалтад 5 салбарын 65 байгууллага холбогдох материалаа ирүүлсэнээс 10 байгууллагыг шалгаруулж өргөмжлөл, шагналыг гардуулав. | |
| 77. | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | Үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөө – 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангасан байна. | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/137 дугаар тушаалаар батлуулан аймаг, дүүрэг, нийслэлд албан бичгээр чиглэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | 100 |
| 78. | Боловсролын салбарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг салбарын яам болон мэргэжлийн хяналтын улсын байцаагчидтай хамтран зохион байгуулна. | ҮОМШӨДС 10.0 сая төг. | Улсын үзлэг зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн салбарын улсын үзлэгийг зохион байгуулсан байна. | Боловсролын салбарт улсын үзлэг зохион байгуулсан байна. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг боловсролын салбарын мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад зохион байгуулах ажлын удирдамжийг батлан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ний 03/826 тоот албан бичгээр аймаг, дүүрэг, нийслэлд чиглэл хүргүүлж ажилласан.<br><br>Улсын үзлэгт нийт 21 аймаг, 9 дүүргийн мэргэжлийн боловсролын-77 байгууллага, үүнээс өмчийн хэлбэрээр авч үзвэл төрийн-38, хувийн-26, их, дээд сургуулийн 13 байгууллага байна. ХАБЭА-н улсын үзлэгт мэргэжлийн боловсролын 58 байгууллага хамрагдсан.<br><br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн улсын үзлэгийн хүрээнд ХАБЭА-н удирдлага зохион байгуулалт- 58,8%, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал- 67,4%, ажлын орчин, ахуйн байрны эрүүл ахуйн нөхцөл-54,7%-тай дүгнэгдэж улсын хэмжээнд 60,4**%** буюу хангалтгүй үнэлгээтэй байна.<br>Улсын үзлэгийн тайланд үндэслэн тухайн салбарт авч хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийн төслийг боловсруулж салбарын яаманд хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 79. | Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулна. | ҮОМШӨДС 1.0 сая төг. | ЗГ-ын тогтоол – 1 | Засгийн газрын 2015 оны 269 дугээр тогтоол | Засгийн газрын тогтоол батлагдсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг 2022 оны А/170 дугаар тушаалаар байгуулсан. “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг шинэчлэн батлах ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/2878 тоот албан бичгээр Бүх яамдаас санал авч, холбогдох тооцоо судалгаа хийж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна. | 90 |
| 80. | Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаал нэмэлт, өөрчлөлт оруулна. | Үйл ажиллагааны зардал | Сайдын тушаал-1 | Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаал | Сайдын тушаал шинэчлэн батлагдсан байна. | Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталсан "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-г шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/155 дугаар тушаалаар батлуулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан тоотоор хүргүүлсэн. | 100 |
| 81. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулна. | Үйл ажиллагааны зардал | Сайдын тушаал-1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаал | Сайдын тушаал шинэчлэн батлагдсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам", шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/173 дугаар тушаалаар батлуулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан тоотоор хүргүүлсэн. | 100 |
| **2.3. НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.4-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***2.3.1.Нийгмийн халамжийн хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах салбар дундын бодлогын уялдааг зохицуулах;*** | | | | | | | |
| 82. | Нийгмийн халамжийн тухай хуулийн 18-р зүйлд заасан үйлчилгээний журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Үйл ажиллагааны зардал | Сайдын тушаал-1 | 2012 оны ОНОТХҮ үзүүлэх журам А/91 дугаар тушаал | ХНХ-ын сайдын тушаалын төслийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны А/91 дүгээр тушаалаар баталсан ОНОТХҮ үзүүлэх журмын төслийг шинэчлэн боловсруулан нийслэл, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсүүдээс болон төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн боловсруулсан бөгөөд яамны газар хэлтсүүдээр тойруулан танилцуулж байна. 2023 оны 12 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сард багтаан ХНХС-ын тушаалаар батлуулахад бэлэн болоод байна. | |
| 83. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хүмүүнлэгийн чиглэлээр хамтран ажиллана. | Үйл ажиллагааны зардал | -Гэрээ-1<br>-Төлөвлөгөө -1 | 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр 01/29 дугаартай гэрээ | МУЗН-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажилласан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмай нийгэмлэгийн хооронд төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх, хамтран ажиллах тухай гэрээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монголын улаан загалмай нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга Н.Болормаа нар 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/126 дугаартай гэрээг байгуулан төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| **2.4. ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.7-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***2.4.1. Гэр бүлийг бэхжүүлэх, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;*** | | | | | | | |
| 84. | Хүүхэд үрчлэлийн зөвлөлийг тухай бүр хуралдуулна. (*МУХТЖҮЧ-ийн 2.3.2, МУЗГҮАХ-ийн 4.3.3, 4.3.5, Яамны үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын 2.5.7.1)* | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Зөвлөлийн хуралдааны дүгнэлт, шийдвэр /Хүсэлт хүлээн авсан тухай бүр/<br>Монгол Улсаас гадаад улсад үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдалтай танилцах уулзалт зохион байгуулах | Хүүхэд үрчлэлийн зөвлөлийг ХНХ-ын сайдын 2021 оны А/132 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. | -Зөвлөлийг тухай бүр хуралдуулж, дүгнэлт, шийдвэр гаргасан байна.<br>-2-3 улс оронд үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдалтай танилцах уулзалт зохион байгуулсан байна. | “Хүүхэд үрчлэлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/162 дугаар тушаалаар шинэчилсэн. Хүүхэд үрчлэх тухай хүсэлтийг 2 гэр бүлээс ирүүлснийг “Хүүхэд үрчлэлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлтийг Гадаадын иргэн харьяатын газарт хүргүүлсэн.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон НҮБ-ын Хүүхдийн сангийн урилгаар Олон улсын хувийн эрх зүйн асуудлаарх Гаагийн бага хурлын Байнгын товчооны нарийн бичгийн дарга бөгөөд Гэр бүлийн хуулийн багийн хамтран даргалагч Лаура Мартинез-Мора Монгол Улсад ажиллаж, “Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцын үүрэг (НССН)” сэдэвт сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгуулж, холбогдох нийт 54 албан хаагчийг хамруулсан. 1993 оны “Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц”-ын хэрэгжилтийг хангахад тулгарч буй бэрхшээл, сайн туршлага, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын холбогдох дээд байгууллага болон Гаагийн бага хурлын Байнгын товчооны нарийн бичгийн дарга нарын санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. 2023 онд Бүгд Найрамдах Герман улсад үрчлэгдсэн 3 хүүхдийн үрчлэлтийн тайланг авч нөхцөл байдалтай танилцлаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 85. | Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагын заавар боловсруулна. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Батлагдсан заавар-1 | шинээр хийх | Заавры батлуулсан байна. | Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтны гарын авлагууд /кейс менежмент, халамжийн, сургуулийн, цагдаагийн, эмнэлгийн ажилтны гарын авлагууд/-ыг боловсруулж, 2023 онд үндэсний хэмжээнд зохион байгуулсан хамтарсан багийн сургалтад хэрэглэж, хэрэглэгчдэд түгээв. | 100 |
| 86. | Гэр бүлд үзүүлэх нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний арга зүй боловсруулна. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Батлагдсан арга зүй-1 | шинээр хийх | Арга зүйг батлуулсан байна. | Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний гарын авлагыг боловсруулж, 2023 онд үндэсний хэмжээнд зохион байгуулсан хамтарсан багийн сургалтад хэрэглэж, нийгмийн ажилтнуудад түгээв. | 100 |
| 87. | Залуучуудын мэдээллийн сан, статистик үзүүлэлтийг сайжруулж, хүний нөөцийг чадавхижуулна. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | -Батлагдсан төлөвлөгөө-1<br>-Хэрэгжилтийн тайлан-1 | 2022 онд 35 ЗХТ-ийн 80 мэргэжилтнийг статистикийн сургалтад хамруулсан. | Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | Мэдээллийн сангийн баяжуулалт, ашиглалтыг сайжруулах үүднээс маягт, маягтыг нөхөх зааврыг шинэчилж, ҮСХ-ны даргын 2022 оны А/118 дугаар тушаалаар зөвшөөрсний дагуу, ХНХСайдын 2022 оны А/168 дугаар тушаалыг үндэслэн ГБХЗХГ-ын даргын 2022 оны А/177 дугаар тушаалаар маягтууд, тэдгээрийг нөхөх заавры баталсан.. Шинэчилсэн маягт, зааврын дагуу мэдээлэл цуглуулах, боловсруулах явц дахь асуудал, шийдлийг хэлэлцэх, чадавхийг бэхжүүлэх сургалтыг цахимаар 3 болон 10 дугаар сард 2 удаа, танхимаар 1 удаа тус тус зохион байгуулж, төвийн мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлсэн. | 100 |
| 88. | “Эрэгтэйчүүдэд нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх жишиг төв”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрэгтэйчүүдэд сургалт, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлнэ. | НҮБХАС, ШХА 19.6 сая төг. | Сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо-50 | 2022 онд жишиг төвийн засварын ажлыг гүйцэтгэсэн. | Эрэгтэйчүүдэд нийгэм- сэтгэл зүйн зөвлөгөө тогтмол өгдөг болсон байна | Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” үндэсний чуулганыг зохион байгуулж, чуулганы зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд:<br>“Эрэгтэйчүүдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн цогц үйлчилгээг тодорхойлох үйлчилгээний арга зүй, аргачлал”-ыг боловсруулсан.<br>“Эрэгтэйчүүдтэй ажиллах арга зүйн сургалт”-ыг 2023 оны 05 дугаар сарын 11-12-ны өдөр зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн төр, төрийн бус байгууллагын 70 гаруй мэргэжилтнийг хамруулж, эрэгтэйчүүдийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхийг дэмжсэн.<br>НҮБХАС, ШХА-тай хамтран хэрэгжүүлж буй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд нийслэлийн Чингэлтэй дүүрэгт “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө, мэдээлэл, өгөх жишиг төв”-ийг байгуулж, 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр буюу “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан үйл ажиллагааг нээсэн. Уг жишиг төвийн үйл ажиллагааны менежмент, удирдлага зохион байгуулалтыг Засгийн газрын тухай хуулийн дагуу ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж, цаашид эрэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний сүлжээг үүсгэхээр төлөвлөж байна. Жишиг төв нь үйл ажиллагаа эхлүүлснээс хойших 6 сарын хугацаанд 146 хүнд утсаар зөвлөгөө, 85 хүнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, 44 хүн буюу 22 гэр бүлийн гишүүдэд хосын зөвлөгөө, 23 подкаст, 23 төрлийн сургалт, сурталчилгаа, 2334 удаагийн цахим сурталчилгаа, цахим хуудсаар дамжуулж 253 хүнд зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн. Мөн Монголын үндэсний олон нийтийн радиотой хамтран “Марсынхан” цуврал подкаст, сурталчилгааны 15 дугаарыг бэлтгэж, олон нийтийн хүртээл болгосон. Мөн нийгмийн ажлын мэргэжлээр сурч буй оюутнуудад төвийн үйл ажиллагааг танилцуулах зэргээр эрэгтэйчүүдийн чиглэлээрх судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэхийг зорьж төвийн үйл ажиллагааг сурталчилж байна.<br>- 21 аймаг, 9 дүүргийн Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулж, архины хамааралтай 57 эрэгтэйчүүд эмчилгээ, зөвлөгөө өгч ажлын байранд холбон зуучилсан. Мөн 32 эрэгтэйд ур чадварын үнэлгээ хийж оффисын байр, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд холбон зуучилсан. Хорих ангийн хүмүүжигч 130 эрэгтэйчүүдэд хувь хүний хагжлийн сургалт зохион байгуулж хорихоос суллагдахад бэлтгэх хөтөлбөрийг сурталчилсан. /Төвийн танилцуулах видеог хүргүүлэв/ | |
| 89. | Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Жендэрийн эрх тэгш | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Сургалт хийсэн байгууллагын тоо-150 | Үлгэрчилсэн заавар батлагдсан. | Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна | Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана. | | | | | чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний комиссын хамтарсан тушаалаар "Үлгэрчилсэн заавар"-ыг батлуулж, төрийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгуулсан бол аж ахуйн нэгж хувийн хэвшлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах талаар МАОЭНХ-той хамтран 6 удаагийн цуврал сургалтыг зохион байгуулсан. | |
| 90. | Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалаас урьдчилан сэргийлэх, хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтүүдийг тодорхойлж, нэвтрүүлнэ. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Үзүүлэлт бүхий удирдамж-1 | Үлгэрчилсэн заавар батлагдсан. | Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалаас урьдчилан сэргийлэх, хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтийг ханган ажиллаж, үзүүлэлтийг мөрдүүлсэн байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т заасны дагуу ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж байна. Энэхүү бодлого нь хүүхэдтэй гэр бүл, ялангуяа эмэгтэйчүүдийг ажлын байранд ялгаварлан гадуурхахаас сэргийлж, улсын хэмжээнд хэрэгжүүлж буй томоохон арга хэмжээ юм. Энэ хүрээнд Дэлхийн зөн Монгол ОУБ-аас техникийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь хэсэг, Хүүхдийн төлөө зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. Сургалтыг 2023 оны 03-аас 05 дугаар сард Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Булган, Орхон, Архангай, Говьсүмбэр, Дархан-Уул аймаг болон Багахангай, дүүрэгт зохион байгуулж, 742 байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл гишүүд оролцсон. | 30 |
| ***2.4.2. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;*** | | | | | | | |
| 91. | Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандарт боловсруулна. *(ХХ-ын тухай хууль)* | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Стандартын төсөл-1 | АНУ-ын "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ"-ний хүрээнд Дэлхийн зөн Монгол олон улсын | Стандартын төслийг боловсруулсан байна. | АНУ болон Монгол Улсын хооронд байгуулсан "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт" гэрээний хүрээнд АНУ-ын Төрийн Департаментын санхүүжилтээр хэрэгжиж буй "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь" төсөлтэй хамтран стандартын төслийг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагатай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө | | боловсруулж байна. Стандартын төсөл боловсруулах ажлын хэсэг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албан дээр байгуулагдсан. Стандартын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-тай хамтран боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санал авч байна. Стандартын төсөлд ирсэн саналыг тусган сайжруулах ажлыг хамтран зохион байгуулж байна. Тайлбар: Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамт Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл УИХ-аар батлагдсаны дараа журмыг батална. | |
| 92. | Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам батлуулна. *(ХХ-ын тухай хууль)* | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Тушаал-1 Журам-1 | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулсан. | Журмын төслийг боловсруулсан байна. | АНУ болон Монгол Улсын хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” гэрээний хүрээнд АНУ-ын Төрийн Департаментын санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төсөл болон Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран “Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг боловсруулах ажлыг эхлүүлсэн. Журам боловсруулах ажлын хэсэг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд байгуулагдан хамтарч ажиллаж байна. Ажлын хэсгийн гишүүд дараах журмуудыг боловсруулж, салбаруудаас санал авч байна. Үүнд: 1. Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам; /шинэчилж байна./ 2. Хүн худалдаалахын хохирогчид сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ үзүүлэх журам; 3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх журам; 4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам; 5. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам”, 6. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”; “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам” болон “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам”-ын төсөлд санал авч хэлэлцүүлэх ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Хөдөлмөр, нийгмийн сургалт, судалгааны институтын албан хаагчид оролцож, журмын төсөлд албан тоотоор санал авсан. “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам” журмын төслийг чиг үүргийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас эцэслэн санал өгч батлуулах ажлыг зохион байгуулах юм. -“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам”, “Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдан боловсруулсан Хүүхдийн эрхийн тухай хуулийн төсөл Улсын Их хурлаас батлагдсаны дараа батлуулна. Тайлбар: Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамт Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл УИХ-аар батлагдсаны дараа журмын төсөл батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллана. | |
| 93. | НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын зөвлөмжийг хэрэгжүүлнэ. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Зөвлөмжийн хэрэгжилтийн урьдчилсан тайлангийн төсөл-1 | ХНХСайдын 2022 оны А/211 дугаар тушаалаар салбар дундын Ажлын хэсэг байгуулсан. | Салбар дундын ажлын хэсгийг үе шаттай хуралдуулсан байна. Зөвлөмжийн хэрэгжилтийн урьдчилсан тайланг бэлтгэсэн байна. | Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах Хорооноос ирүүлсэн зөвлөмжийг орчуулж, төлөвлөгөөний төслийг боловсруулж, яамд, агентлагуудаас санал авч, эцэслэн боловсруулсан. Төлөвлөгөөний төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/211 дүгээр тушаалаар байгуулагдсан конвенцын зөвлөмжийг хэрэгжүүлэх салбар дундын ажлын хэсгийн хуралдаан болон төр, төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уулзалт, хэлэлцүүлэгт танилцуулсан. Төлөвлөгөөний төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын дарга нарт танилцуулж, санал авсан. Төлөвлөгөөний төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулахад бэлэн болсон. | |
| **2.5. ЭРСДЭЛД СУУРИЛСАН САЛБАРЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТЫГ МӨРДҮҮЛЭН МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ИРГЭДИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГУУЛАХ, ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРҮҮЛ , АЮУЛГҮЙ ОРЧИНД ХӨДӨЛМӨРЛӨХ ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ БҮХИЙ ҮР ДҮНТЭЙ ЦОГЦ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***2.5.1. Салбарын хяналтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлт оруулан, хэрэгжилтийг хангуулах;*** | | | | | | | |
| 94. | Хяналт шалгалтын нийтлэг журмын хүрээнд төв, орон нутагт салбарын хяналтыг хэрэгжүүлэх журам боловсруулж, батлуулна.<br><br>*/Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9.2.1, 5.19/* | Үйл ажиллагааны зардал | Журам-1 | Мэргэжлийн хяналт, шалгалын ерөнхий шаардлага, стандарт /МХЕГ-ын даргын 2019 оны тушаал/ | -Журмын төсөл боловсруулж, ХНХ-ын сайдын тушаалаар батлуулсан байна.<br>-Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хяналт шалгалт хийх нийтлэг журмын хүрээнд салбарын хяналтыг хэвийн хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн баримт бичгүүдийн боловсруулан батлуулж ажиллалаа. Үүнд:<br>- “Салбарын улсын ерөнхий байцаагчийн эрх шинэчлэн олгох тухай” сайдын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/51,<br>- “Хяналтын улсын ахлах байцаагчийн эрх, албаны болон хувийн дугаар олгох тухай” сайдын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/49, А/50 дугаар тус тус тушаалаар нийт 162 салбарын улсын ерөнхий болон улсын (ахлах) байцаагчийн эрх, үнэмлэх, тэмдэг үргэлжлүүлэн олгож хяналт шалгалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.<br>- “Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох заавар батлах тухай” 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/22,<br>- “Хяналт шалгалтын объектын жагсаалт батлах тухай” 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/42,<br>- ХНХ-ын сайдын 2023 оны 03 дугаар сарын 22-ны “Эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, шалгалтад хамруулах давтамжийн хугацаа батлах тухай” А/31,<br>- “Хяналт шалгалтад хяналтын хуудас хэрэглэх журам, хяналтын хуудас шинэчлэн батлах тухай” 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/54,<br>- “Үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, гэрчилгээ олгох журам батлах тухай” 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/26, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - “Улсын (ахлах) байцаагчийн хөдөлмөрийн жишиг норм норматив батлах тухай тухай” 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/27 дугаар тушаалуудыг тус тус батлуулан хяналт шалгалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. “Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжин ирсэн. Үүнтэй холбоотой салбарын улсын байцаагчдын нийт 32 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, дүн шинжилгээ, харьцуулалтыг хийж Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүллээ. | |
| 95. | Салбарын хяналтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн боловсруулж, батлуулна. | Үйл ажиллагааны зардал | Дүрэм-1 Журам -2 | -Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм. -МХЕГ-ын даргын 2021 оны А/78 тоот тушаал, Үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох журам -ХНХ-ын сайдын 2017 оны А/36 тоот тушаал, Аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиллах заавар /аргачилсан зөвлөмж/-ыг тус тус мөрдөн ажиллаж байгаа. | Хяналт шалгалтын болон хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхтэй холбоотой дүрэм, журмыг шинэчлэх, өөрчлөн найруулах саналыг боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулсан байна. | - Хяналт шалгалтын нэгдсэн стратеги болон тасралтгүй хэрэгжих хяналтын бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, түүний харьяа байгууллагын зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж, улсын байцаагч нарт тавигдах шаардлага, бие даасан байдлыг хангах, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын журам”-ын төсөл, “Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагааг үнэлж дүгнэх заавар”-ын төслийн саналыг НДЕГ, ХХҮЕГ болон аймаг, орон нутгийн албан хаагчдаас авч нэгтгэн боловсруулж, батлуулахад бэлэн болсон. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 96. | Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулна. *<br>/Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9.2.1, 5.19/* | Үйл ажиллагааны зардал | Шинээр батлуулсан хяналтын хуудас, тоо-6 | Хяналтын хуудасны тоо-6: | Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын 6 хуудсыг шинэчлэн боловсруулж, ХНХ-ын сайдаар батлуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Хяналт шалгалтад хяналтын хуудас хэрэглэх журам, хяналтын хуудас шинэчлэн батлах” тухай А/54-дүгээр тушаалаар доорх хяналтын хуудсуудыг шинэчлэн боловсруулж, батлууллаа. Үүнд:<br>-Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр: 07.1.1 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас; 07.1.2 кодтой Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас,<br>-Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 07.2.1 кодтой Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас,<br>-Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр,<br>-07.3.1 кодтой Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас,<br>-07.3.2 кодтой Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас,<br>-07.3.3 кодтой Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолтыг шалгах хяналтын хуудас,<br>-07.3.4 кодтой Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас,<br>-07.3.5 кодтой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас<br>Шинээр болон шинэчлэн боловсруулсан хяналтын хуудсыг хяналт шалгалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. | 100 |
| 97. | Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн үүсч болзошгүй эрсдэлийг удирдах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | -Эрсдлийн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэж, хяналт шинжилгээ хийнэ.<br>-Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний Төлөвлөгөө-1 | Эрсдлийн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэж, хяналт шинжилгээ хийж, 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний Төлөвлөгөөг МХЕГ-ын даргын тушаалаар баталсан. | Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн үүсч болзошгүй эрсдэлийг удирдах арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөг боловсруулж, ХНХ-ын сайдаар батлуулсан байна. | Үүсч болзошгүй эрсдэлийг удирдах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад сүүлийн 5 жилийн хяналт шалгалтын тоон үзүүлэлт /хяналтын хуудасны мэдээлэл, зөрчлийн болон эрсдэл үүсэх магадлал, мөн хууль сахин мөрдөлтийн мэдээллүүд/-д үндэслэн хийгдэх байсан. Хяналт шалгалтын чиг үүрэг салбарын яамдуудад очсонтой холбоотой хяналт шалгалтын цахим бүртгэл, мэдээллийн цахим системийн үйл ажиллагаа бүрэн зогссон тул өмнөх 5 жилийн хяналт шалгалтын тоон үзүүлэлтийг татан авч ашиглах боломжгүй болсон. Харин 2023 оны хагас жилийн хяналт шалгалтын дүн шинжилгээг гаргаж, удирдлагад танилцуулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 98. | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах, эрсдэлийн төлөв байдлын талаар олон нийтийг цахим мэдээллээр хангана. *lТХШТ хууль $5^5$.2. Энэ хуулийн $5^5$.1-д заасан эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтооно./ /Хяналт шалгалтын нийтлэг журмын 35 дугаар зүйлд заасны дагуу/* | Үйл ажиллагааны зардал | -Эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулна.<br>-ЗГ-ын тогтоолын төсөл-1 | 2022 оны эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг МУ-ын Засгийн газрын 2012 оны 23 дугаар тогтоолоор баталсан. | 2023 оны Эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн, МУ-ын Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна. | 1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^5$ дугаар зүйлийн $5^5$.2 дахь хэсэгт заасны дагуу “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт”-ийг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн хурлаар хэлэлцэгдэж батлагдсан.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөг Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоолоор батлуулж, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/42 тоот тушаалаар төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулан гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна. Хяналт шалгалтын чиг үүрэг салбарын яамдуудад очсонтой холбоотой хяналт шалгалтын цахим бүртгэл, мэдээллийн цахим системийг шинээр хөгжүүлэх шаардлагатай болсон. Хяналт шалгалтын цахим систем www.ekhyanalt.gov.mn-ыг ЦХХХЯам хөгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд систем хөгжүүлэлтийн ажил бүрэн дуустал хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх боломжгүй. Хяналт шалгалтын мэдээллийг загвар хүснэгтийн дагуу хагас, бүтэн жилээр авч нэгтгэн ажиллаж байна | 100 |
| 99. | Зөрчлийн болон Зөрчил шалгах шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, батлуулна. | Үйл ажиллагааны зардал | -Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай журмын төсөл-1<br><br>-Албадан иргүүлэх тухай журмын төсөл-1 | Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай журмыг хэрэгжүүлж байсан. | -Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай журмын төслийг шинэчлэн найруулж, УЕП-р батлуулсан байна.<br>-Албадан иргүүлэх тухай журмын төслийг шинээр боловсруулж, ХЗДХ-ийн сайдаар батлуулсан | - Хууль зүй, дотоод хэргийн яаманд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан хэргийн харьяалалд өөрчлөлт оруулах, түүнчлэн харьяаллын давхардлыг арилгах талаарх болон албадлагын арга хэмжээ авах тухай төслийг холбогдох байгууллагуудад хүргүүлж саналыг нэгтгэн шийдвэрлүүлэхээр Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03/624 тоот, ХНХ-ын сайдын 2023.11.24-ний өдрийн 01/3018 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн.<br>- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-д заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааны харьяаллын асуудлаар Улсын ерөнхий прокурорт, Зөрчлийн тухай хуулийн $10.5^2$ дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна.. | зүйлд өөрчлөлт оруулах асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус албан бичиг хүргүүлсэн.<br>- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох тухай саналыг төрийн захиргааны байгууллага, аймаг, орон нутгийн байгууллагаас санал авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж Салбарын хяналтын газрын улсын байцаагчийн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны төсвийг ирэх оны төсөвт санал өглөө. ХХҮЕГ, НДЕГ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 196 дугаар тогтоолд зааснаар зардлын төсвийг хаьяа төрийн байгууллагын 2024 оны төсөвт оруулсан байна. | |
| **3. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **3.1. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, САЛБАРУУДЫН ЭРЭЛТЭД НИЙЦСЭН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВ, ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОЖ ХӨГЖҮҮЛЭХ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨРИЙН ТААТАЙ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.2-ЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***3.1.1. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийг ажлын байраар хангах, ядуурлыг бууруулах, тогтвортой ажлын байр бий болгохыг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;*** | | | | | | | |
| 100. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр хангаж, тогтмол хяналт, үнэлгээ хийнэ.<br><br>*/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль 30.1.6/* | ХЭДС<br>70.0 сая төг. | -Үнэлгээний тайлан - 1<br>-Арга хэмжээ-1 | 2021 оны Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж үнэлгээ хийсэн. Хэрэгжилт 84 хувь байна. | -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, үнэлгээ хийх үйл ажиллагаа тогтмолжсон байна.<br>-Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр бүрэн хангасан байна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэгийг 2020 онд 3274 иргэнд 6.3 тэрбум төгрөгийг, 2021 онд 3185 иргэнд 7.5 тэрбум төгрөгийг, 2022 онд 5598 иргэнд 26.9 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна. 2020-2022 онд нийт 12057 иргэнд 40.7 тэрбум төгрөгийг олгож, 2023 оны байдлаар эргэн төлөлт сайн байгаа хэдий ч хугацаандаа зээлээ төлөхгүй, хугацаа хэтэрсэн өр үүсгэсэн 4.6 тэрбум төгрөг байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтнууд өрийг төлүүлэхээр ажиллаж байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийн хэрэгжилтийг хангуулахад нийгмийн түншлэгч талуудтай хамтран ажиллах хүрээнд ХНХЯам, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гишүүд, нийгмийн түншлэлийн холбогдох төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-ний хэрэгжилтийн явцтай танилцаж, 2023 оны 10-11 сард Дорнод, Хэнтий, Завхан, Архангай, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Булган, Хөвсгөл, Төв аймгуудад ажиллаж Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүд, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, хөтөлбөрт хамрагдаж дэмжлэг авсан иргэдтэй уулзаж холбогдох зөвлөмж гаргасан.<br>Мөн ХХҮЕГ-ын даргын А/44 дугаар тушаалаар Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн ХХҮГ-т 2022 онд ХЭДС-ийн төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийж холбогдож зөвлөмж гаргаж, зөвлөмжийг 2024 оны үйл ажиллагаа /хөтөлбөр/-нд тусгахаар санал гарган ажилласан. | |
| 101. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн хуваарийн тооцоо судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулан, төсвийн хуваарийг батлуулна.<br>*/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль 24.1/* | Үйл ажиллагааны зардал | -Төсвийн төсөл - 1<br>-Тушаал - 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны төсвийн төсөл боловсруулагдсан. | -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн төслийг боловсруулсан байна<br>-ХЭҮЗ-ийн саналыг үндэслэн ХЭДС-ийн 2024 оны төсвийн хуваарийг батлуулсан байна. | Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үр дүнд суурилсан бодлого, төсвийн төлөвлөлт ба иргэн төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хэрэгжүүлэх салбарын албан хаагчдыг сургах сургагч багш бэлтгэх” сургалтыг 2023 оны 6 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Салбарын сургагч багшийг бэлтгэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтөөр төлөвлөж гүйцэтгэх бэлтгэл ажлыг хангах зорилготой энэхүү сургалтад аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнээс бүрдсэн 160 гаруй албан хаагч оролцож, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн саналыг урьдчилсан байдлаар боловсруулж, саналыг нэгтгэж дуусгасан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төслийг үр дүнд суурилсан бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчмын дагуу боловсруулсан болно. Төсвийн тухай хуулинд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд нэгтгүүлэн, хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлэв.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан 2024 онд 107.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 оны 11 дүгээр сарын 30, 12 дугаар сарын 01-ны өдрүүдэд Удирдлагын академи дээр ХХҮЕГ-ын дарга, 21 аймаг 9 дүүргийн ХХҮГ, хэлтсийн дарга, хөдөлмөрийн асуудал хариуцсан албадын дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-т хэлэлцүүлэг хийж, санал авч, саналыг эцсийн байдлаар гаргаж ХЭҮЗ-өөр хуралдуулахад бэлэн болгоод байна. | |
| 102. | “Шинэ технологи (финтек) ашиглан цахим хэлбэрээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийг олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ХЭДС<br>1.0 тэрбум. төг. | Гэрээ - 1 | Үнэлгээний хороо 2022 оны А/178 тоот тушаалаар батлагдсан. | -Банк, санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулсан байна.<br>-Дамжуулан зээлдүүлэх банк, санхүүгийн байгууллагатай гэрээ байгуулж, санхүүгийн дэмжлэгийг иргэн, аж ахуйн нэгжид олгосон байна. | ХХҮЕГ-ын даргын 2023 оны А/76 дугаар тушаалаар финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийг цахимаар дамжуулан олгох санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж Энт кредит инвестмент ББСБ шалгарч ХХҮЕГ-ын 2023 оны ХХҮЕГ/24 тоот гэрээ байгуулан үйлчилгээг Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 5356 иргэнд 2,456,690,000 төгрөгийн зээл олгосон байна. Үүнээс Улаанбаатар хотод 4112 иргэнд 1,862,230,000 төгрөг, Дархан-Уул аймагт 1244 иргэнд 594,460,000 төгрөгийн зээл олгосноос 400,000 мянган төгрөгийг 4075 иргэнд, 600,000 төгрөгийг 1015 иргэнд, 800,000 төгрөгийг 252 иргэнд, 1,000,000 төгрөгийг 14 иргэнд олгосон байна. Цаашид Хур болон бусад систем ашиглан иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгч гэдэг мэдээллээ оруулан зээлээ шууд судлуулах боломжтой байхаар программ хөгжүүлэлт хийгдэж байна. | 100 |
| 103. | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих, жижиг зээлийн хүүг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2.5.14/* | ХЭДС<br>20.0 тэрбум төг. | Гэрээ- 2 | Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд 2022 оны 10 дугаар | -Дамжуулан зээлдүүлэх банкийг сонгон шалгаруулсан байна. -Дамжуулан зээлдүүлэх банктай гэрээ байгуулж, | Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сарын байдлаар 1433 хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдэд 12.7 тэрбум төгрөгийн жижиг зээл олгож, 2800 гаруй ажлын байрыг дэмжсэн. | хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгосон байна. | нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.<br>Дээрх журмын 2.18-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/93 дугаар тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг дамжуулан олгох банкийг сонгон шалгаруулах удирдамж”-ийг баталсан бөгөөд уг удирдамжид заасны дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өөрийн эх үүсвэрээс /20.0 тэрбум төгрөг/ бага хүүтэй, жижиг зээлийг 2023 оны 2 дугаар сараас эхлэн олгож байна. Уг зээлийг аймаг, орон нутагт жилийн 4.4 хувийн хүүтэй Төрийн банкаар, Улаанбаатар хотод жилийн 8.5-8.8 хувийн хүүтэй Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкуудаар дамжуулан олгож байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 881 иргэнд 20.2 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгож 1859 ажлын байрыг бий болгох, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна. | |
| 104. | Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээг зохион байгуулна. | ХЭДС<br>426.1 сая.төг | Арга хэмжээ -1 | Хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлын үнэлгээ хийх үйлчилгээнд 2022 онд 14 мянга иргэнийг хамруулаад байна | Хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлын үнэлгээнд нийт 50 мянган иргэнийг хамруулж, холбогдох дэмжлэг, үйлчилгээг үзүүлсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн цахим систем /ejob/ шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан 2023 онд Мэдээллийн технологийн төв, Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн нэгжтэй, Ай Ти Зон ХХК-тай хамтран Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэдээллээр хангах үйлчилгээ, Хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээ хийх үйлчилгээг үзүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын албан хаагчдыг мэргэжилт арга зүйн удирдлагаар хангаж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хяналт тавих талаар үе шаттай цахим болон танхимын сургалтыг 6 удаа зохион | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж давхардсан тоогоор 600 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан.<br>Үйлчлүүлэгч төвтэй аргачлалыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлж эхэлсэнтэй холбогдуулан ажилгүй болон ажил хайгч, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэнийг хувь хүний хэрэгцээнд үндэслэн профайлинг буюу хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх зорилт тавин улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Дээрх үйлчилгээг хэрэгжүүлэхээр 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Монгол Улсад ажилгүй байгаа нийт иргэдийн ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодруулах, мэдээллийн сан үүсгэх зорилгоор нийт 50 мянган ажилгүй иргэнд хөдөлмөр эрхллэтийн бэлэн байдлын үнэлгээг хийх хүрээнд 2022 онд 14 мянган иргэнд, 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 17 мянган иргэнд, нийт 31 мянган иргэнд хөдөлмөр эрхлэлтйн бэлэн байдлын үнэлгээг хийж хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх төлөвлөгөө гарган төлөвлөгөөг нь хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна. | |
| 105. | Ажил олоход хүндрэлтэй иргэнийг урт хугацаанд тогтвортой ажлын байраар хангах ажил олгогчид цалингийн дэмжлэг үзүүлнэ.<br>*/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль 6.1.2/* | ХЭДС<br>15.6 тэрбум төг. | Холбогдох шийдвэр-1 | шинээр хийх ажил | 5000 хүнийг тогтвортой ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид цалингийн дэмжлэг үзүүлсэн байна. | 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд тусгагдсан Ажил олоход хүндрэлтэй иргэнийг урт хугацаанд тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчид цалингийн дэмжлэг үзүүлэх тухай" арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцээд тусгайлсан хөтөлбөр боловсруулан батлуулсан.<br>Ажил олгогчийг дэмжих туршилтын төслийн журмыг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар танилцуулж Засгийн газарт танилцуулах зөвлөмжийг гаргасан.<br>Үүний дагуу энэхүү туршилтын төслийг Засгийн газарт 2023 оны 10 дугаар сарын 11-нд | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулснаар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт чиглэл хүргүүлсэн. Уг арга хэмжээний зардлыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тусгаж 5200 хүнийг хамруулахаар ажиллаж байна. 21 аймаг 9 дүүргийн ХХҮГ, хэлтсүүдийн хөдөлмөрийн асуудал хариуцсан хэлтэс, албадын дарга болон мэргэжилтэнгүүдтэй энэхүү арга хэмжээний талаар цахимаар сургалт зохион байгуулж ажилласан. | |
| 106. | Нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулна.<br><br>*/АХШХтХууль 21.5/* | НҮБХХ<br>10.0 сая.төг | -Засгийн газрын тогтоол-1<br>-Тушаал -1 | шинээр хийх ажил | Салбар дундын ажлын хэсэг байгуулж, гишүүд, оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, оролцогч талуудтай зөвшилцөн Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна. | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасны дагуу “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Монгол Улсад 2023-2025 онуудад шаардлагатай нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг аж үйлдвэрийн IV хувьсгал, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн динамик өөрчлөлт, олон улсын хөдөлмөрийн чиг хандлага болон өмнөх жилүүдийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажиллах хүчний статистик мэдээлэл болон “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гадаадаас авч ажиллуулах зайлшгүй шаардлагатай нарийн мэргэшлийн мэргэжилтний талаарх судалгаа зэрэгт тулгуурлан, холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн дэргэдэх 35 гаруй мэргэжлийн зөвлөлүүд, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон бусад оролцогч талуудаас саналуудыг нэгтгэн боловсруулж, яамдуудаас санал авч 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 359 дүгээр тогтоолоор 11 эдийн засгийн ангиллын 130 нарийн мэргэшлийн жагсаалтыг батлуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг баталснаар уг жагсаалтад заасан мэргэшлийн гадаад ажилтанг авч ажиллуулахад Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.9-д заасан зөвшөөрлийг нэмэлт шаардлагагүй авах эрх зүйн орчин бүрдсэн. | |
| 107. | Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт /тарифаар тооцож/ олгох журам болон тарифийг шинэчлэн боловсруулж, батлуулна.<br><br>*/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль 6.1.1/* | НҮБХХ<br>3.0 сая төг. | -Журам-1<br>-Тушаал -1 | Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж санхүүжилт /тарифаар тооцож/ олгох журмыг Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/123 дугаар тушаалаар баталсан. Хөдөлмөрийн хувийн биржид санхүүжилт олгох тарифийг тогтоох тухай Хөдөлмөрийн сайдын 2016 оны 05 сарын 06-ны өдрийн А/117 тоот тушаалаар баталсан. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг хувийн биржээр гүйцэтгүүлэх журмыг боловсруулан батлуулсан байна. Хөдөлмөрийн хувийн биржид санхүүжилт олгох тарифыг шинэчлэн тогтоож батлуулсан байна. | Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн хүрээнд Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагааг сайжруулах ажлыг 2023 оны төслийн төлөвлөгөөнд тусгасан. Энэ ажлын хүрээнд хөдөлмөрийн хувийн биржээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарим үйл ажиллагааг гүйцэтгүүлэх, санхүүжилтийн механизмыг сайжруулах, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 88, 181 дүгээр конвенциудад нийцүүлэхэд хамтран ажиллаж байна.<br>-Хөдөлмөрийн биржийн сарын мэдээ тайланг шалгаж, санхүүжилт олгох үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд хөдөлмөрийн хувийн биржээр дамжуулан үзүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг 2023 оны 11 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр авч үзвэл:<br>Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгсөн: 6698<br>Бүлгийн зөвлөгөө өгсөн: 940 бүлэг<br>Ажилд зуучилсан хүний тоо: 1102<br>3 сар тогтвортой ажилласан иргэн: 351<br>6 сар тогтвортой ажилласан иргэн: 206<br>12 сар тогтвортой ажилласан иргэн: 216<br>Нийт олгосон санхүүжилт: 451,157,000 төгрөг зарцуулсан байна.<br>“Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл-тэй хамтран хувийн хөдөлмөрийн биржтэй холбоотой үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дотоодын зөвлөх авч ажиллуулж байна. Энэ хүрээнд:<br>1. Төрийн хөдөлмөрийн алба болон Хувийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн албадтай хамтран үр дүнтэй ажилласан талаар судлан, Монгол Улсын нөхцөлд нэвтрүүлж болох хувилбарыг боловсруулах, хамтран ажиллах байгууллагын зохион байгуулалт, зохицуулалт, санхүүжилтийн болон тайлагналтын механизмыг одоогийн www.ejob.gov.mn платформын ажлын горимд нийцүүлэн боловсруулж хувийн биржүүд тус системийг ашиглан бүртгэл мэдээллээ оруулсны үндсэн дээр санхүүжилтийг олгож байна.<br>2. Хувийн бирж нь I)Хувийн хөдөлмөрийн биржид тавигдах олон улсын стандартыг хангаж буй эсэх, II) санал болгож буй хувилбарыг гүйцэтгэхэд үйл ажиллагаа явуулж буй хувийн хөдөлмөрийн албадын чадавхийн бэлэн байдлын үнэлгээг хийж чадавхижуулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна.<br>3. Төрийн болон хувийн хөдөлмөрийн албад иргэдэд үйлчилгээ хүртээмжтэй, үр дүнтэй хүргэх тал дээр харилцан, хамтран ажиллах боломжуудын талаар оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж “Хөдөлмөрийн хувийн биржүүдийг бүртгэх, санхүүжилт олгох журам”-ын төсөл, “Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржүүдийн үйл ажиллагаанд тавигдах шалгуур үзүүлэлт тогтоох аргачлал”, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага”-ын нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсрууллаа. Мөн хөдөлмөрийн хувийн биржид санхүүжилт олгох тарифийг шинэчлэн тогтоох судалгааг зөвлөх баг болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институттэй хамтран холбогдох тооцоо судалгааг боловсруулсан бөгөөд, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн хуваарийг хэлэлцэн батлах үед зардлын тооцоо жишиг үнийг танилцуулах болно.<br>4. Түүнчлэн хөдөлмөрийн хувийн биржүүдтэй хамтран ажиллах талаар холбогдох заалт, зохицуулалтыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусгасан бөгөөд тус хуулийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар Хууль, зүй дотоод хэргийн яаманд 12 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн болно. | |
| 108. | Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загварын хөгжүүлэлтийг дуусган, салбар дундын бодлогын уялдаа холбоог сайжруулна. *<br>/Алсын хараа-2050 2.6.4, МУЗГҮАХ 2020-2024 2.5.4/* | ХЭДС<br>70.0 сая төг. | -Зөвлөмж -1<br>-Арга хэмжээ-1 | ХНХЯ-наас хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг удирдах болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, зохицуулалтын шийдвэр гаргахад статистик мэдээлэлд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй, ирээдүйд бий болох үр дүнгийн тооцоо, судалгаатай байх боломжийг хангахад зориулсан “Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ыг боловсруулж, туршилтаар ажиллуулж эхлүүлсэн. | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, тооцооллыг хийж, БШУЯ, ХХАХҮЯ, БХБЯ, УУХҮЯ болон бусад холбогдох яамдад зөвлөмж хүргүүлсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загварын хөгжүүлэлтийн ажлын хүрээнд эдийн засгийн салбаруудыг мал аж ахуй, газар тариалан, худалдаа үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилгын үйлдвэрлэл, уул уурхайн үйлдвэрлэл, дулаан ба цахилгаан үйлдвэрлэл гэсэн 7 салбараар симуляци хийхийн тулд Кобба-Дугласын үйлдвэрлэлийн функцийг ашигласан. 2050 хүртэлх хугацааны дараах таамаглалуудыг тооцоолсон байна. Тухайлбал: Монгол Улсын хүн ам, дундаж наслалт, 1 хүнд ноогдох ДНБ, нийт ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин, тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага, тэтгэврийн даатгалын сан, тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлого, тэтгэврийн даатгалын сангийн бусад орлого, албан журмаар даатгуулагчид, сайн дурын даатгуулагчид, тэтгэвэр авагчийн тоо, цэргийн алба хаагчийн тэтгэвэр авагчийн тоо, ҮОМШӨ-ний тэтгэвэр авагчийн тоо, өндөр насны тэтгэвэр авагчийн тоо зэрэг болно.<br>Манай яамнаас Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд 5-10 жилийн хугацаанд шаардагдах эрэлттэй ажил, мэргэжлийн судалгааг олон улсын арга, аргачлалын дагуу хийхээр гадаад, дотоодын зөвлөх баг шалгаруулж, судалгааны ажлыг эхлүүлээд байна. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн дунд хугацааны таамаглалыг олон улс болон хөдөлмөрийн чиглэлээр мэргэшсэн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэгч байгууллагуудын арга аргачлал, загварыг судлан харьцуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, загварын дагуу уг таамаглалыг боловсруулах зорилготой “Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал боловсруулах” ажлыг зөвлөх үйлчилгээний баг Эм Эм Си Жи ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байна. Зөвлөх баг урьдчилсан тайланг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр танилцуууллаа. Үүнд:<br>- Хөдөлмөр эрхлэлтийг таамаглах загварын мэдрэмжийн коэффициентуудыг хүн амын шинэчилсэн тооцоололд үндэслэн дахин нягталж, тооцооллын найдвартай байдлыг шалгаж эхний үр дүнгийн уулзалтанд шаардлагатай дата мэдээлэл, тооцооллыг боловсруулсан.<br>- ДНБ-ний таамаглалд суурилан салбарын бүтцийг тодорхойлох, өгөгдлийг салгаж, засварлаж бэлтгэх ажлын датаг засварлаж бэлэн болгосон. Монгол улсын салбар хоорондын тэнцлийн мэдээлэл дээр тулгуурлан Леонтьевийн аргаар хэтийн тооцоо хийх ажлын датаг 2019 оны байдлаар бэлтгэж тооцоолол хийхэд бэлэн болгосон.<br>- Аймгуудын датаг шахаж тэдгээрийн ДНБ-ий тооцооллыг хийхэд бэлэн болгосон. Шилжилт хөдөлгөөний датаг шалгасан.<br>- Эдийн засгийн салбараарх ажил мэргэжлүүдийн 2035 он хүртэлх трендийг гаргаад, жил бүрийн салбар ажил мэргэжлийн матрицийг тооцоолсон. Тус матриц нь эдийн засгийн 19 салбар, 10 гол ажил мэргэжлийн ерөнхий ангиллаар хийгдсэн болно.<br>Цаашид зөвлөх баг 2023 оны 12 дугаар сарын 06-15-ны өдрийн хооронд Хөдөлмөрийн зах зээлийн таамаглалын дундын тайланг танилцуулж энэ ондоо багтаан эцсийн үр дүнг боловсруулан, хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | |
| 109. | Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг хэрэгжүүлэхэд бодлого арга зүйн удирдлагаар хангаж, ажиллана.<br>*/”Алсын хараа-2050” 3.1.14, МУЗГҮАХ 2.5.9.1/* | ХЭДС<br>6.0 тэрбум төг. | Хамрагдах оролцогчийн тоо – 1000 хүртэл | 2021 онд 2328 залуучууд хамрагдсан.<br>2022 онд 1218 | “Оролцоо” төслийн бүхий л үйл ажиллагааг удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллах. Монгол Улсын хэмжээнд 1000 оролцогчийг | Залуучуудад эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт зохион байгуулж, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, ажилтай, орлоготой болгох зорилготой “Оролцоо” төслийг 2023 онд хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/62 дугаар тушаалаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамруулж, ажлын байран дээрх дадлагад 70 хүртэлх хувийг хамруулсан байна. | байгуулж, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжийг дээрх тушаалаар батлуулан, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Батлан хамгаалах яамтай хамтран “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдаж буй 1500 оюутан, залуучуудыг хамруулж, “Оролцоо” төслийн сургалтын үндсэн агуулга болох хувь хүний хөгжил, манлайлал, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар /soft skills/, хөдөлмөрт бэлтгэх чиглэлийн хичээлүүд болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын агуулгыг зааж 2.0 тэрбум төгрөгийг зарцуулав. | |
| **3.2.ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ, БОДЛОГО, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨРИЙН ХУВИЛБАР, ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.5-ЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***3.2.1. Хувийн хэвшлийн цалин хөлсний тогтолцоо, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн норм нормативын асуудлаар санал боловсруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;*** | | | | | | | |
| 110. | “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08”-д шаардлагатай ажил, мэргэжлээр нэмэлт, өөрчлөлт оруулна. | Үйл ажиллагааны зардал | Сайдын тушаал-1 | ХНХ-ын сайдын 2022 оны А/143 дугаар тушаал | Салбарын яамдаас ХНХ-ын сайдын 2019 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан аргачлалд заасан холбогдох шаардлагыг хангаж ирүүлсэн ажил, мэргэжлээр ҮАМАТ-08-д нэмэлт, өөрчлөлт оруулж, ХНХ-ын сайдаар батлуулсан байна. | ХНХ-ын сайдын 2019 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу холбогдох бүрдлийг хангуулан, архивын ерөнхий газартай уулзаж, зөвшилцсөний үндсэн дээр архив, түүнтэй холбогдох ажил, мэргэжилд ХНХ-ын сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны А/175 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулав.<br>Хууль сахиулах, дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлийн ажил, мэргэжлийн ангилалд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бэлтгэж байна. | 100 |
| 111. | Үндэсний индекс/кодоор үүсгэсэн 100-аас доошгүй ажил, мэргэжлийг сонгон авч тодорхойлолт, чиг үүрэг зэрэг холбогдох мэдээллийг боловсруулж, ҮАМАТ-08-ын цахим системд цэс үүсгэн | Үйл ажиллагааны зардал | 100-аас доошгүй ажил, мэргэжлийн тодорхойлолт, мэдээлэл | Зарим ажил, мэргэжлийн тодорхойлолтууд боловсруулагдаагүй байна. | 100-аас доошгүй ажил, мэргэжлийн тодорхойлолтыг боловсруулж, ҮАМАТ-08-ын цахим системд оруулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/210 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон нийт 102 ажил мэргэжлээр тодорхойлолт боловсруулан гаргалаа. ҮАМАТ-08-ын цахим системд ажил мэргэжлийн тодорхойлолтыг оруулах шинэ цэс нэмэх, цахим системд зарим сайжруулалт, өөрчлөлтийг хийлгэх Ажлын даалгавар боловсруулан Дэлхийн банкны | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулах ажлыг эхлүүлнэ. | | | | | санхүүжилтээр хэрэгжиж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-д хүргүүлсэн. | |
| 112. | Үйлчилгээний зарим ажил мэргэжлээр салбар дундын хөдөлмөрийн жишиг норм, нормативын төсөл боловсруулна. | Үйл ажиллагааны зардал | Сайдын хамтарсан тушаал-1 | Хөдөлмөрийн норм, норматив боловсруулах аргачлал Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 тогтоол | Үйлчилгээний зарим ажил, мэргэжлээр хөдөлмөр зарцуулалтын нормативт хэмжээг судлан ажлын ачааллыг тооцож, ХНХ-ын болон ХХААХҮ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлуулсан байна. | Албан газар, оффисын үйлчлэгчийн ажлын ачааллыг тооцох судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээр гүйцэтгүүллээ. Судалгааны үр дүнд үндэслэн албан газар, оффисын үйлчлэгчийн хөдөлмөрийн жишиг норм, нормативын төслийг боловсрууллаа. Судалгааг гүйцэтгэхдээ Хөдөлмөрийн норм, норматив боловсруулах аргачлалд суурилсан болно. Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүргийн нийт 29 байгууллагын цэвэрлэгч /үйлчлэгч/, хүний нөөц болон удирдах албан тушаалтан хамрагдсан. Үүнд<br>Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар, 2, 23, 117-р сургууль, ХНХЯ-ны харьяа байгууллага – ХХҮЕГ, ХБХХГ, НДЕГ, ГБХЗХГ, ХНХСҮСИ болон төрийн өмчит, төсөвт байгууллагуудын нийт 41 үйлчлэгч хамрагдаж, ажлын байрны зураг авалт, судалгаа хийсэн.<br>Ажлын байрны судалгаа нь тухайн албан тушаалтны ажлын цагийн ашиглалт, үр ашигтай зарцуулалт, ажлын ачаалал, ажлын цагийн алдагдлыг илрүүлэн түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, хөдөлмөрийн зохион байгуулалтыг судалж, дүгнэх зорилгоор хийгддэг, хийсэн судалгаа бүрийн дараа тухайн байгууллагын үйлчлэгч нартай ярилцлага хийсэн судалгааны үр дүнг танилцуулсан. Нэгдсэн хэлэлцүүлэг хийхгүй. Албан газар, оффисын үйлчлэгчийн хөдөлмөрийн жишиг норм, нормативын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулахаар бэлтгээд байна. Жишиг нормативийг аж ахуйн нэгж, байгууллагууд үйлчлэгчийн ажлын ачаалал тооцох, хүний нөөцийг төлөвлөхдөө жишиг, арга зүй байдлаар ашиглах боломжтой. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **4.1.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХУУЛЬ ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.8-ЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***4.1.1.Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, олон нийттэй харилцах зорилтын хүрээнд:*** | | | | | | | |
| ***Хөжглийн бодлогын урт , дунд, богино хугацааны баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайлан гаргах:*** | | | | | | | |
| 113. | Бодлогын баримт бичгүүдэд хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний тайлан гаргах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын хэрэгжилтийн явцын Тайлан-1; | 2021 оноос эхлэн хэрэгжиж байна. 2021 онд 1 тайлан, 2022 онд хагас, бүтэн жилээр 2 удаа гаргасан. | Тайлан-2 | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн Хүний хөгжлийн 24 зорилтын 30 шалгуур үзүүлэлт, Амьдралын чанар ба дундаж давхаргын 20 зорилтын 20 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган, ХШҮДАГ-т хүргүүлэв. | 100 |
| | | | “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2023 оны хэрэгжилтийн тайлан-1; | Тайлан-1 | Тайлан-1 | “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны бодлогын баримт бичигт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн 24 арга хэмжээний биелэлтийг бүтэн жилээр гарган, ХШҮДАГ-т хүргүүлэв. | |
| | | | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын Тайлан-12; | 2022 онд 6 дугаар сараас эхлэн сар бүр нийт 8 удаа тайлан гаргасан. | -Тайлан-12 | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн нийт 18 зорилт, 47 арга хэмжээний биелэлтийг сар бүр нэгтгэн боловсруулж, үнэлгээ хийлгүүлэхээр тус яамны ХШҮДАГ-т хуулийн хугацаанд хүргүүлэв.<br>Мөн түүнчлэн 2022 оны жилийн эцсийн биелэлтээр хэрэгжилт удаашралтай байгаа 10 арга хэмжээг /2.5.3, 2.5.4, 2.5.5.3, 2.5.7.1, 2.5.8.1, 2.5.8.5, 2.5.8.9, 2.5.8.9.2, 2.5.9.2, 2.5.12/ 2023 оны төлөвлөгөөнд нэмж тусган, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч байна. | |
| | | | Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний | Тайланг 2021 онд 2 удаа, 2022 онд 6 дугаар сараас эхлэн сар бүр нийт | -Тайлан -12;<br>-13 төсөл, арга хэмжээ | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн нийт 6 зорилтын 9 арга хэмжээний биелэлтийг 2023 онд сар бүр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | биелэлтийн Тайлан -12;<br>-13 төсөл, арга хэмжээ. | 8 удаа гаргасан. | | нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлэв. Үүнд:<br>-Хүний хөгжлийн бодлогын 5 зорилтын 7 арга хэмжээ;<br>-Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлогын 1 зорилтын 2 арга хэмжээ байна. | |
| ***Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэх, хэрэгжилтийн тайлан гаргах:*** | | | | | | | |
| 114. | Дээд газраас ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэн, хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардал | -Тайлан -12;<br>-ЗГХЭГ-ын ХШҮДАГ-аас ирүүлсэн жагсаалтын дагуу биелэлт гаргах | -2022 онд нийт 9 тайлан гаргасан. Үүнд:<br>-2022 оны 6-р сараас эхлэн сар бүр нийт 6 удаа гаргасан.<br>-Дээд байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 3 тайлан нэмэлтээр гаргасан. | -2023 оны Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, УИХ, ЗГ-ын тогтоол, ЗГХ-ны тэмдэглэл, Албан даалгаврыг програмд бүртгэн, хяналтын карт нээж, Сайд, дэд сайд, ТНБДаргад танилцуулан, цохолтын дагуу холбогдох газрын даргад хүргүүлсэн байна.<br>-Тайланг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | 1/ 2023.12.06-ны байдлаар нийт 174 тогтоол шийдвэрийг цахимд бүртгэн, хяналтад авсан. Үүнд:<br>УИХ-ын БХ-ны тогтоол 1;<br>Засгийн газрын тогтоол 79 ;<br>Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 80;<br>МУ-ын Ерөнхий сайдын захирамж 13;<br>Албан даалгавар 1;<br>-УИХ, ЗГ-ын 2022 оны тогтоол шийдвэрүүдээр архивын нэгж үүсгэн, 2 боть архивт хүлээлгэн өгсөн.<br>2/ 2023 онд нийт 15 удаа тайлан гаргасан. Үүнд:<br>1/2023 онд сар бүр буюу 12 удаа гаргасан.<br>2/Нэмэлтээр нийт 3 удаа 698 заалт, арга хэмжээний биелэлт гаргасан. Үүнд:<br>-3 дугаар сард 195 арга хэмжээ /ЗГХЭГ-т/,<br>-5 дугаар сард 46 арга хэмжээ /ЕСайдын үүрэг даалгавар-ЦХХХЯ-нд/,<br>-10 дугаар сард 351 заалт, арга хэмжээ /ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газарт/<br>3/ Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилээр нийт 292 заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд багтаан ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>4/Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт .... заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд багтаан ХШҮДАГ-т хүргүүлэв.<br>Үүнд:<br>МУ-ын ...хуулийн ... заалт;<br>УИХ-ын ... тогтоолын ... заалт;<br>УИХ-ын байнгын хорооны .... тогтоолын .... заалт;<br>Ерөнхийлөгчийн ... зарлигийн .. заалт;<br>Засгийн газрын ... тогтоолын ... заалт;<br>Ерөнхий сайдын ... захирамжийн ... заалт; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засгийн газрын хуралдааны ... тэмдэглэлийн ... заалт;<br>• ЗГ-ын ... албан даалгаврын ... заалт. | |
| ***ХНХЯ-ны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, УХО-ын хөтөлбөрийн хэрэгжилт гаргах:*** | | | | | | | |
| 115. | ХНХЯ-ны 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангуудыг гаргах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | -ХНХЯ-ны 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн Тайлан-1;<br>-2022 оны зорилтот түвшингийн гүйцэтгэлийг үзүүлэлт тус бүрээр гаргана. | Жил бүр тайлан гаргадаг. | Тайланг нэгтгэн боловсруулж, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн байна. | Засгийн газрын 2022 оны .. дугаар тогтоолоор баталсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийт 20 үзүүлэлтийн биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-аар үнэлгээ хийлгэв.<br>Эдийн засаг, нийгмийн хөгжлийн 20 үзүүлэлтийг чиглэлээр нь авч үзвэл:<br>• Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсролын 4 үзүүлэлт;<br>• Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн 7 үзүүлэлт;<br>• Хөдөлмөрийн харилцааны 2 үзүүлэлт;<br>• Хүн ам, гэр бүлийн хөгжлийн 7 үзүүлэлт байна. | 100 |
| | | | -ХНХ-ын салбарын ТЕЗ-ийн 2022 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний хүрсэн үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийн Тайлан-1<br>-Үзүүлэлт тус бүрээр гаргана. | Жил бүр тайлан гаргадаг. | Тайланг нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, түүний хүрсэн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>-Тус хөтөлбөрт тусгагдсан нийгмийн халамжийн 3, нийгмийн даатгалын 3, нийгмийн бүлэгч чиглэсэн хөтөлбөрийн 7, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах 2, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлагын 2 арга хэмжээ тус бүрийг 2022 оны зорилтот түвшин, хүрсэн түвшин, батлагдсан төсөв болон гүйцэтгэл гэсэн үзүүлэлтүүдээр гаргав. | |
| | | | -Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтийн Тайлан-1<br>-Төсөл тус | Жил бүр тайлан гаргадаг. | Тайланг нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | -Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багцад батлагдсан 40 төсөл арга хэмжээний, 24 төсөл арга хэмжээ шинээр хэрэгжихээр батлагдсан. Худалдан авах ажиллагаа амжилтгүй болж гэрээ хийгдээгүй байсан 5 арга хэмжээ Монгол Улсын 2022 оны өөрчлөлт оруулах тухай хуулиар хасагдаж нийт 19 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. Шинээр хэрэгжих 19 төсөл арга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрээр гаргана. | | | хэмжээний худалдан авах ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдаж тухай бүр хэрэгжилт үр дүнгийн тайлан мэдээг Сангийн яаманд хүргүүлж, tender.gov.mn цахим системд байршуулсан. Нийт 19 төсөл арга хэмжээний 10 төсөл арга хэмжээн төрийн худалдан авах ажиллагаа болон аймаг нийслэлийн засаг дарга нарт эрх шилжин хэрэгжсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газар дээр зохион байгуулагдсан.<br>-Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаман дээр худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан 9 төсөл арга хэмжээний 7 нь гүйцэтгэгчтэй гэрээ байгуулагдан хэрэгжиж байна. "Олон улсын Хүүхдийн Найрамдал-2 зуслан" цогцолбор төсөл /Хөвсгөл, Хатгал сум/ төсөл арга хэмжээ нь зураг төсөв дуусаагүй шалтгааны улмаас тендер шалгаруулалт удааширч гүйцэтгэгч шалгараагүй байна.<br>-Нийт салбарын худалдан авах ажиллагааны хэрэгжилт 84.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. | |
| ***Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг гаргах:*** | | | | | | | |
| 116. | Яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, түүний хэрэгжилтийн тайланг гаргах ажлыг зохион байгуулна.<br><br>*/ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 4.3./* | Үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөө-1, | Шинэ загварын дагуу гарган Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | -Төлөвлөгөөг МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичиг /урт, дунд, богино хугацааны/ холбогдох хууль тогтоомж болон салбарын стратеги төлөвлөгөөтэй уялдуулсан байна.<br>-Төлөвлөгөөнд газруудын саналыг тусган, Сайдын зөвлөлд танилцуулан, хэлэлцүүлж, Төрийн нарийн | -ХНХЯ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тоот тушаалын 3 дугаар хавсралтын дагуу боловсруулж, газруудын саналыг тусган, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэв.<br>-ХНХЯ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, “Алсын хараа-2050” зэрэг бодлогын баримт бичигт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээтэй уялдуулав.<br>-Яамны үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд 207 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөв. Үүнд**:**<br>• Бодлогын баримт бичигт тусгагдсан 55 арга хэмжээ;<br>• Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 44 арга хэмжээ;<br>• Хуулиар олгосон чиг үүргийг үүргийг | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгийн дарга баталсан байна. | хэрэгжүүлэх 13 арга хэмжээ<br>• Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 76 арга хэмжээбайна.<br>• Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 19 арга хэмжээ. | |
| | | | -Тайлан-1 | **Тайланг** хагас, бүтэн жилээр ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу боловсруулна. | Тайланг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | ХНХЯ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж, удирдлагад танилцуулан, ХШҮДАГ-т хүргүүлэв. Эхний хагас жилийн байдлаар нийт 191 арга хэмжээний биелэлтийг, жилийн эцсийн байдлаар нийт 207 арга хэмжээний биелэлтийг гаргав.<br>Хэрэгжилт удаашралтай байгаа болон хугацаа болоогүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын Дотоод албан бичгийг төлөвлөн 2023.10.24-ний өдөр бүх газрын дарга нарт хүргүүлсэн. | |
| 117. | Байгууллагын ил тод байдлын хэрэгжилтийг гаргах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | -Тайлан-1<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу гаргана. | Жил бүр гаргадаг. | Тайланг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны жилийн эцсийн ил тод байдлын нийт 5 чиглэлийн, 46 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн тайланг 2023 оны 3 дугаар сард боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлэв.Үүнд:<br>-үйл ажиллагааны 10;<br>-хүний нөөцийн 6;<br>-төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн 15;<br>-үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн 2;<br>-бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 13 арга хэмжээ тус бүрээр гаргав. | 100 |
| 118. | ХНХЯ-ны 2023 оны сар бүрийн үйл ажиллагааны тайланг боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | -Тайлан -12<br>-Хуулийн хугацаанд гарган “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” (www.unelgee.gov.mn)-д хугацаанд нь байршуулж | 2022 онд 1-12 сарын 12 тайланг тухай бүр гарган, (www.unelgee.gov.mn)-д хугацаанд нь байршуулж баталгаажуулсан. | ХНХЯ-ны 2023 оны 1-12 сарын үйл ажиллагааны тайланг гарган, “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” (www.unelgee.gov.mn)-д хугацаанд нь байршуулж | 2023 оны 1-12 сарын үйл ажиллагааны тайлангуудыг тухай бүр нэгтгэн боловсруулж, ЗГ-ын ХШҮ-ний цахим системд хуулийн хугацаанд багтаан байршуулж, баталгаажуулав.<br>Тайланг хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлого төлөвлөлтийг сайжруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, санхүү, хөрөнгө оруулалт, дотоод ажил, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн 6 чиглэлээр, гүйцэтгэсэн ажлыг тулгамдсан болон хоцорч буй ажил, УИХ, ЗГ-т өргөн барьсан, салбарын хүрээнд хийгдсэн болон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | баталгаажуулна. | | баталгаажуулсан байна. | шинэлэг ажил гэсэн 4 төрлөөр тус тус гарган хүргүүлж ажиллав. | |
| ***Хүний нөөцийн хөгжил, шагнал урамшуулал, авлигаас ангид ажиллахтай холбоотой ажлыг зохион байгуулах*** | | | | | | | |
| 119. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангаж, салбарын удирдах ажилтны болон яамны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж мөрдүүлэх | Үйл ажиллагааны зардал | -Төрийн албаны салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт<br>-Албан тушаалын тодорхойлолт | -Төлөвлөгөө, тайлан-жил бүр;<br>-албан тушаалын тодорхойлолт- шаардлагатай албан тушаал | -Төрийн албаны салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байна.<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.<br>-Салбарын удирдах албан тушаалтнуудын болон яамны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж батлуулсан байна. | Төрийн албаны зөвлөлийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр боловсруулан хуралдааныг дэгийн дагуу хуралдуулан, хурлаас гарсан шийдвэрийг 3 хоногийн дотор эцэслэн албажуулан ажиллалаа.<br><br>Энэ онд Салбар зөвлөлийн хуралдаан 13 удаа хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан байна. Үүнд:<br>-Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалга хүргүүлэх тухай;<br>-Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах тухай;<br>-Албан тушаалд нэр дэвшүүлж, санал болгох тухай;<br>-Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2-т заасны дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон харьяа байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр болох ахиулан олгуулах санал авах тухай;<br>-Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-д заасны дагуу Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх болзол хангасан албан хаагчдыг Төрийн албаны тангаргаа өргүүлэх тухай;<br>-Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг батлуулах зөвшөөрөл авахаар ТАЗ-д хүргүүлэх тухай;<br>-Тусгай шалгалтыг хүчингүйд тооцох тухай зэрэг 34 асуудлыг хэлэлцэн, 147 тогтоол батлан, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.<br>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Салбарын хяналтын газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлөөр хянуулж, ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийж Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл хангагдаад байна. Мөн Засгийн газрын 2023 оны 358 дугаар тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэд байгуулагдсан Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга болон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлуулсан.<br><br>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 3.9-т заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн даргын, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын, аймгуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга, аймгуудын Хөдөлмөр, халамжийн үйчилгээний газрын дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн болон шинээр боловсруулан төслийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, эрх бүхий албан тушаалтнаар батлуулах ажлыг зохион байгууллаа. | |
| 120. | Улсын ахлах болон улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шилжин ажиллах албан тушаалтны ажил, албан үүрэгт нийцүүлэн шинэчлэн боловсруулна. *<br>/Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу/* | Үйл ажиллагааны зардал | Шинэчлэн батлуулах албан тушаалын тодорхойлолтын тоо-7 | ТАЗ-ийн 2021.09.29-ний 237 дугаар тогтоолоор баталсан 7 албан тушаалын тодорхойлолтын хүрээнд ажиллаж байсан. | Улсын ахлах болон улсын байцаагчийн 7 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан байна. | Улсын ахлах болон улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шилжин ажиллах албан тушаалтны ажил, албан үүрэгт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2023 оны 4 сарын 03-ны өдөр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 121. | Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан тушаалын сул орон тоог нийтэд зарлан, удирдах албан тушаалд болон шинээр томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох санал гаргах, зэрэг дэв олгуулах | Үйл ажиллагааны зардал | Албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт | Тухай бүр | Албан тушаалын сул орон тоонд холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулсан байна. | Төрийн албаны зөвлөлийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс салбарын хэмжээний төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах комиссыг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тухай бүр байгуулан ажиллалаа.<br>Энэ оны байдлаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны **6,** Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон харьяа байгууллагын **64**, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон харьяа байгууллагын **11,** Нийгмийн даатгалын Ерөнхий газар болон харьяа байгууллагын **43** , Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон харьяа багууллагын **65** нийт **187** сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, тусгай шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.<br>Тусгай шалгалтыг энэ оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.<br>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул орон тоог олон нийтэд мэдээлэх, төрийн жинхэнэ албан хаагч төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс уг албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд **5** хоногийн хугацаанд Зөвлөлийн цахим хуудас, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системээр мэдээллэн ажиллаж байгаа бөгөөд журам батлагдснаас хойш нийт **225** сул орон тооны мэдээллийг салбарын хэмжээнд нэгтгэн нийтэд мэдээлж ажилласан байна.<br>Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Хөгжлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захирал мөн Архангай, Дархан-Уул, Ховд, Дорнод, Дорноговь, Хөвсгөл аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн даргын сонгон шалгаруулалтыг тус тус зохион байгуулав. | |
| | | | Зэрэг дэвийн санал | Тухай бүр | Салбарын хэмжээнд төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулсан байна. | Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан болзол хангасан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон харьяа байгууллагуудын **23** төрийн захиргааны албан хаагчдад Эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулах, Ахлах болон Дэс түшмэлийн зэрэгт хамаарах **108** албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв ахиулах болон шинээр олгох асуудлыг Төрийн албаны зөвлөлийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэр гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. | |
| 122. | Төсвийн ерөнхийлөн захирагчаас харъяа байгууллагын дарга, захиралтай хамтран ажиллах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавина. | Үйл ажиллагааны зардал | Хамтран ажиллах гэрээ | Жил бүр | Төсвийн ерөнхийлөн захирагчаас харъяа байгууллагын дарга, захиралтай байгуулсан Хамтран ажиллах гэрээний биелэлтийг хүлээн авч, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлагууд, байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, албажуулах ажлыг зохион байгуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу 2023 оны Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газраар үнэлүүлэх ажлыг зохин байгууллаа. | 100 |
| 123. | Яамны хүний нөөцийг чадавхижуулах 2023 оны сургалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Яамны хүний нөөцийг чадавхижуулах 2020 оны сургалтын | Жил бүр | Хүний нөөцийг чадавхижуулах сургалтын төлөвлөгөөг батлан, яамны | Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Хүний нөөцийн газар байгуулагдсан бөгөөд уг газраас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэн төрийн бүх шатны байгууллага | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | */ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 4.1./* | | төлөвлөгөө | | нийт албан хаагчдын 40-с доошгүй хувийг гадаадын болон дотоодын цахим сургалт семинар, хурал зөвлөгөөн, танилцах аялалд хамруулсан байна. | мөрдөж ажиллахаар болсон. Уг хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулахад яамны албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг цахимаар зохион байгуулж албан хаагчдын эрэлт хэрэгцээнд тохирсон сургалтуудыг оновчтой зохион байгуулах санал, яамны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлсэн. Яамны албан хаагчдыг мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлэхийн тулд анх томилогдсон үеэс тасралтгүй сургаж, хөгжүүлэх, шатлан дэвшихэд нь тухайн албан тушаалыг эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг, эзэмшүүлэн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 3 албан хаагчийг, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч, дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагч, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5 албан хаагч, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулж улсын төсвийн санхүүжилтээр 9 албан хаагч, байгууллагын санхүүжилтээр 3 албан хаагч, нийт 12 албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна. Мөн цаг үеийн шаардлагад нийцсэн мэдээлэл, мэдлэг, чадварыг шуурхай олгох үүднээс албан хаагчдыг богино хугацааны зорилтот, арга зүйн сургалтад тухай бүр хамруулах ажлыг Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи болон холбогдох бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн. Энэ онд яамны албан хаагчдаас 44 албан хаагч буюу 32 хувь нь эрхэлсэн ажлын чиг үүргийн хүрээнд гадаад улсад зохион байгуулагдаж буй уулзалт, хурал, зөвлөгөөн, сургалт, семинарт хамрагдсан байна. | |
| 124. | Салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (2021-2024 он)-ийн төслийг боловсруулж, батлуулан, хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн бодлого, хүний | -Нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн бодлого, хүний нөөцийг | -Нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн | Салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон харьяа агентлаг, байгууллагуудын сургалтын хэрэгцээний судалгааг гаргав. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нөөцийг чадавхижуулах, мэргэшүүлэх дунд хугацаа (2021-2024 он)-ны хөгжлийн хөтөлбөр /ХНХ-ын сайд/ | чадавхижуулах, мэргэшүүлэх дунд хугацаа (2016-2020 он)-ны хөгжлийн хөтөлбөр байхгүй, -Яамны хүний нөөцийн (2017-2022 он) хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. | төслийг боловсруулж, газруудын саналыг тусгасан байна. -Нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг ХНХ-ын сайдаар батлуулсан байна. | | |
| 125. | ХНХЯ-ны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацаа (2022-2025 он)-ны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авна. */ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 4.2./* | Үйл ажиллагааны зардал | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. | ХНХЯ-ны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацаа (2022-2025 он)-ны хөтөлбөрийг Төрийн нарийн бичгийн даргын 2022.11.22-ны А/235 тушаалаар шинэчлэн баталсан. | “Нийгмийн баталгааг хангах дунд хугацаа (2022-2025 он)-ны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Төрийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 2023 оны хагас жилээр **123** хүнд **157,6** сая төгрөгийг урамшуулалд олгосон байна. Ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн шахуу хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэн илүү цагаар ажилласан албан хаагчдад цалингийн санд багтаан илүү цагийн хөлсийг тооцож олгох Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын дагуу 17 албан хаагчид илүү цагийн хөлсөнд 5.1 сая төгрөгийг тооцож олголоо. Төрийн албан хаагчдын хэрэгцээнд үндэслэн орон сууцны болон нөхцөлийг нь сайжруулах асуудлыг судлан, Төгс орчин ХХК-тай Хан-уул дүүргийн Буянт ухаа спорт цогцолбор, Буянт ухаа нисэх буудал 2-ын дунд төв замаас 100м зайд барих 196 айлын орон сууцанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр захиалгад хамруулах гэрээ байгуулж, захиалга өгөх албан хаагчдын судалгааг гарган, 13 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтан урдчилгаа төлж, гэрээ байгуулсан.<br>Төрийн албан хаагчдын хэрэгцээнд зуслангийн зориулалтын газар эзэмших, ашиглах, байшин барихад дэмжлэг үзүүлэн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Кувейтын аманд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчдын амины хэрэгцээнд зуслангийн зориулалтын газар эзэмших, ашиглах зөвшөөрөл авч, кадастрын зураг хийлгэхээр дүүргийн Газрын албатай хамтран ажиллаж байна.<br>Төрийн албан хаагчдын нийгмийн батлагааг хангах хүрээнд төрийн албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд өдрийн **3,0** мянга, өдрийн хоолны мөнгөнд **12,0** мянган төгрөгөөр тооцон, сар бүр олгож байна.<br>Мөн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинээр гэр бүл болсон **1** ажилтанд **500,0** мянган төгрөг, ар гэрт нь гачигдал гарсан **8** ажилтанд **2.4** сая, төгрөг, өөрийн зардлаар мэдлэг боловсролоо дээшлүүлэхээр их дээд сургуульд суралцаж байгаа **11** ажилтанд **5.5** сая төгрөг, шинээр байранд орсон **14** албан хаагчид **7.0** сая төгрөг, шинээр төрсөн хүүхэдтэй **3** ажилтанд **900,0** мянган төгрөгийн нийт **38** ажилтанд **21.0** сая төгрөгийн дэмжлэгийг олгосон.<br>Ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн, албан хаагчдаас ажил үйлсээрээ бусдыгаа хошуучлан ажиллаж байгаа **1** албан хаагчийг Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, **3** албан хаагчийг Алтан гадас одонгоор, **6** албан хаагчийг Хөдөлмөрийн хүндэт медалиар, **1** албан хаагчийг Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр, **4** албан хаагчийг Хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр, **3** албан хаагчийг Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр, **3** албан хаагчийг Яамны хүндэт жуух бичгээр тодорхойлон шагнуулсан байна. | |
| 126. | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ХНХ-ын салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй | Үйл ажиллагааны зардал | Судалгаа -1<br>Сургалт, нөлөөллийн ажил -1<br>Салбарын бүх | Нэгдсэн судалгаа байхгүй. | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, албан хаагчдын судалгааг нас, | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллах бодлого барин ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажилтан албан хаагчдын нэгдсэн судалгаа гаргана. | | байгууллагуудад хүргүүлэх ХНХ-ын сайдын чиглэл | | хүйс, бэрхшээлийн төрөл, албан тушаалын ангиллаар нэгтгэж гаргасан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 1, Нийгмийн даатгалын Ерөнхий газарт 5, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт 5 хүн тус тус ажиллаж байна. | |
| 127. | Салбарын хэмжээнд Ахмадын сан байгуулсан, Ахмад ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын нэгдсэн судалгаа гаргана. | Үйл ажиллагааны зардал | Судалгаа -1 Сургалт, нөлөөллийн ажил -1 Салбарын бүх байгууллагуудад хүргүүлэх ХНХ-ын сайдын чиглэл | Нэгдсэн судалгаа байхгүй. | Салбарын хэмжээнд Ахмадын сан байгуулсан, Ахмад ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын нэгдсэн судалгаа гаргасан байна. | Салбарын хэмжээнд ахмад настны хөгжлийг дэмжих бодлого барьж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 2018 онд, Нийгмийн даатгалын Ерөнхий газар 2019 онд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 2021 онд, ХНХЯ 2022 онд тус тус Ахмад сан байгуулан ажиллаж байна. | 90 |
| 128. | Байгууллага, иргэдээс Төрийн дээд одон медалиар шагнуулахаар ирүүлсэн хүмүүсийн материалыг хүлээн авах, хянах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлах болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын шагналын болзол, шалгуур хангасан материалыг удирдлагуудад танилцуулан шийдвэрлэнэ. | Үйл ажиллагааны зардал | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын шагналд шаардлага хангасан материал | Тэмдэглэлт өдрүүдээр ХНХ-ын сайдын тушаалаар шийдвэрлэдэг. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын шагналын болзол, шалгуур хангасан материалыг удирдлагуудад танилцуулан шийдвэрлэсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/258 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын шагналын журам”-ыг үндэслэн эрхэлсэн ажилдаа олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг ХНХ-ын Сайдын тушаалаар шагнаж урамшулах ажлыг зохион байгуулан ажиллалаа.<br>Эхний 12 сарын 05-ны өдрийн байдлаар Засгийн газрын шагнал “Хөдөлмөрийн тэргүүний ажилтан” тэмдгээр 913, “Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан” тэмдгээр 478, “Хүндэт жуух” бичгээр 826 хүнийг шагнасан. | 100 |
| | | | Шаардлага хангасан материал | - | Шаардлага хангасан хүмүүсийн материалыг Засгийн газрын ХЭГ-т уламжилсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 71 дүгээр зарилагаар батлагдсан "Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ын дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг шагнуулахаар байгууллага, хамт олноос нь нэр дэвшүүлсэн материалыг хүлээн авч судлан, шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Энэ оны байдлаар төрийн дээд одон медалиар шагнуулахаар Гавьяат эдийн засагч цолоор 1, Үйлчилгээний гавьяат цолоор 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 5, Алтан гадас | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | одонгоор 22, Хөдөлмөрийн хүндэт медалиар 67 хүнийг шагнуулахаар холбогдох байгууллагад уламжиллаа. | |
| 129. | “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | -Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /АТҮХ/-ийн хэрэгжилт;<br>-Авлигатай тэмцэх 5Ш-ийн төлөвлөгөө. | АТҮХ-ийн 2021 оны хэрэгжилт 82.2 %, 2022 оны хэрэгжилт .......%. | -АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг өмнөх онуудын үнэлгээнд тулгуурлан хэрэгжилтийг хангаж ажилласан байна.<br>-ХНХ-ын салбарын авлигатай тэмцэх 5Ш-ийн төлөвлөгөө гарган, ажилласан байна. | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй болно.<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчид, харьяа агентлаг, байгууллагуудын дарга нар нийт 158 албан хаагчдын Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд шалган авч, мэдээ, тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.<br>-Шинээр болон жинхэнэ албан тушаалд томилогдох 43 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлэн ашиг сонирхлын зөрчил байгаа эсэх талаар дүгнэлт гаргуулсан.<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан ажиллаж байна. | 70 |
| ***Яамны аппаратын хэвийн үйл ажиллагааг хангах*** | | | | | | | |
| 130. | ХНХЯ-ны дотоод ажлыг тухай бүр шуурхай зохион байгуулах арга хэмжээ авна. | Үйл ажиллагааны зардал | -ХНХ-ын сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааны үйл ажиллагааг хариуцах, түүний тэмдэглэл хөтөлнө.<br>-Ажилтнуудын дотоод томилолт; ХНХЯ-ны мэдээллийн цагийн хуваарийг батлуулж, | Тухай бүр хэрэгжүүлж ажилласан. | -Сайдын зөвлөлийн болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн, хуралдаанаас гарсан үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг холбогдох удирдлагуудад танилцуулсан байна.<br>-Сайдын | --Сайдын шуурхай хурлыг 4 удаа хуралдаж, хуралдаанаас гарсан үүрэг даалгаврын жагсаалтыг холбогдох газруудад танилцуулж, биелэлтийг нэгтгэн танилцуулсан, Сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгаврын биелэлт 95 хувьтай байна.<br>-Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хурал 15 удаа хуралдаж хуралдааны бэлтгэл ажил хангаж, тэмдэглэл хөтлөн, хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг тухай бүр гаргаж, удирдлагад танилцуулсан. Шуурхай хуралдаанаас гарсан үүрэг даалгаврын биелэлт 93 хувьтай байна.<br>-Ажилтнуудын дотоод томилолтыг тухай бүр бүртгэн өгөв.<br>-ХНХЯ-ны мэдээллийн цагийн хуваарийг батлуулан, хэрэгжүүлж байна.<br>-ХНХЯ-ны ажилтнууд нүүрээ таниулан цагаа бүртгүүлж байна. Цаг ашиглалт сайн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлнэ.<br>-ХНХЯ-ны ажилтнуудын цагийн бүртгэл;<br>-Ахмадуудад тэмдэглэлт өдрүүдээр хүндэтгэл үзүүлнэ.<br>-Хурлын зал, танхим зохицуулна. | | зөвлөлийн болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааны тэмдэглэлүүдийг баталгаажуулан, архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн байна.<br>-Тухай бүр томилолт олгосон байна.<br>-Мэдээллийг хуваарийн дагуу зохион байгуулсан байна.<br>-Яамны албан хаагчдын цагийн бүртгэл тооцоог сар бүр гаргаж, холбогдох удирдлагуудад танилцуулж, цаг ашиглалтыг сайжруулсан байна.<br>-ХНХЯ-нд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настнуудыг тэмдэглэлт өдрүүдээр 2 удаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>-Яамны хэвийн | -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдөр”-ийг угтан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Сүхбаатарын талбайд 5 дугаар сарын 17-ны өдөр салбарын “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг зохион байгууллаа. Хөдөлмөр, нигймийн хамгааллын салбарын ажилтан, албан хаагчид 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр буюу амралтын өдрөөр Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших "Баянгол агропарк”-д нийт 115 хайлаас, 135 шар хуайс, нийт 250 мод тарив.<br>-Тус яамнаас зохион байгуулж буй аливаа арга хэмжээг цаг хугацаа, хурлын танхим, ёслол хүндэтгэлийн өргөөг давхардуулахгүйгээр бүртгэн, зохион байгуулав.<br>ХНХЯ-нд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настнуудыг ахмадын баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйл ажиллагааг хангах хүрээнд хурлын зал, танхимд зохион байгуулах арга хэмжээг хуваарь гарган зохицуулсан байна. | | |
| 131. | ХНХЯ-ны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | -Яамны газар, нэгжүүдээс 2022 болон 2023 оны эхний хагас жилд гарсан архивын баримтуудыг хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалалт, хамгаалалтад авна.<br>-Газар, хэлтсүүдийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулна.<br>-Архив, албан хэрэг хөтлөлтийн 2019 оны улсын үзлэгээс өгсөн Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.<br><br>-Засгийн газрын 2022.12.07-ны өдрийн | -Жил бүр архивын баримтуудыг хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалалт, хамгаалалтад авдаг.<br>-Газар, хэлтсүүдийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангасан.<br>-Архив, албан хэрэг хөтлөлтийн 2019 оны улсын үзлэгээс өгсөн Зөвлөмжийн дагуу ХНХЯ-ны 2000 оноос хойшхи архивын баримтуудыг Үндэсний төв архивт шилжүүлэхтэй холбоотой төсөв байхгүй тул, ажил хийгдээгүй.<br>-Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцлийг | -Яамны газар нэгжүүдээс 2022 болон 2023 оны эхний хагас жилд гарсан архивын баримтуудыг хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалалт, хамгаалалтад авсан байна.<br>-Газар, хэлтсүүдийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангасан байна.<br>-Архив, албан хэрэг хөтлөлтийн 2019 оны улсын үзлэгээс өгсөн Зөвлөмжийн дагуу ХНХЯ-ны 2000 оноос хойшхи архивын баримтуудыг Үндэсний төв архивт шилжүүлэхтэй холбоотой ажлын хэсэг байгуулж, | ХНХЯ-ны газар нэгжүүдээс 2022 онд хөтлөгдөж дууссан баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг үндэслэн архивт хүлээн авах хуваарийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/10 тоот тушаалаар батлуулсан.<br>-Уг хуваарийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 тоот тушаалын хавсралтаар баталсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-д заасан стандартын шаардлага хангасан 274 боть баримтыг шалган хүлээн авч, үдэж хавтаслан архивын нэгж үүсгэн хадгалалт хамгаалалтад авч данс бүртгэл үйлдэх ажлыг хуваарийн дагуу хийж дуусгасан.<br>- Яамны газар, хэлтэс, иргэд, байгууллагын хүсэлтээр УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал шийдвэр болон шаардлагатай баримтын хуулбарыг 145 удаа, Шүүхээс шаардсан нотлох баримтыг 5 удаа гарган өгсөн.<br>-Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/210 дугаар тушаалаар Архив дээр ажиллах ажлын хэсгийг харьяа байгууллагын Архивын эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй байгуулан тус яамны архивын баримтыг эмхлэн цэгцлэх, тоо бүртгэл хөтлөх, бүртгэлд ороогүй баримтыг бүртгэлжүүлэх, шаардлагатай задгай баримтыг үдэж хавтаслах, дугаарлах, оны заагуур, заагч хийх, стандартын дагуу тавиурт зөөж байрлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Дээрх ажлын үр дүнд ХНХЯ-ны 2016-2022 оны байнга хадгалах 356 ХН, түр хадгалах 2016-2023 оны 2968 ХН, 70 жил хадгалах 2016-2022 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуралдааны 58 дугаар тэмдэглэлийн дагуу Албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллана.<br><br>-Сургалт | ЦХХХЯ бүрдүүлсэн. | үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан байна.<br><br>-Албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажилласан байна.<br>-Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр салбар, яамны албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна. | 351 ХН, устгах хэргийн 2016-2019 оны 57 ХН, байгууллагын архивт байнга хадгалах 2016-2021 оны 69 ХН, нийт 3801 ХН, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны 2000-2016 оны байнга хадгалах 635 ХН, түр хадгалах 2000-2016 оны 1071 ХН, 70 жил хадгалах 2000-2016 оны 420 ХН, устгах хэргийн 2000-2012 оны 486ХН, нийт 2612 ХН, Хөдөлмөрийн яамны 2012-2016 оны байнга хадгалах 319 ХН, түр хадгалах 2012-2016 оны 944 ХН, 70 жил хадгалах 2012-2016 оны 248 ХН, устгах хэргийн 2012-2013 оны 662 ХН, байгууллагын архивт байнга хадгалах 10 ХН, нийт 2183, Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл хөтөлбөрийн устгах баримтын жагсаалт 2008-2013 оны 1168 ХН, Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл хөтөлбөрийн баримтын жагсаалт 2014-2020 оны байнга хадгалах 425 ХН, түр хадгалах 2014-2020 оны 365 ХН, 70 жил хадгалах 2014-2020 оны 32 ХН, нийт 822 ХН, Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр төслийн түр хадгалах 2001-2011 оны 379 ХН, Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх Мон-3243 төслийн байнга хадгалах 2015-2021 оны 152 ХН, түр хадгалах 2015-2021 оны 561 ХН, 70 жил хадгалах 2015-2021 оны 6 ХН, нийт ХН 719 ХН, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн байнга хадгалах 2018-2023 оны 104 ХН, түр хадгалах 69 ХН, нийт 173 ХН, Барилгын зураг төслийн 2008-2019 оны 548 ХН Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх Мон-01/1001 төслийн 2001-2011 оны 203 ХН, Гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн үрчлэлтийн холбогдолтой баримтууд 1991-2022 оны 291 ХН, Жендерийн үндэсний хорооны 2004-2012 оны 106 ХН, "Төрийн үйлчилгээ" УҮГ-ын 2000-2015 оны 139 ХН, нийт 13,294 ХН-ийн хадгалах хугацааг тодорхойлж, ангилан төрөлжүүлж, бүртгэл, жагсаалттай тулгалт хийх, бүртгэлд ороогүй баримтыг бүртгэлжүүлэх, хуудас тоолох, хавтас шинэчлэх, нүүр дардас, шифр, "Тоолов" дардсыг даран гарын үсэг зурж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны заагуур, заагч хийж, стандартын дагуу тавиурт байрлуулсан.<br>Устгах баримтын бүртгэлд 21 аймаг, 9 дүүрэг, хороодоос ирүүлсэн “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр, төслийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны асуулгын хуудас”-ууд /2008-2013 он/ цэнхэр хавтастай, Хүнс тэжээл, нийгмийнхаламжийн хөтөлбөр, төслийн харилцахын баримтууд /2002-2010 он/, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны харилцсан бичиг /2000-2002 он/, Явуулсан бичгийн бүртгэлийн дэвтэр, Өргөдөл гомдлын бүртгэлийн дэвтэр /2003, 2006 он/, Санхүүгийн сар, улирлын харилцахын баримтууд /2006-2012 он/, Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол /2009-2016 он/, Албан хаагчдын үр дүнгийн гэрээ, түүний биелэлт, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслүүд, Явуулсан албан бичгийн төслүүд, Ирсэн бичгийн бүртгэл хяналтын картууд, Албан хаагчдын цагийн бүртгэл зэрэг баримтуудыг ялгаж оруулсан.<br>-Яамны газар, хэлтсийн бичиг хэрэг хариуцсан ажилтнуудаас тухайн газарт 2023 онд хөтлөгдөн гарсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/199 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>-Баримт бичгийн эргэлтийн мэдээг 2022, 2023 оны байдлаар газар тус бүрээр гаргуулан авч нэгтгэн авч нэгжийн удирдлагад танилцуулсан. | |
| 132. | -Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлүүлнэ.<br>-Мэдээ, тайланг ЗГХЭГ-т хүргүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлүүлнэ. | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээг 7 хоног, сар бүр гарган, хяналт тавин ажилласан. | -Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлүүлэн, хяналт тавьсан байна.<br>-Мэдээ, тайланг улирал тутам ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Тус яаманд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 2023 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 3270 өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл ирүүлснээс 1088 бичгээр, 82 цахимаар, иргэд олон нийттэй харилцах төвөөс 1932, биечлэн болон утсаар 168 ирсэн байна. Үүнээс 2990 өргөдөл шийдвэрлэж, уламжлагдаж ирсэн 19 өргөдөл, 18 өргөдөл бусад байгууллагад шилжүүлж, 280 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байгаа бөгөөд шийдвэрлэлт 91,4% -тай байна. Ирсэн нийт өргөдлийн 1589 буюу 70% нь хүүхдийн мөнгөтэй, 30% нь Нийгмийн даатгал тэтгэвэртэй холбоотой байна. Түүнчлэн Төрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захиргааны удирдлагын газарт 332, Бодлого, төлөвлөлтийн газарт 287, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 25, Салбарын хяналтын газарт 109, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 727, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 1003, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 249, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 165, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 122, Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 209, бусад асуудлаар 42 өргөдөл тус тус ирсэн байна. | |
| ***4.1.2. Хууль тогтоомжийн үзэл баримтлал, төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр, яамны зүгээс бусад байгууллагатай байгуулах гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хангуулах, хууль зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;*** | | | | | | | |
| 133. | Хуулийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | 2022 онд яамнаас боловсруулах 5 хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэх, бусад хууль тогтоомжтой уялдуулах, боловсруулалтын шаардлага хангах | 2021 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 3 хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлаар батлуулсан. Засгийн газрын хуралдаанаар 6 хуулийн төслийг хэлэлцүүлэн, Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн. Эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлэн болгосон 1 хуулийн төсөл, 5 хуулийн төсөл боловсруулалтын шатанд байна. | Хуулийн төслүүдийг боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоход ажлын хэсэгт ажиллах, санал дүгнэлт өгөх, судалгаа хийх хэлбэрээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн хамтран ажилласан байна. | Яамнаас боловсруулж, ЗГ, УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлсэн хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, аргачлалын дагуу боловсруулах, хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлж, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.<br>Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан 12 хуулийн төслийн боловсруулалтын түвшин дараах хэрэгжилттэй байна:<br>1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль тэдгээрийг дагалдах хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-аас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан.<br>2.Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аас 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан.<br>3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдөр УИХ-аас баталсан.<br>4.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 11 бүлэг, 60 зүйлтэй байхаар эцэслэн боловсруулсан. Энэхүү хуулийн төслийг дагалдуулан 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. УИХ-аас хэлэлцэх эсэхийг дэмжсэн, анхны хэлэлцүүлэгт шилжээд байна.<br>5.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг дэмжсэн, анхны хэлэлцүүлэгт шилжээд байна.<br>6.Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүн амын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулсан боловч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас буцаан татаж, дахин боловсруулж байна.<br>7.Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн хэрэгцээ шаардлагын судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хийж, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, дагалдах 20 орчим хуулийн төсөл, зардлын тооцоог боловсруулаад байна. Хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-д хүргүүлсэн.<br>9.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг ХЗДХЯ-д хүргүүлсэн. | |
| 134. | Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | ХНХЯ-аас 2022 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад туссан Засгийн газрын 31 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2021 онд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар 30 тогтоолыг хэлэлцүүлэн | Яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 31 Засгийн газрын тогтоолын төслийг цаг хугацаанд нь | Тайлант хугацаанд тус яамнаас 23 Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.<br><br>Уг 23 Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах, хууль тогтоомжид нийцүүлэх асуудлаар хууль зүйн үндэслэлийг хянаж, санал, дүгнэлт, зөвлөмж өгөх, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхэд биечлэн оролцох | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтоолын төсөл болон бусад цаг үеийн асуудлаар хэлэлцүүлэх Засгийн газрын тогтоолын төслийн хууль зүйн үндэслэл, боловсруулалтын шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлнэ. | батлуулсан. | хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулахад дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажилласан байна. | хэлбэрээр ажилласан. | |
| 135. | Бусад яам, газруудаас боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, гэрээ, хэлэлцээр болон бусад шийдвэрийн төсөлд салбарын бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн санал боловсруулна. | Үйл ажиллагааны зардал | Санал өгсөн хууль, тогтоол, шийдвэрийн төсөл болон албан бичгийн тоо, хэрэгжилтээр | Батлагдан гарч байгаа эрх зүйн баримт бичгүүдэд салбарын болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн 530 удаагийн албан бичгээр санал хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичгүүдэд салбарын болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн санал хүргүүлсэн байна. | Бусад яам, газруудаас боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, гэрээ, хэлэлцээр болон бусад шийдвэрийн **536** төсөлд салбарын бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн санал боловсруулж Засгийн газрын журамд заасан хугацааг хэтрүүлэлгүйгээр албан бичгээр саналыг тухай бүр хүргүүлж ажилласан. | 100 |
| 136. | Салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах, төсөл боловсруулна. | Үйл ажиллагааны зардал | 1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн захиргааны хэм хэмжээний акт<br>2. Боловсруулсан хуулийн төсөл<br>3.Судалгааны санал, дүгнэлт | 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах **53** захиргааны хэм хэмжээний акт улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй байна. | -Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээг хийн, боловсронгуй болгох санал дүгнэлт гаргасан байна.<br>- Салбарын захиргааны хэм хэмжээний актыг тухай бүр хянан, Хууль зүй дотоод хэргийн яамны захиргааны хэм | 1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны улсын нэгдсэн санд бүртгэлтэй, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 54 захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг шинэчлэн гаргаж жагсаалтыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт мөрдөгдөж буй 54 захиргааны хэм хэмжээний актад Хууль, эрх зүйн хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хуралдааны 2022 оны “Улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай” 55 дугаар тэмдэглэлийн 1.1 дэх заалтын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж шинэчлэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээний улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна. | батлах, өөрчлөх, нэмэлт, өөрчлөлтийг нэгдсэн санд бүртгүүлэх, хасалт хийлгэх зэргээр санд хөдөлгөөн хийлгэх шаардлагатай 10 акт байгаа дүгнэлт гарсан.<br>3.Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болгосонтой холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/97, 231 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам"-ыг хүчингүй болгосон тул захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасуулах саналыг хүргүүлсэн.<br>4.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын "Аргачлал, журам батлах тухай /Мэргэжил албан тушаалын тариф мэргэжлийн лавлах зохиох аргачлалыг нэгдүгээр, Хөдөлмөрийн норм, норматив тогтоох журмыг хоёрдугаар хавсралтаар/ 2001 оны 48 дугаар тушаалыг хүчингүй болгох тухай тушаалыг батлуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.<br>5.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын захиргааны хэм хэмжээний актуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/199 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02/2552 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>6.Тайлант хугацаанд нийт 8 захиргааны хэм хэмжээний актыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулахаар хүргүүлэн тус актуудыг захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 137. | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын гаргаж буй захиргааны акт, хэм хэмжээний акт, шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, санал өгөх, шийдвэрийн төсөл боловсруулахад хууль зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | ХНХ-ын сайд, Төрийн нарийн бичгийн даргын гаргаж буй тушаал, шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт, шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төсөл нь хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянана. | 2021 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 261 тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 322 тушаал баталсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бусадтай 255 гэрээ байгуулсан. | Яамны эрх зүйн баримт бичгүүдэд салбарын болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн санал өгсөн, хууль зүйн үндэслэлийг хянасан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 217 тушаалын төсөл, Төрийн нарийн бичгийн даргын 484 тушаалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянасан.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бусад байгууллага, хуулийн этгээдтэй байгуулсан 206 гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянан, бүртгэж ажилласан. | 100 |
| 138. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн гэрээ боловсруулж, байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 22 гэрээг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд байгуулна. | 2021 онд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 22 гэрээ байгуулагдсан. | Төсвийн тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах 22 гэрээ боловсруулан, гэрээ байгуулах арга хэмжээ зохион байгуулж, 22 гэрээ байгуулсан байна. | Төсвийн тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах **22** гэрээний төсөл боловсруулсан, яамны газрууд мөн аймаг, нийслэлийн Засаг даргад гэрээний төсөл хүргүүлж саналыг авч нэгтгэн гэрээг эцэслэн боловсруулсан.<br>Аймаг, нийслэлийн Засаг даргад гэрээг хүргүүлэн нийт **22** гэрээг албажуулж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гэрээг байгуулсан. | 100 |
| 139. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, дүрмийг оновчтой болгох, шинэчлэхэд хууль зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, санал өгсөн, харьяа байгууллагын бүтэц, зохион байгуулалтын асуудлаарх шийдвэр, чиглэл, зөвлөгөө өгнө. | Харьяа байгууллагуудын бүтэц, зохион байгуулалттай холбоотой холбогдох ЗГ, сайдын шийдвэрийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, боловсруулсан. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, харьяа байгууллагын чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд судлах, байгууллагын зохион | -Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн боловсруулж хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар батлуулсан.<br>-Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын дүрмийн төслийг хянаж хамтран боловсруулсан.<br>-Олон Улсын хүүхдийн “Найрамдал цогцолбор”-ын зохион байгуулалтын бүтэц, дүрэм шинэчлэн батлахаар төсөл боловсруулан удирдлагад танилцуулсан.<br>-Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулалтын бүтэц, дүрмийн төслийг хянаж санал өгсөн байна. | үйлчилгээний төвийг татан буулгаж, тус улсад Монгол Улсаас суугаа элчин сайдын яамны бүрэлдэхүүнд шилжүүлэхээр “Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, холбогдох танилцуулгын хамт Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн.<br>-“Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн ажлын албаны бүтэц, дүрэм батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл, “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн ажлын албаны ажиллах дүрэм”-ийг боловсруулан Засгийн газраар батлуулсан. | |
| 140. | Шүүх, хуулийн байгууллагад эрх зүйн маргаанд яамыг төлөөлөн ажиллах, хууль зүйн зөвлөгөө өгнө. | Үйл ажиллагааны зардал | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг итгэмжлэлээр төлөөлж, шүүх хуралдаанд итгэмжлэлийн дагуу оролцож, хэргийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлнэ. | 2021 онд **7** иргэний маргаан, **7** захиргааны маргаан, 1 эрүүгийн маргаан нийт **15** маргаанд яам, Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажилласан Эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа **5** маргааны үлдэгдэлтэй байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг итгэмжлэлээр төлөөлж, шүүх хуралдаанд итгэмжлэлийн дагуу оролцож, хэргийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлсэн байна. | Сайдын эрхлэх асуудлын хүрээний асуудлаар эрх зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан, шүүх, хуулийн маргаанд яамыг төлөөлөн хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллаж байна:<br>- Тайлант хугацаанд **1** иргэний маргаан, **3** эрүүгийн маргаан, **10** захиргааны маргаан нийт **14** маргаанд яам, Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажилласан. Үүнд:<br>**Иргэний маргаан**:<br>- “Женералтеч” ХХК<br>**Эрүүгийн маргаан:**<br>- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын зарим алба хаагчид<br>- Р.Галбадрах, Т.Амартүвшин, Б.Алтансүх нар<br>- Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн эрх бүхий албан тушаалтнууд<br>**Захиргааны маргаан:**<br>- П.Анхтуяа<br>- Х.Арменбек<br>- Г.Саранхүү<br>- Т.Наранбат<br>- “Чингисхаан травел” ХХК<br>- Л.Шинэчимэг<br>- С.Мягмардорж<br>- Д.Алтангэрэл<br>- Б.Батзориг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - "АЕЕ" ХХК<br>- Эцэслэн шийдвэрлэгдсэн **1 иргэний** маргаан**, 5 захиргааны** маргаан, 1 эрүүгийн маргаан хариуцагч, хохирогч буюу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны талд шийдвэрлэгдсэн.<br>- Эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа **7** маргаан байгаа болно.<br>- Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсээс иргэн Л.Насанцэнгэлийн талаар ирүүлсэн тодруулгын хариу, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газраас "A+edu Academy" хүүхэд хөгжлийн төв үйл ажиллагааны талаар ирүүлсэн тодруулгын хариу тайлбарыг боловсруулж хүргүүлсэн. | |
| ***4.1.3. Салбарын гадаад хамтын ажиллагааг эрхэлж, гадаад орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулах, дэмжлэг үзүүлэх; /ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.1.3/*** | | | | | | | |
| 141. | Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллана. | ЗГ-ын нөөц сан /улс орноо гадаадад сурталчлах зардал/ | Олон улсын хөдөлмөрийн Бага хурлын ээлжит 111 дүгээр Чуулганд төлөөлөгч оролцуулах, холбогдох бэлтгэлийг хангана. | 110 дугаар Чуулганы арга хэмжээнд төлөөлөгч оролцсон | Чуулганд холбогдох төлөөллүүд батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу оролцон, холбогдох бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна. | Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурлын 111 дүгээр Чуулган Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023 оны 06 дугаар сарын 05-15-ны өдрүүдэд болж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар тэргүүтэй манай улсын гурван талын нийт 14 төлөөлөгчид /Женев дэх Байнгын төлөөлөгчийн газар, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо/ оролцов. Төлөөлөгчдийн тэргүүн бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар 06 дугаар сарын 06-ны өдөр Нэгдсэн хуралдаанд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий Захирлын тавих үндсэн илтгэлийн хүрээнд үг хэлж, Засгийн газрын байр суурийг илэрхийллээ. Чуулганы арга хэмжээнд 187 гишүүн орны Засгийн газар, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын 4000 гаруй төлөөлөгчид оролцож, цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт, үйлдвэрлэлийн бодлого, технологид суурилсан байгаль орчинд ээлтэй шударга нийгэм ба эдийн засгийн өсөлтөд чиглэсэн шилжилт, түүнд чиглэсэн зохистой хөдөлмөр эрхлэлт, эрх тэгш нийгмийн төлөөх шударга даяарчлал, дагалдан хөдөлмөр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхлэлт, хөдөлмөр хамгаалал зэрэг асуудлуудыг хэлэлцэв. Мөн чуулганы үеэр төлөөлөгчдийн тэргүүн ОУХБ-ын Ерөнхий захирал ноён Желбэр Унгбо болон Ерөнхий захирлын орлогч хатагтай Миа Сеппо тэргүүтэй төлөөлөгчидтэй албаны уулзалт хийлээ. Уулзалтаар ОУХБ-ын зүгээс Монгол Улстай өргөн хүрээнд буюу хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн платформ хөгжүүлэх, албан бус салбарт ажиллагсдыг албажуулах зэрэг чиглэлээр нягт хамтран ажиллаж байгаадаа таатай байгаагаа илэрхийлээд хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээг хийх, Нийгмийн хамгааллын доод хэм хэмжээний тухай 102 дугаар конвенцид нэгдэн орох асуудлаар санал солилцлоо. | |
| | | | Олон улсын хөдөлмөрийн Бүсийн Бага хуралд төлөөлөгч оролцуулах, холбогдох бэлтгэлийг хангана. | Бүсийн бага хурал 2022 оны 12 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд БНСингапур Улсад зохиогдож, 3 талын төлөөлөл оролцсон | Бага хурлын арга хэмжээнд хуваарийн дагуу төлөөлөл оролцуулж, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | 2023 онд бүсийн хурал зохион байгуулах шийдвэр гаргаагүй болно. | |
| | | | Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц, зөвлөмжүүдийн хэрэгжилтийн талаарх 2023 оны хуваарьт 3 тайланг боловсруулах, хүргүүлэх ажлыг зохицуулалтаар хангаж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. /100, 111, 122-р конвенцийн тайлан/ | 2022 оны хуваарьт тайлангууд хугацаандаа хүргэгдсэн. | 3 тайлангийн төслийг орчуулж, ОУХБ-ын холбогдох нэгжид албан ёсоор хүргүүлсэн байна. | Монгол Улс нэгдэж орсон олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмжүүдийн 2023 онд хүргүүлэх нийт 3 конвенцийн тайланг холбогдох бодлогын газруудтай хамтран боловсруулсан. Түүнчлэн, 2023 оны 04 дүгээр сарын 24-нд ОУХБ-тай хамтран холбогдох яамд, агентлагуудыг оролцуулсан сургалт, семинарыг Тэгш шан хөлс олгох тухай 100 дугаар конвенц, Ялгаварлан гадуурхахгүй /ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/ байх тухай 111 дүгээр конвенцын хүрээнд зохион байгуулав. Тайлангуудыг 2023 оны 08 дугаар сарын 31нд ОУХБ болон Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, МҮЭХ-д тус тус албан ёсоор хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 142. | Олон улсын байгууллагууд, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санал тавих, төслүүдийн хэрэгжилтийг зохицуулалтаар хангана. | Үйл ажиллагааны зардал | АХБ, ДБ болон бусад олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа шинээр тогтоох, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохицуулалтаар хангах, дэмжлэг үзүүлнэ. | ХНХ-ын сайд болон дэд сайд нар ОУ-ын байгууллага, гадаад орны элчин сайд нартай албан ёсны уулзалтуудыг хийсэн. | -Төсөл, хөтөлбөрүүд хэрэгжихтэй холбоотой баримт бичиг /гэрээ, санамж бичиг/ байгуулан, төсөл, хөтөлбөр хэрэгжиж эхлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | -ЖАЙКА олон улсын байгууллагаас 2023 оны 06 дугаар сараас хэрэгжүүлэх Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төслийн хүрээнд хамтран ажиллав.<br>- Азийн Хөгжлийн Банкнаас 2024 оны 01 дүгээр сараас хэрэгжүүлэх “Монгол Улсад ахмад настны тусламж үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх: Ахмад настанд ээлтэй технологийн хүртээмжийг сайжруулах" төслийн ерөнхий агуулга, хүрээг тодорхойлох чиглэлээр бодлогын газартай хамтран ажиллаж Санамж бичиг байгуулах, холбогдох уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэв.<br>-Европын Холбооны харьяа Socieux Plus байгууллагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний гэр бүлийн гишүүдэд чиглэсэн хөгжлийн дунд хугацааны стратеги (2023-2025) боловсруулах, чадавхи бэхжүүлэх чиглэлээр Болгар, Франц зэрэг улсаас 2 зөвлөх ХБХХЕГазарт 2023 оны 02 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд, Ганц бие ахмад настны тэтгэврийн зарцуулалт, хүртээмжийн судалгааны асуудлаар 2 зөвлөх 2023 оны 1.30-наас 02.10-ны өдрүүдэд тус тус ирж ажилласан.<br>-Европын Холбооны дэмжлэгтэйгээр тэтгэврийн шинэчлэлийн асуудлаар туршлага судлах, богино хугацаагаар мэргэжилтэн урих, сургалт семинар зохион байгуулах багц арга хэмжээг хэрэгжүүлэх 5 мэргэжилтэн бүхий зөвлөх баг 2023 оны 05 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд ажиллалаа.<br>- Олон улсын хөдөлмөрийн байгууллага, АНУ-ын Хөдөлмөрийн департаментаас хамтран 2023-2024 онд Албадан хөдөлмөрийг устгах дэлхий нийтийн хүчин чармайлтыг холбох гүүр төслийн – II үе шат Монгол Улс сонгогдон хэрэгжиж эхэлсэн. Төслийн үндсэн зорилго нь Албадан хөдөлмөрийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэхэд чиглэсэн үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих механизмыг бэхжүүлэх, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хохирогчдод тусламж үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн талаар ойлголт мэдлэг өгөхөд оршино.<br>- Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас Албан бус эдийн засгийг албажуулах төслийг хэрэгжүүлж эхлэв. Төсөл нь бодлогын уялдаа холбоог хангах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, бүртгэлийг хялбаршуулах, бизнес хөгжлийн үйлчилгээг өргөжүүлэх цогц аргачлалаар албан бус салбарт ажиллагчид болон албан бус бизнесийг албан салбарт шилжихэд нийгмийн гурван талт түншлэлийн байгууллагуудад техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх зорилготой юм.<br>Төслийг жижиглэн худалдаа, үйлчилгээ, мал аж ахуйн салбарт 2023-2025 онд хэрэгжүүлж, дижитал технологи ашиглан цахимаар албажуулах үйл ажиллагааны стратеги,системийн удирдамж, дизайныг боловсруулах юм. | |
| | | | Одоо хэрэгжиж буй төслүүдийн үйл явцыг зохицуулалтаар хангах, удирдлагыг холбогдох мэдээллээр хангах, хуваарьтай тайлагналтад хяналт тавина. | 2022 оны 12 дугаар сарын байдлаар салбарын хэмжээнд хэрэгжиж буй төслүүдийн мэдээллийг нэгтгэж удирдлагуудад мэдээлэл өгсөн. | Ирэх онд хэрэгжүүлэх төслүүдийн санал, чиглэлийг цаашид хамтран ажиллах холбогдох газруудтай хамтран тодорхойлсон байна.<br>-Хэрэгжиж буй төслүүдийн явцын талаар удирдлагыг холбогдох мэдээллээр ханган, хуваарьтай тайлагналтад хяналт тавин ажилласан байна. | Олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газруудын буцалтгүй тусламж болон хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй нийт төслүүдийн хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэн ХНХ-ын сайдын шуурхайд танилцуулав. /2023.04.18-20/ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 143. | НҮБ, Хүний эрхийн байгууллагуудаас гаргасан зөвлөмжтэй холбоотой асуудлыг зохицуулалтаар хангах, НҮБ-ын салбар байгууллагуудтай хөгжүүлэх хамтын ажиллагааг зохицуулалтаар хангах НҮБ-ын чуулгануудад оролцох ажлыг зохицуулалтаар хангана. | Улс орноо гадаадад сурталчлах зардал | Гаагийн улс хоорондын холбогдох конвенц, протоколд нэгдэн орох бэлтгэл ажлыг зохицуулалтаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Гаагийн конвенцын нарийн бичгийн дарга нарын газарт конвенцэд нэгдэх асуудлаар чадавх бэхжүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр санал тавьсан. | Конвенцод нэгдэн орохтой холбоотой бэлтгэл ажлыг хангасан байна. | НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх 2 болон 3 дугаар тайланг 2023 оны 8 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд хэлэлцүүлэн хамгаалах бэлтгэл ажлыг хангасан. Инхүү хэлэлцүүлэн хамгаалсны мөрөөр НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлийн хорооноос өгсөн зөвлөмжийг холбогдох талуудад танилцуулах, хэрэгжилтийг хамтран хангах асуудлаарх арга хэмжээг зохион байгууллаа. Тухайлбал, 11 дүгээр сарын 29-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, 12 дугаар сарын 7-ны өдөр олон улсын байгууллагууд, элчин сайдын яамдад танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.<br>- НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын Ази, Номхон далайн бүс хариуцсан захирал Роури тэй хийх дэд сайд С.Зулпхарын уулзалтыг 12 дугаар сарын 7-ны өдөр амжилттай зохион байгууллаа.<br>Улс хоорондын үрчлэл болон хамтын ажиллагааны асуудлаарх Гаагийн конвенцын асуудлаар Гаагийн бага хурлын товчооны эксперт Лаура Мартинез Мора ирж 2023 оны 5 дугаар сарын 9-11-ний өдрүүдэд сургалт хийлээ. Сургалтын үеэр конвенцод элсэхийн ач холбогдол, болон конвенцыг хэрхэн хэрэглэх талаар нарийвчлан тайлбарласан сургалтыг зохион байгуулав.<br>-НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас ирүүлсэн Хүүхдийн эрт, албан гэрлэлтийн асуудлаарх тогтоолын хэрэгжилтийн талаарх тайланг ГББХЗГ-тай хамтран боловёруулж, ГХЯ-аар дамжуулан НҮБ-д хүргүүллээ.<br>- НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас ирүүлсэн Монгол Улсын цом бичиг баримтыг шинэчлэх асуудлаарх бичгийн дагуу холыогдох тайланг хүргүүллээ. Уг цөм баримт бичгийг Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон талт гэрээний хэрэгжилтийн тайланг НҮБ-ын гэрээний хороод хэлэлцэхэд суурь баримт бичиг болж хамтатган авч үздэг.<br>- Зохистой орон байраар хангагдах эрхийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | асуудал болон нэн ядуурлын асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайланд тусгах мэдээллийг орчуулж, холбогдох газартай хамтран, хэрэгжилтийг гаргаж, ГХЯ-аар дамжуулан НҮБ-д хүргүүлсэн.<br>- Хүүхдийн бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, хүүхэд худалдаалах асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайланд тусгах үндэсний түвшний мэдээллийг ГББХЗГ-тай хамтран боловсруулж, орчуулан, ГХЯ-аар дамжуулан НҮБ-д хүргүүлсэн.<br>Манай улсын санаачлан батлуулсан НҮБ-ын RES/76/140 тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан боловсруулсан мэдээллийг боловсруулан, ГХЯ-р дамжуулан НҮБ-д хүргүүлсэн.<br>НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганаар баталсан A/RES/76/137 тоот “Policies and programs involving youth” тогтоолын хэрэгжилтэд тусгах манай улсын мэдээллийг боловсруулан, ГХЯ-аар дамжуулан НҮБ-д хүргүүлсэн. | |
| | | | НҮБ-ын чуулгануудад оролцоход зохицуулалтаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, бэлтгэл ажлыг хангана. | 2022 онд зохиогдсон холбогдох чуулгануудад цахимаар болон биечилсэн байдлаар сайдын түвшинд оролцсон. | Чуулгануудад төлөөлөгч оролцож, Засгийн газрын байр суурийг илэрхийлэх ажлыг холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулсан байна. | -НҮБ-ын Нийгмийн хөгжлийн хорооны 60-р чуулган 2023 оны 02 дугаар сарын 6-15-ны өдрүүдэд болсон бөгөөд чуулганы ерөнхий санал шүүмж болон сайд нарын форумд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан биечлэн оролцохтой холбоотой Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх баримт бичгийг боловсруулж, бэлтгэл хангасан боловч сайд оролцох боломжгүй болсон тул Байнгын төлөөлөгчийн газраас төлөөлөгч оролцууллаа. Төлөөлөгчийн хэлэх үгийг бэлтгэн боловсруулж хүргүүлэв.<br>-АНУ-ын Нью Йорк хотноо 2023 оны 03 дугаар сарын 6-17-ны өдрүүдэд болсон НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Аж байдлын Хорооны 67 дугаар чуулганд ХНХ-ын дэд сайд С.Зулпхар тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Уг чуулганд “Хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг хангах, чадавхжуулах чиглэлээр гаргасан ололт амжилт, тулгарсан бэрхшээл” сэдвээр үндэсний сайн дурын илтгэлээ танилцууллаа. Мөн сайд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нарын дугуй ширээний уулзалт, ерөнхий санал шүүмж зэрэг чуулганы үеэр зохиогдсон хуралдаануудад оролцож, холбогдох асуудлуудаарх Засгийн газрын байр суурийг илэрхийлэв.<br>-2023 оны 4 дүгээр сарын 10-14-ний өдрүүдэд АНУ-ын Нью Иорк хотноо болсон НҮБ-ын Хүн ам ба хөгжлийн хорооны 56 дугаар хуралдаанд санхүүгийн бэрхшээлийн улмаас яамны төлөөлөл оролцох боломжгүй болсон учир НҮБ-ын дэргэд суугаа Элчин сайд бөгөөд Байнгын төлөөлөгч В.Энхболд оролцлоо. Элчин сайдын хэлэх үгэнд оруулах холбогодох мэдээллийг боловсруулан, орчуулж хүргүүллээ.<br>-2023 оны 6 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохиогдсон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах конвенцын талуудын 16 дугаар чуулганы ерөнхий хэлэлцүүлэгт Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа цахимаар оролцох бэлтгэлийг хангаж ажиллав. Сайд Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл хийж, үг хэллээ. Сайдын хэлэх үгэнд оруулах холбогдох мэдээллийг боловсруулж, орчуулга, хэвлэлийн мэдээ зэргийг иж бүрнээр нь хангаж ажиллав. | |
| | | | НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохицуулалтаар хангана. | НҮБ түүний төрөлжсөн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төслүүдийн хүрээнд хамтын ажиллагааг зохицуулалтаар хангасан. | Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулалтаар хангаж ажилласан байна. | - НҮБ-ын ХАС, Хүүхийн сан, ОУХБ болон ХХАА байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Малчдын нийгмийн хамгааллыг бэхжүүлж, цочролд бэлэн байдлыг сайжруулах нь” төслийн хүрээнд НҮБ-ын Хүнс хөдөө, аж ахуйн байгууллагаас боловсруулан гаргасан гамшгийн эрсдлийн замын зураглалын судалгааг хийхэд хамтран ажиллалаа. Уг төсөл нь 2022 оны 6 дугаар сард хэрэгжиж дууссан хэдий ч эрсдлийн үнэлгээний замын зураглалыг үргэлжүүлэн хийж, 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдөр замын зураглалын тайлангийн хаалтын үйл ажиллагааг зохион байгууллаа. Хаалтын арга хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр оролцож, үг хэллээ. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, Удирдах хорооны хурлыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг хамтран зохион байгууллаа.<br>-Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн зөвлөлтэй хамтран нийгмийн хамгааллын асуудлаар СПОТ симуляторын сургалтыг 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдөр зохион байгууллаа. Сургалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн Бангкок дахь төвөөс Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлагч Катинка Вэйнбэргэр тэргүүтэй төлөөлөгчид ирж сургалт оролцов. Сургалтад нийт 11 байгууллагын 53 албан хаагчид оролцлоо.<br>Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023 оны 08 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд болж буй Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын Хорооны 29 дүгээр хуралдаанд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын ээлжит 2 болон 3 дугаар тайланг хэлэлцүүлж хамгаалах бэлтгэл ажлыг иж бүрнээр нь хариуцаж ажиллав. Засгийн газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 7-р сарын 19-ний 281 дугаар тогтоолоор батлуулсан төлөөлөгчидтэй хамтран ажиллав. НҮБ-ын 193 гишүүн орноос 43 Улс орон ямар нэгэн гэрээ, конвенцийн өргүй байна. ХНХЯ тус улс орны нэг болж байгаа бөгөөд сүүлийн 2 жилийн хугацаанд гурван конвенцийн тайланг амжилттай хамгаалж ХНХЯ манлайлж ажилласан. | |
| 144. | Салбарын хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Салбарын хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд санал боловсруулж, | 2022 онд ЗГ-ууд хоорондын комиссын хуралдаан болон бусад үйл ажиллагааны | Хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд тухай бүр зохион байгуулагдах | 1/Дараах төлөвлөгөөний төсөлд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд санал ГХЯ-ны холбогдох газруудад тус тус хүргүүлэв. Үүнд:<br>-Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох байгууллагад хүргүүлнэ. | хүрээнд хамтын ажиллагаа хөгжүүлсэн | айлчлал, уулзалтын ярианы сэдэв, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санал, санаачилга гаргахын тулд судалгаа хийх, бусад газруудтай нягт хамтран ажилласан байна. | департамент хоорондын Стратегийн түншлэлийн эдийн засгийн бодлогын III зөвлөлдөх уулзалтын төлөвлөгөөтэй холбогдох санал,<br>-Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн 2023 оны 5 дугаар сард Бүгд Найрамдах Чех Улсад хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд 1. Төлөвлөгөөний төслийн 13 дугаар хэсгийн хариуцах байгууллагад Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Элчин сайдын яамыг нэмэх, 2. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх маягтыг эцэслэн тохиролцох санал,<br>-Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент, Испанийн Хаант Улсын нийслэл Мадрид хотод тус тус Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажилуулах тухай танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд,<br>-Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын 2023 оны 02 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос Улсад хийх ажлын айлчлалын үеэр баримтлах удирдамжийн төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд Монгол Улсын иргэнийг БНСУ-д улирлын, түр хугацааны визний ангиллаар хөдөлмөр эрхлүүлэхтэй холбоотой саналыг хүргүүлсэн.<br>2/ Дараах чиглэлээр хамтын ажиллагааны саналыг холбогдох ЭСЯ-д хүргүүлэв. Үүнд:<br>-Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, БНСУ-ын Хөдөлмөр, эрхлэлтийн яамны харьяа БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн агентлаг (KOSHA)-ийн хооронд “Ажлын байран дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хамтын ажиллагааны гэрээ”-г анх 2003 онд байгуулсан бөгөөд дахин шинэчлэн байгуулах асуудлаарх бэлтгэл ханган ажиллаж байна. Айлын тал нэг жилээр хойшлуулах хүсэлт тавьсаны дагуу 2023 оны 1 дүгээр сард албан и-мейл хүргүүлсэн болно.<br>-БНТУ-ын ЭСЯ болон Хөдөлмөрийн яаманд нийт ард иргэдэд олон муж, хотыг хамарсан хүчтэй газар хөдлөлтөд олон мянган хүний амь эрсэдсэн энэхүү гарз хохирол учирсан явдалд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Салбарын Сайдын болон яамны өмнөөс гүн эмгэнэл илэрхийлсэн.<br>-Бүгд Найрамдах Солонгос Улсын Жендэрийн тэгш байдал, Гэр бүлийн яаманд Залуучууд солилцооны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх буюу 2023 оноос биечлэн болгох хүсэлтийг дэмжин хүргүүлсэн. Энэ хүрээнд Залуучууд солилцооны хөтөлбөр-2023 -т хамрагдах монголын залуучуудын төлөөлөл 2023 оны 06 дугаар сарын 13-23-ны өдрүүдэд БНСУ-д залуучуудын солилцооны хөтөлбөрийг хамтран зохион байгуулж ажилласан. Түүнчлэн Монгол Улсад 2023 оны 8 сард Солонгосын залуучуудыг хүлээн авч харилцан солилцооны хөтөлбөрөө амжилттай зохион байгуулав. Хоёр улсын залуучууд өөрийн орны түүх соёл, ахуй, ёс заншил, боловсрол, байгаль, нийгэм эдийн засаг, бүтээн байгуулалт хөгжлийн талаар харилцан таниулах замаар найрсаг харилцаа, талуудын залуучуудын асуудлаарх хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой тус солилцооны хөтөлбөрт энэ жил Монгол, Солонгосын талаас мэдлэг, хандлага, манлайлах чадвараараа шалгарсан 16-22 насны 20 залуу хамрагдсан болно. | |
| | | | Эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хороог зохион байгуулна. | шинээр хийх ажил | Засгийн газрын 2022 оны 387 дугаар тоот тогтоолоор ХНХ-ын сайд Монголын хэсгийг удирдах болсонтой холбогдуулан зохих бэлтгэлийг хангаж ажилласан байна. | Холбогдох яамдуудтай хамтран төлөвлөөний биелэлтийг гаргаж ажилласан. Эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны хуралдааныг зохион байгуулах товын хувьд Туркийн тал хойшлуулах санал илэрхийлсэн. | |
| | | | Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн | шинээр хийх ажил | Засгийн газрын 2022 оны 387 дугаар тоот тогтоолоор ХНХ-ын сайд | Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын 8 дугаар ээлжит хуралдаан 2023 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамтын ажиллагааны Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын хуралдааныг зохион байгуулна. | | Монголын хэсгийг удирдах болсонтой холбогдуулан зохих бэлтгэлийг хангаж ажилласан байна. | Улаанбаатар хотноо ГХЯ, ЭСЯ-тай хамтран зохион байгуулав. Засгийн газар хоорондын хамтарсан хорооны хуралдааныг монголын талаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа даргалсан. Хуралдаанаар хоёр орны уламжлалт, найрсаг харилцааг өргөжүүлэх, Монгол, Чехийн эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцлээ.<br>Түүнчлэн комиссын монголын талын дарга ХНХ-ын сайд Х.Булгантуяа чехийн төлөөлөгчдийн тэргүүн, БНЧУ-ын Шадар сайд бөгөөд ХНХ-ын сайд Мариан Юречка болон албаны хүмүүсийг хүлээн авч уулзсан. Уулзалтын үеэр хоёр улсын нийгмийн халамж болон даатгалын тогтолцооны талаар харилцан мэдээлэл солилцсон. 1999 онд байгуулсан "Монгол Улсын иргэд, Бүгд Найрамдах Чех Улсын иргэдийг харилцан хөдөлмөр эрхлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг шинэчлэхээр тохиров. | |
| | | | Салбарын хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний биелэлтийг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ. | 2022 онд хүргүүлэх хуваарьт төлөвлөгөө, арга хэмжээний биелэлт бүрэн биелсэн. | Уулзалт, айлчлал, хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан холбогдох арга хэмжээний биелэлтийн явцыг холбогдох газарт улирал бүр хүргүүлсэн байна. | Засгийн газар хоорондын комиссын хуралдаануудад хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээрх холбогдох саналуудыг тусгахаар хүргүүлэв. Үүнд:<br>-Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол, Австрийн Засгийн Газар хоорондын комиссын 8 дугаар хуралдааныг Вена хотноо зохион байгуулахаар төлөвлөж байгаатай холбогдуулан Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр байгуулах асуудал,<br>-Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Казахстаны Засгийн газар хоорондын комиссын IX хуралдааны протоколыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд "Тэтгэврийн хүрээнд хамтран ажиллах тухай" хэлэлцээрийг эцэслэн батлах санал,<br>-Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсын удирдлагын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиролцоог байгуулласны мөрөөр ашиглах маягтуудыг эцэслэх. | |
| | | | Салбарын хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд гадаад улсын төлөөлөгчидтэй тухай бүр хийх хурал, уулзалтад мэргэшил, арга зүйн, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ. | Тухай бүр оролцоог хангаж, дэмжлэг үзүүлэн ажилласан. | Тухай бүр уулзалт, арга хэмжээг зохицуулалтаар ханган, оролцож, дэмжлэг үзүүлсэн байна. | -Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын гүйцэтгэх захирал, Зүүн өмнөд Ази хариуцсан захирал Тан По Тек болон албаны хүмүүсийн ХНХ-ын сайд Х.Булгантуяатай хийсэн уулзалтыг зохион байгуулав.<br>Мөн энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Монгол Улсын онцлогт нийцсэн Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын (SCE)-ын Зөвлөх үйлчилгээний хуулийн зөвлөх багийг 6 сарын хугацаатай, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих” төслийн санхүүжилтээр авч ажиллуулахаар Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай санал солилцож Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах, хууль эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр зөвлөх үйлчилгээ авахаар албан ёсны саналыг хүлээн авч Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар бэлтгэл ажлыг хийж байна.<br>Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын Гүйцэтгэх Захирал Конг Вай Мүүн, Зүүн хойд Ази, Ойрхи Дорнод хариуцсан газрын захирал ноён Тан По Тек, Зөвлөх Лим Чи Киа нарын төлөөлөгчид 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд Монгол Улсад айлал хийж, ХНХЯ-ын Сайд Х.Булгантуяа, БХБЯ, ЗТХЯ, ТӨБЗХ, МИАТ ТӨХК зэрэг байгууллагатуудтай албаны уулзалтуудыг хийсэн.<br>-2023 оны 06 дугаар сарын 13-22 болон 7 дугаар сарын 26-аас 8 дугаар сарын 03-ны өдрүүдэд Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Жендэрийн тэгш байдал, гэр бүлийн яам, Солонгосын залуучуудын ажлын агентлагтай хамтран | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Залуучууд солилцооны хөтөлбөрийг зохион байгуулсан.<br>Уг хөтөлбөрт 16-18 насны шилдэг 8 залуусын төлөөлөл, 2021, 2022 оны тус хөтөлбөрт хамрагдаж байсан шилдэг 2 оролцогчийг сонгон шалгаруулж 2023 оны 6 дугаар сарын 13-23-ны өдрүүдэд БНСУ-д болсон солилцооны хөтөлбөрт хамруулав.<br>ХНХ-ын сайдын АХБ, ДБ, ЕХ, ОУХБ-ын суурин төлөөлөгчид, хөтөлбөр зохицуулагч нартай хийсэн уулзалтуудыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллав.<br>ХНХ-ын сайдын Япон Улс, ХБНГУ-ын элчин сайд нартай хийсэн хоёр талт уулзалтуудыг зохион байгуулав. | |
| ***Олон нийттэй харилцах чиглэлээр*** | | | | | | | |
| 145. | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Цахим монгол болон ХНХ-ын салбарын цахимжуулалтын ажлыг олон нийтэд мэдээлнэ. | Үйл ажиллагааны зардал | ХНХ-ын салбарын цахимжуулалтыг тухай бүр мэдээлж, олон нийтэд хүргэнэ. | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Цахим монгол болон ХНХ-ын салбарын цахимжуулалтын ажлыг олон нийтэд мэдээлсэн. | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Цахим монгол болон ХНХ-ын салбарын цахимжуулалтын ажлыг тухай бүр олон нийтэд мэдээлсэн байна. | -Ejob платформын тоон мэдээллийг 10 хоног тутам мэдээлж, тус системийг сурталчлах, олон нийтэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэв.<br>-Вэб сайтын Төрийн үйлчилгээ цэсийн Ажилд зуучлах цэсийг ejob.gov.mn системтэй, Нийгмийн даатгалын үйлчилгээ цэсийг edaatgal.mn системтэй холбуулав.<br>-Нийгмийн даатгалын Хөдөлмөрийн чадварын хувь, хугацаа тогтоосон акт болон нийгмийн даатгалын бусад үйлчилгээг emongolia системээс авах боломжтой болсон талаарх мэдээ мэдээллийг постер хэлбэрээр болон мэдээ хэлбэрээр тухай бүр мэдээлж ажиллав.<br>-Хүүхдийн мөнгийг 91 хувь олгох болсонтой холбоотой иргэд бүртгэлийн мэдээллээ хэрхэн засварлах, хүсэлт хэрхэн илгээх талаарх мэдээ, заавар постер, шторкийг бэлтгэн түгээв.<br>-Нийгмийн халамжийн цахим үйлчилгээг сурталчлах хүрээнд шторк бэлтгэх удирдамж боловсруулан НҮБ-ын Хүүхдийн сангаар санхүүжилтийг шийдвэрлүүлэв. 3 ширхэг шторк, постеруудыг бүтээлгэж, олон нийтэд түгээв. | 100 |
| 146. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээллийн ил тод байдлыг хангаж, бодлого | Үйл ажиллагааны зардал | Бодлого, үйл ажиллагаа, цаг үе, үйл явдлын мэдээ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээллийн ил тод | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны | *1.<u>Байгууллагын вэб сайт болон сошиал сувгуудыг хөтлөх, хөгжүүлэх талаар:</u>*<br>-Байгууллагын вэб сайтад эхний хагас жилд 180 мэдээ /үйл явдлын мэдээ, ярилцлага, видео | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна. | | мэдээллийг шуурхай бэлтгэн мэдээллийг хүртээмжтэй ил тод байдлаар олон нийтэд хүргэх. Байгууллагын вэб сайт болон сошиал сувгуудыг хөтлөх, хөгжүүлэх ажлыг хийнэ. | байдлыг хангаж, бодлого үйл ажиллагааг олон нийтэд хүргэх сурталчлах ажлыг хийсэн. | мэдээллийн ил тод байдлыг хангаж, бодлого үйл ажиллагааг олон нийтэд хүргэх сурталчлах ажлыг тухай бүр хийсэн байна. | мэдээ/ бэлтгэн байршуулсан. Зарим цэсийг шинэчлэх хөгжүүлэх ажлыг мөн хийж гүйцэтгэв.<br>-Нийгмийн сүлжээ болох Фэйсбүүк хуудас, твиттер, инстаграмд тогтмол мэдээ, постер видео хэлбэрээр олон нийтэд хүргэх мэдээллийг оруулан хөгжүүлж хөтөлж байна. Тухайлбал, Фэйсбүүк хуудаст өдөрт дунджаар 8-9 пост /мэдээ, постер, видео контентууд г.м/ оруулж ажилласан ба дагагч, хандалтын тоо тогтмол нэмэгдэж, оны эхнээс дагагчдын тоо 15 мянга орчмоор нэмэгдэж **109100** болсон байна.<br>-Яамны сошиал бусад суваг болох инстаграм,, твиттер, юутубэ зэрэгт мөн тохирох контентыг тогтмол байршуулан идэвхтэй хөтлөн ажиллаж байна.<br>-Байгууллагын ил тод байдлыг хангах, вэб сайтын хөгжүүлэлтийг тогтмолжуулах зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын А/243 тоот тушаалаар Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл хариуцах албан тушаалтныг томилох тухай тушаалыг боловсруулан батлуулав.<br>2. ***Бодлого, үйл ажиллагаа, цаг үе, үйл явдлын мэдээ мэдээллийг шуурхай бэлтгэн мэдээллийг хүртээмжтэй ил тод байдлаар олон нийтэд хүргэх талаар:***<br>-Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгийг 100 хувь олгохтой холбоотой Төсвийн хуульд оруулах тодотголын талаар постерууд /10/ бэлтгэн түгээв.<br>-Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн төслийг сурталчлан мэдээ мэдээллийг өргөн хүрээнд түгээж ажиллав.. Өдрийн сонинд ТНБД Г.Өнөрбаярын 2,5 нүүр томхон ярилцлагыг бэлтгэн нийтлүүлэв. 10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч сурвалжлагчдыг урьж Г.Өнөрбяар даргаар ярилцлага өгүүлэв. Б.Батжаргал даргын ярилцлагыг бэлтгэн бүх өдөр тутмын сонин, 30 гаруй мэдээллийн сайтад өгөв.<br>-Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, “Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл” зэрэг хууль эрх зүйн орчныг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайжруулах чиглэлээр зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг зэргийг тухай бүр мэдээлж ажиллав.<br>-Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх тэмдэглэлт болон баярын өдөрт зориулсан зурагт мэндчилгээг тогтмол бэлтгэн түгээж ажиллав. Тухайлбал, Хүүхдийн эрхийн өдөр, Хүүхдийн байгууллагын ойн баярын өдөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдөр, Олон Улсын гэр бүлийн өдөр гэх мэт. | |
| 147. | Нэгдсэн арга хэмжээ, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Нэгдсэн арга хэмжээний мэдээлэл сурталчилгаан ы ажлын төлөвлөгөө гарган, системтэй үе шаттай нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах. Хамтран ажиллагч олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, төрийн байгууллагын мэдээлэл сурталчилгаан ы ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана. | Нэгдсэн арга хэмжээ, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. | Нэгдсэн арга хэмжээ, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн мэдээлэл сурталчилгааны ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан байна. | “Найз байя” аяны мэдээлэл сурталчилгааны ажлыг хийж гүйцэтгэв.<br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд зохион байгуулсан үйл явдал арга хэмжээний мэдээ сурвалжилгыг бэлтгэн түгээв.<br>Старт Ап Улсын уралдааны ажлын хэсэгт орон мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулав.<br>“Шинэ сэргэлт Ахмадын оролцоо” үндэсний чуулганы ажлын хэсэгт ажиллаж, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулав.<br>“Хүүхдийн чуулган”, “Залуучуудын чуулган”, “ЖД бизнес эрхлэгчдийн чуулга уулзалт” зэрэг нэгдсэн арга хэмжээний мэдээлэл сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж сурталчлав.<br>“Career expo-2023” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажиллан мэдээлэл сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд зохион байгуулав.<br>“Барилга, байгууламжийн аюулгүй чанар, аюулгүй байдал эрүүл ахуйн аян”, “Хамтдаа шалгая, хамгаалъя” аян зэрэг нэгдсэн нөлөөллийн арга хэмжээг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж, өргөн хүрээнд мэдээлэл сурталчилгаа хийв.<br>Жайка ОУ-ын байгууллагын дэмжлэгтэй DPUB2 төслийн хүрээнд бэлтгэсэн нийтлэл, видео контент бүтээхэд зөвлөн тусалж, 20 нийтлэлийг редакторлаж, түгээв.<br>ОУ-ын хөдөлмөрийн байгууллагатай ХАБЭА-н сарын аян, Хүүхдийн хөдөлмөрийг устгах | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэлхийн өдрийн хүрээнд зохион байгуулсан ажил арга хэмжээг олон нийтэд хүргэх мэдээлэл сурталчилгааны ажлыг хамтран гүйцэтгэв.<br>-ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр Хөдөлмөрийн тухай хуулийн онцлох зохицуулалтаар хийсэн 20 ширхэг видео шторкийг олон нийтэд хүртээмжтэй хүргэхээр фэйсбүүк бүүстийн зардал шийдвэрлүүлэн гүйцэтгэв. | |
| 148. | Яамны цахим хуудсыг англи хэл дээр хөгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, орчуулсан мэдээ, мэдээллийг байршуулна. | Үйл ажиллагааны зардал | Орчуулгыг үнэн зөв хийх, зохион байгуулалтаар хангаж яамны цахим хуудсаас англи хэл дээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ. | Цахим хуудсыг шинэчлэх, баяжуулах ажлыг эхлүүлсэн | -яамны цахим хуудсанд байршуулах мэдээллийг нэгтгэн бэлтгэсэн байна.<br>-1-р улиралд цахим хуудсанд ерөнхий мэдээ, мэдээллийг байршуулсан байна.<br>-Цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр орчуулсан байна. | Цахим хуудсын англи хувилбарын хөгжүүлэлтийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>-Цэсийг монгол хувилбараас цомхон болгож, байршуулав.<br>-Яамны удирдлагуудын намтар, байгууллагын бүтэц, салбарын хуулийн жагсаалт, яамны эрхэм зорилго, зорилтууд зэрэг мэдээллийн англи хэл дээрх орчуулгыг гүйцэтгэж цахим хуудсанд байршуулав.<br>-Мэдээ, мэдээллийг англи хэл дээр хөрвүүлснийг вэб сайтруу тухай бүр оруулж ажилласан. | 100 |
| ***4.1.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг төлөвлөх, удирдлага, зохицуулалтаар хангах, салбарын хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх, төсвийг зарцуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, тооцоо гаргахад дэмжлэг үзүүлэх, төрийн сангийн салбарын үйл ажиллагааг эрхлэх, яамны дотоод санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, тайлагнах*** | | | | | | |
| ***Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн богино, дунд хугацааны стратеги, үндсэн чиглэлийг үндэслэн Засгийн газрын тусгай сангуудын болон салбарын богино, дунд хугацааны төсвийн бодлогыг тодорхойлон улсын нэгдсэн төсөвт тусгуулах*** */ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.3.1/* | | | | | | |
| 149. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн богино, дунд хугацааны стратеги, үндсэн чиглэлийг үндэслэн Засгийн газрын тусгай сангуудын болон салбарын богино, дунд хугацааны төсвийн бодлогыг тодорхойлон улсын нэгдсэн төсөвт тусгуулна. | 2023 оны төсөв Нийгмийн даатгалын сан 3,679.7 тэрбум төг,<br>ХНХ-ын сайдын багц 2,728.6 тэрбум төг.<br>Үүнд:<br>*-Нийгмийн халамжийн сан 1,952.0 тэрбум төг.* | - 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд салбарын бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, төсвийн төсөл, төсвийн сар, улирлын хуваарийн саналыг холбогдох тооцоо, судалгааны хамт хуульд заасан | -2023 оны батлагдсан төсөв, төсвийн хуваарийг харьяа байгууллагуудад хүргүүлсэн байна.<br>-МУ-ын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд салбарын | -Салбарын харьяа төсөвт байгууллагууд болон ЗГ-ын тусгай сангуудын 2023 оны батлагдсан төсвийг 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/3121 дугаар албан бичгээр хүргүүлж, төсвийн хуваарийг хуулийн хугацаанд ирүүлэх чиглэлийг хүргүүлэв.<br><br>-ЗГ-ын тусгай сангууд болон салбарын харьяа байгууллагуудын 2023 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг Сангийн яамны төсвийн програмд байгууллага бүрээр эдийн засгийн ангиллаар шивж, батлагдсан хуваарийг 2023 оны 01 сарын 23-ны өдрийн 01/200 дугаар албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | *Нийгмийн даатгалын сан татаас 545.2 тэрбум төг.*<br>*-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 92.4 тэрбум төг.*<br>*-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 12.9 тэрбум төг.*<br>*-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбар 35.2 тэрбум төг.*<br>*-Хөрөнгө оруулалт 36.8 тэрбум төг.*<br>*-Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар 34.3 тэрбум төг,*<br>*-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн салбар 12.5 трэбум төг,*<br>*- Бусад харьяа байгууллагууд 7.3 тэрбум төг.* | саналыг тусган Сангийн яаманд хүргүүлнэ.<br>- 2024 оны төсвийн зарлагын хязгаарт салбарын саналыг нэгтгэн Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлнэ.<br>- 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлнэ.<br>- 2024 оны төсвийн төслийг Сангийн яамаар хянуулах болон ЗГ, УИХ-аар хэлэлцэх үед холбогдох тайлбар, тодруулгыг бэлтгэн удирдлагыг мэдээллээр хангана. | хугацаанд Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлагдсан. | бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн саналыг тусган СЯ-нд хүргүүлсэн байна.<br>-Төсвийн захирагч нарын 2024 оны төсвийн зарлагын хязгаарт салбарын саналыг нэгтгэн Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.<br>-Харьяа агентлаг, төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийж, хүсэлтийг зохих түвшинд шийдвэрлэсэн байна.<br>-2024 оны батлагдсан төсвийн хязгаар болон ирэх жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг харьяа байгууллагуудад хүргүүлж, 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 | бичгээр харьяа байгууллагуудад хүргүүлэн шинэ төсвийн жил эхлэхэд гүйлгээ хийх нөхцлөөр хангаж ажиллав.<br><br>-Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд салбарын бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн саналыг тусган 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02/827 дугаар албан бичгээр Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.<br><br>-Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн зарлагын хязгаарт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын саналыг нэгтгэн 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/1551 дугаар албан бичгээр Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүллээ.<br><br>-Харьяа агентлаг, төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг төсвийн гүйцэтгэл, байгууллагын хэрэгцээ шаардлагад үндэслэн хянаж, төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийх, төсвийн тодотголд тусгах шаардлагатай асуудлыг тухай бүр Сангийн яаманд хүргүүлэн зохих түвшинд шийдвэрлүүлж салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах, шинээр өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллалаа.<br>-МУ-ын 2023 оны төсвийн тухай, НДС-ийн 2023 оны төсвийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1450 дугаар албан бичгээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллав.<br><br>-ХНХ-ын салбарын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн саналыг МУ-ын төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - Салбарын сар, улирлын хуваарийг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж, төсвийн програмд байгууллага бүрээр эдийн засгийн ангиллаар шивж ирэх жилийн төсвийн жил эхлэхэд гүйлгээ хийх нөхцлөөр хангана. | | оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд СЯ-нд хүргүүлсэн байна.<br>-2024 оны төсвийн төслийг Сангийн яамаар хянуулах болон ЗГ, УИХ-аар хэлэлцэх үед холбогдох тайлбар, тодруулгыг бэлтгэн удирдлагуудыг мэдээллээр хангасан байна<br>-ЗГ-ын тусгай сангийн болон салбарын сар, улирлын хуваарийг нэгтгэн СЯ-нд хүргүүлж, төсвийн програмд байгууллага бүрээр эдийн засгийн ангиллаар шивж ирэх жилийн төсвийн жил эхлэхэд гүйлгээ хийх нөхцлөөр хангасан байна.<br>-ТЕЗ-аас аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулах гэрээний хавсралтыг төсвийн тухай | дагуу боловсруулах заавар чиглэлийг харьяа байгууллагуудад хүргүүлэн саналыг нэгтгэн боловсруулж танилцуулга, холбогдох тоцооллын хамт 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/2020 дугаар албан бичгээр УИХ, ҮАГ, Сангийн яаманд хүргүүлж ажиллав.<br>-2024 оны төсөв хэлэлцэгдэх явцад салбарын сайд, удирдлагуудыг тайлбар, танилцуулга, мэдээллээр ханган ажиллав. 2024 онд ХНХ-ын сайдын багц 3,945.3 тэрбум төгрөг, НДС-ийн төсөв 5,188.4 тэрбум төгрөгөөр тус тус батлагдлаа.<br><br>Харьяа байгууллагуудад 2024 оны батлагдсан төсвийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 01/3116 дугаар албан бичгээр хүргүүлэв. Батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг орлого, зарлагын гүйцэтгэлд тулгуурлан үндэслэл сайтай боловсруулан хуулийн хугацаанд ирүүлэх заавар чиглэлийг өгч ажиллалаа.<br><br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ТЕЗ-аас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2023 онд байгуулах гэрээний хавсралтыг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, НДС-ийн 2023 оны төсвийн тухай хуулиудын хүрээнд боловсруулан бэлтгэж гэрээ хийх нөхцлөөр хангаж ажиллав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуулийн хүрээнд боловсруулсан бэлтгэсэн байна. | | |
| 150. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн богино, дунд хугацааны стратеги, үндсэн чиглэлийг үндэслэн салбарын богино, дунд хугацааны хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлон улсын төсөвт тусгуулна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалт – 36.8 тэрбум төг. | -МУ-ын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд тусгах салбарын хөрөнгө оруулалтын саналыг Сангийн яаманд хүргүүлнэ.<br>-2024 оны төсвийн зарлагын хязгаарт салбарын хөрөнгө оруулалтын саналыг нэгтгэн Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлнэ.<br>-Салбарын хөрөнгө оруулалтын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж, | Салбарын хөрөнгө оруулалтын 2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийн санал, төсвийн хязгаар, төсвийн төслийн саналыг холбогдох тооцоо, судалгааны хамт хуульд заасан хугацаанд Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлагдсан. | -Салбарын хөрөнгө оруулалтын 2023 оны хөрөнгийн хуваарийг батлуулан Сангийн яаманд хүргүүлсэн байна.<br>-МУ-ын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд тусгах салбарын хөрөнгө оруулалтын саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байна.<br>-Салбарын хөрөнгө оруулалтын саналыг хянаж нэгтгэн 2024 оны төсвийн зарлагын хязгаарт тусгуулах салбарын хөрөнгө оруулалтын саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байна.<br>-2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд тусгах салбарын хөрөнгө оруулалтыг нэгтгэн | -Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/201 дугаар тушаалыг гаргуулан Сангийн яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газруудад хүргүүлэв.<br><br>-Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл болон 2024 оны төсвийн зарлагын хязгаарт тусгуулах салбарын хөрөнгө оруулалтын саналыг нэгтгэн хуулийн хугацаанд хүргүүлсэн.<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам аргачлалууд”-ын дагуу төлөвлөж, Улсын Их Хурал, Үндэсний аудитын газар, Эдийн засгийн хөгжлийн яам болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2023 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн 01/2021 дугээр албан бичгээр хүргүүлэв.<br>Мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн https://pimis.publicinvestment.gov.mn цахим системд төсөл, арга хэмжээ бүрээр шивж баазыг хүргүүлсэн.<br>-2024 оны төсөв хэлэлцэгдэх явцад салбарын сайд, удирдлагуудыг салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээнүүдийн талаарх тайлбар, танилцуулга, мэдээллээр хангаж ажилласан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 2024 онд 48.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлнэ.<br>-2024 төсвийн төслийг Сангийн яамаар хянуулах болон ЗГ, УИХ-аар хэлэлцэх үед хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн тайлбар, тодруулгыг бэлтгэн удирдлагыг мэдээллээр хангана. | | боловсруулж, хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн байна.<br>-2024 оны төсвийн төслийг Сангийн яамаар хянуулах болон ЗГ, УИХ-аар хэлэлцэх үед хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төслийн талаар тайлбар, тодруулгыг бэлтгэн удирдлагыг мэдээллээр хангасан байна.<br>-ТЕЗ-аас аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулах гэрээний хавсралтад хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг орон нутгаар нь батлагдсан төсвийн хүрээнд боловсруулсан байна. | -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ТЕЗ-аас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2023 онд байгуулах гэрээний хавсралтад тусгагдах хөрөнгө оруулалтын зардлыг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хүрээнд боловсруулан бэлтгэсэн. | |
| 151. | Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа төсөвт байгууллагуудын | 2023 оны төсөв Нийгмийн даатгалын сан 3,679.7 тэрбум төг,<br>ХНХ-ын сайдын | -Төсвийн хэрэгжилтийг төсвийн тухай хууль, журмын дагуу зохион байгуулж, | ЗГ-ын тусгай сангууд болон харьяа байгууллагуудын 2023 оны сар, улирлын хуваарийг | -Төсвийн хэрэгжилтийг төсвийн тухай хууль, журмын дагуу зохион байгуулж, харьяа | Төсвийн хэрэгжилтийг төсвийн тухай хууль, холбогдох журмын дагуу зохион байгуулж, харьяа байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.<br>Салбарын харьяа төсөвт байгууллагууд болон ЗГ-ын тусгай сангуудын дансдаас 2023 оны | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсвийн хэрэгжилтийг хангуулах, холбогдох хууль, журамд нийцүүлэн батлагдсан төсөвт багтаан төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянаж нэгтгэнэ. | багц 2,728.6 тэрбум төг.<br>Үүнд:<br>*-Нийгмийн халамжийн сан 1,952.0 тэрбум төг.*<br>*Нийгмийн даатгалын сан татаас 545.2 тэрбум төг.*<br>*-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 92.4 тэрбум төг.*<br>*-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 12.9 тэрбум төг.*<br>*-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбар 35.2 тэрбум төг.*<br>*-Хөрөнгө оруулалт 36.8 тэрбум төг.*<br>*-Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар 34.3 тэрбум төг,*<br>*-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн салбар 12.5 трэбум төг,*<br>*- Бусад харьяа байгууллагууд 7.3 тэрбум төг.* | харьяа байгууллагууд ыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.<br>-Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг цахимаар хурдан шуурхай хийж гүйцэтгэнэ.<br>-Харъяа төсөвт байгууллагууд ын төлбөр тооцоог хийж гүйцэтгэхдээ зориулалтын зүйлд зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж, шинээр өр, авлага үүсгэхгүй байхад анхаарна.<br>-Харьяа байгууллагууд ын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянаж, нэгтгэн хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | төсвийн программ байгууллага бүрээр эдийн засгийн ангиллаар шивж, 2023 оны төсвийн жил эхлэхэд гүйлгээ хийх нөхцөл бүрэн хангагдсан. | байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангасан байна.<br>- Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг цахимаар хурдан шуурхай хийж гүйцэтгэсэн байна.<br>-Харъяа төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хийж гүйцэтгэхдээ зориулалтын зүйлд зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж, шинээр өр,авлага үүсгээгүй байна.<br>-Харьяа байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянаж, нэгтгэн хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, удирдлагыг мэдээллээр хангасан байна. | төсвийн жилд нийтдээ/2023-01-01-ээс 12 дугаар сарын 05-ны байдлаар/ 12,967 удаагийн төлбөрийн хүсэлтээр 3,797.5 тэрбум төгрөгийн зарцуулалтын гүйлгээг хянаж, ЗГСУМС-ээр хурдан шуурхай дамжуулж ажилласан.<br>Олон улсын байгууллагуудын гишүүнчлэлийн хураамж төлбөр болон Бүгд Найрамдах Солонгос, Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн санхүүжилтэд нийт 30 удаагийн 2,639.5 сая төгрөгийн гадаад гүйлгээг хянаж дамжуулсан.<br><br>Төсвийн тухай хууль, НББ-н тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны тухай журмыг үндэслэн Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянаж нэгтгэн, хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан.<br>Төрийн хэмнэлтийн тухай хууль болон хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоол, “МУ-ын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 72 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулан шинээр өр, авлага үүсгэхгүй байхад анхаарах заавар чиглэлийг 2023 оны 5 сарын 17-ны өдрийн 03/1345 дугаар албан бичгээр харьяа байгууллагуудад хүргүүлэв.<br><br>-Шилэн дансны цахим хуудсанд ХНХ-ын салбарын 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 8-ны дотор хуулийн хугацаанд байршуулж олон нийтэд ил тод мэдээлж ажиллалаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 152. | Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалт – 36.8 тэрбум төг. | -Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруултыг хууль, журмын дагуу зохион байгуулна.<br>- Салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажилд явцын хяналт тавьж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлж, төсвийн хөрөнгийг зөв зохистой, үр ашигтай удирдахад удирдлагыг мэдээллээр хангаж, харьяа байгууллагууд ыг мэргэжил арга зүйгээр хангана.<br>-Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээ, хагас бүтэн жилийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлж, батлагдсан | Салбарын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ болон худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах бэлтгэл ажил хангагдсан. | -Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруултыг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>-Салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажилд явцын хяналт тавьж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлж, төсвийн хөрөнгийг зөв зохистой, үр ашигтай удирдахад удирдлагыг мэдээллээр хангаж, харьяа байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангасан байна.<br>-Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээ, хагас бүтэн жилийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлж, батлагдсан төсөл, арга хэмжээ хугацаандаа | - Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 2023 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг Засгийн газрын 2022 оны 460 тоот тогтоол, УИХ-ын тогтоолыг үндэслэн 2023 оны 4-р сарын 1- ний дотор тендер зарласан байхаар боловсруулан Сангийн яаманд хүргүүлэн ажиллалаа. Мөн харьяа байгууллага агентлагуудад 2023 онд урсгал төсөв, бусад эх үүсвэрээр худалдан авах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөө болон 2022 оны худалдан авах ажиллагааны тайлан мэдээг төрийн худалдан авах ажиллагааны тендер.мн цахим системээр ирүүлэх байршуулан ажиллах тухай чиглэл зөвлөмжийг өгч, холбогдох хяналтыг тавьж ажиллалаа. Салбарын хэмжээнд нийт 37 байгууллага тайлан мэдээ ирүүлж, 33 байгууллага 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө цахим системд байршуулж баталгаажуулан ажилласан байна. 2023 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хүрээнд хэрэгжихээр нийт 33 төсөл арга хэмжээ батлагдсанаас шинээр хэрэгжих 1 төсөл арга хэмжээ “Өнөрбүл хүүхдийн төвийн их засвар”-ын холбогдох материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн ажиллалаа. Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдахаар эрх шилжин хэрэгжсэн “Өнөрбүл хүүхдийн төвийн их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын дүгнэлт зөвлөмжийн дагуу шалгарсан Найрамдал оргил ХХК-тай ХНХЯ/202301001/03/125 тоот гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилт 100% их засварын ажлыг Улсын комисст хүлээлгэн өгсөн байна.<br>Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд бүртгэн ажиллав.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих 2 төслийн нийт 11 арга хэмжээ, Дэлхийн банкны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөл, арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжинэ. -Харьяа байгууллагууд ыг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангаж, төлөвлөгөөг батлан, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнаж буй эсэхэд хяналт тавьж, тайланг хуулийн хугацаанд хүргүүлнэ. -Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан, мэдээг нэгтгэн удирдлагыг мэдээллээр хангана. -Салбарын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж, | | бүрэн хэрэгжсэн байна. -Харьяа байгууллагуудыг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангаж, төлөвлөгөөг батлан, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнаж буй эсэхэд хяналт тавьж, тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. -Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан, мэдээг нэгтгэн удирдлагыг мэдээллээр хангасан байна. - Салбарын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлж зохистой удирдахад удирдлагыг | санхүүжилтээр хэрэгжих 1 төслийн 20 арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянан баталгаажуулан ажиллалаа.<br><br>Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангаж ажиллав.<br><br>Азийн Хөгжлийн Банкны зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд дараах хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд Улаанбаатар хот болон 6 аймагт баригдаж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв"-ийн барилгын ажил 5 аймаг дээр гүйцэтгэл 100 % дуусаж улсын комисст хүлээлгэн өгсөн. Архангай аймагт баригдаж байгаа хөгжлийн төвийн барилгын гүйцэтгэл удаашралтай 70 хувийн гүйцэтгэлтэй гэрээний үүрэг биелэгдэхгүй байгаа тул гэрээг цуцлах хийгдсэн ажлыг хүлээж авах ажил явагдаж байна. Эдгээр барилгын ажлын гүйцэтгэлд 22.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.<br>Тус 6 аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвийн албан тавилга, тоног төхөөрөмж, туслах технологи, сургалтын хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчээр Интерсайнс ХХК-тай 2,138.4 сая төгрөг болон 1,45 мян.долларын, Хашхан ХХК-тай 172,2 мян долларын гэрээ байгуулсан. Гүйцэтгэл 100 хувь.<br>Мөн ХБХХЕГ-ын Протезийн үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах 2 төсөл арга хэмжээ хэрэгжиж эхний 21.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдэж дууссан.<br>Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвд сургалтын зориулалттай тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ хэрэгжиж 1,230.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулан гүйцэтгэл хангагдаж тоног төхөөрөмжийг хүлээн авлаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | түүний үр ашгийг дээшлүүлж зохистой удирдахад удирдлагыг мэдээллээр хангана. | | мэдээллээр хангасан байна. | "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2"-ийн санхүүжилтээр "Төгсөлтийн аргачлалаар туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний зөвлөхийг сонгон шалгаруулалт амжилттай явагдаж МУЗН-тэй гэрээ байгуулагдсан. Энэ арга хэмжээний хүрээнд сонгогдсон 1520 өрхөд өөрийн өрхийн үйлдвэрлэл явуулахад зориулж 10 нэр төрлийн үйл ажиллагааны тоног төхөөрөмж материал худалдан авах тендер зарлагдаж нийлүүлэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулан хэрэгжүүлсэн. 3.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.<br>Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд дараах хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>"Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлт"-ийн төслийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системийн сервер, програм хангамж, компьютер, тоног төхөөрөмжийг нийлүүлэх тендер зарлагдаж Саммит компьютер технологи ХХК, Хай Теч Солюшн ХХК-тай гэрээ байгуулагдсан ба гүйцэтгэл 100% байна. ХХҮЕГ-ын серверийн өрөө, үйлчилгээний болон сургалтын танхимуудын засварын ажлын зураг төсөв интерьер боловсруулах зөвлөх сонгон шалгаруулалтаар Их мянган инженерчлэл ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд гүйцэтгэл 11 сарын байдлаар 80 хувьтай явагдаж байна. | |
| 153. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн хагас, бүтэн жилийн тайланг хууль журмын дагуу нэгтгэн хуулийн хугацаанд аудитын дүгнэлт гаргуулан холбогдох газарт хүргүүлнэ. | 2023 оны батлагдсан төсөв Нийгмийн даатгалын сан 3,679.7 тэрбум төг,<br>ХНХ-ын сайдын багц 2,728.6 тэрбум төг.<br>Үүнд: | -ТЕЗ-ийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд аудитлуулан холбогдох газарт хүргүүлнэ.<br>-УСНББОУСтан | Өмнөх жилийн аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр цаашид анхаарч ажиллах заавар чиглэлийг харьяа байгууллагуудад | -ТЕЗ-ийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд аудитлуулан холбогдох газарт хүргүүлсэн байна.<br>-УСНББОУСтандарт болон НББ-ийн бодлогын баримт бичгийг салбарт | -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланг хүлээн авч Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу нэгтгэн ТЕЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг гаргав.<br>ТЕЗ-ийн 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайланг Үндэсний Аудитын газарт 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 02/905 тоот албан бичгээр хүргүүлэн санал дүгнэлт гаргуулан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | *-Нийгмийн халамжийн сан 1,952.0 тэрбум төг. Нийгмийн даатгалын сан татаас 545.2 тэрбум төг. -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 92.4 тэрбум төг. -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 12.9 тэрбум төг. -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбар 35.2 тэрбум төг. -Хөрөнгө оруулалт 36.8 тэрбум төг. -Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар 34.3 тэрбум төг, -Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн салбар 12.5 трэбум төг., - Бусад харьяа байгууллагууд 7.3 тэрбум төг.* | дарт болон НББ-ийн бодлогын баримт бичгийг салбарт мөрдүүлэн бүртгэлээр тавих хяналт сайжирна. -Удирдлагыг зөвлөгөө мэдээллээр хангаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. -Төсвийн хэрэгжилтэд явцын хяналт тавьж, ажлын уялдааг хангаж, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр хангана. | хүргүүлж, мэргэжил аргазүйгээр хангаж ажилласан байна. | мөрдүүлэн бүртгэлээр тавих хяналт сайжирсан байна. -Удирдлагыг зөвлөгөө мэдээллээр хангаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна. -Төсвийн хэрэгжилтэд явцын хяналт тавьж, ажлын уялдааг хангаж, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр хангасан байна. | ажиллалаа.<br><br>-ТЕЗ-ийн 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланг Төсвийн тухай хуулийн дагуу Сангийн яаманд 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/1114 тоот албан бичгээр хүргүүлэв.<br><br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны төсвийн багц 1,595.3 тэрбум төгрөгөөр батлагдаж 1,541.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч 96.5 хувийн биелэлттэй гарсан. Нийт зардлын 97.0 хувь буюу 1,494.2 тэрбум төгрөгийг урсгал зардал, 1.7 хувь буюу 25.9 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд, 1.3 хувь буюу 20.0 тэрбум төгрөгийг жижиг зээлд тус тус зарцуулсан байна. | |
| ***Яамны аппаратын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангах*** */ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.3.1/* | | | | | | | |
| 154. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль тогтоомж, | *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны төсөв 12.9* | Батлагдсан маягт зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, сар, | 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт | 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль тогтоомж, УСНББОУС-ын дагуу үнэн зөв гарган хуулийн хугацаанд Үндэсний Аудитын газарт хүргүүлж | 30 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | УСНББОУС-ын дагуу үнэн зөв гаргаж аудитын дүгнэлт гаргуулна. | *тэрбум төг* | улирал, жилийн санхүүгийн тайланг гаргаж, удирдлагыг шуурхай үнэн зөв мэдээллээр хангана. | авч ажилласан. | “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажилласан байна. | санал дүгнэлт гаргуулж ажиллалаа. | |
| 155. | Яамны эд хөрөнгиин бүртгэл, ашиглалтыг сайжруулна. | Үйл ажиллагааны зардал | Тооллого-2 Танилцуулга-2 | Жилд 2 удаа хагас, бүтэн жилээр тооллого хийж, удирдлагад танилцуулдаг. | Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна. | Яамны эд хөрөнгийн хагас бүтэн жилийн тооллогыг ТНБД-ын 2023.05.15-ний өдрийн А/136, 2023.11.30-ны өдрийн А/285 дугаар тушаалуудаар тооллогын ажлын хэсгийг томилон эд хөрөнгийн тооллогыг хийв. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2023 оны төсвийн жилд үндсэн хөрөнгө худалдаж аваагүй. Жилийн эцсээр шаардлага хангахгүй үндсэн хөрөнгийг актлах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлээд байна. | 100 |
| **4.2. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНД НЬ ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ, АУДИТ ХИЙХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.9-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***4.2.1. Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт шалгалт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх замаар оновчтой бодлого, стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх*** | | | | | | | |
| ***Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх*** */ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.4.1/* | | | | | | | |
| 156. | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЭЗХЯ-нд хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна. | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хяналт-шинжилгээ хийж үнэлгээний тайлан танилцуулгыг ТНБД болон нэгжийн удирдлагуудад танилцуулан Эдийн засаг хөгжлийн яаманд 2023 оны 03/2202 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хэрэгжилт 86.3%-тай үнэлэгдсэн байна. Үнэлгээний тайлан зөвлөмж, ТНБД-с өгсөн чиглэлийг холбогдох бодлогын газарт хүргүүлсэн. ХШҮДАГ-аас хэрэгжээгүй болон эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний жагсаалтыг ТЗУГ-т хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 157. | Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өглөө. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 96.6 хувьтай үнэлэгдлээ. Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| 158. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЭЗХЯ-нд хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа.<br>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх нийт 5 зорилго, 8 зорилтын 20 арга хэмжээ туссан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв. Нийт үнэлгээгээр Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 93.5 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 159. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 12 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна. | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны 2020-2024 оны төлөвлөгөөнд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн хэрэгжилт болон 2023 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10,11 дүгээр сарын байдлаар гарган Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах 18 зорилтын 47 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаа. ХШҮ-ний дүнг ЗГХЭГ-т хүргүүлэн цахим мэдээллийн санд сар бүр баталгаажуулж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг ТЗУГ-т гарган өгсөн. Жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна. | 100 |
| 160. | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 12 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЭЗХЯ-нд хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна. | Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний 2023 оны эхний хагас жил, 2023 оны 7, 8, 9, 10 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа.<br>Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийт 6 төсөл, арга хэмжээ 9 шалгуур үзүүлэлт туссан байна.<br>Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байна. | | | туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зоилт, арга хэмжээний хэрэгжилт:<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар:<br>- 74.0 хувь<br>7 дугаар сард:<br>- 73.3 хувь<br>8 дугаар сард:<br>- 68.9 хувь<br>9 дүгээр сард:<br>- 67.8 хувь<br>10 дугаар сард<br>- 67.8 хувь<br>11 дүгээр сард:<br>- 77.8 хувийн биелэлттэй байна.<br>Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг хяналтад авч, явцын хяналтыг тогтмол тавьж, хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг шуурхай зохион байгуулан хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэхэд онцгой анхаарч ажиллах талаар зөвлөмж өгч ТНБД-ын шуурхай хуралдаанд танилцуулсан. Мөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээний жагсаалтыг ТЗУГ-т гарган өгсөн. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт 86.7 хувийн үнэлгээтэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна. | |
| 161. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 12 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт- | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан байна. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад өгсөн үүрэг даалгаврын 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | | | тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад 2022 онд 84 шийдвэр, 253 заалтын хүрээнд үүрэг даалгавар өгсөн байна. Дээрх 253 заалт бүрийн хэрэгжилтийг хянан үзэхэд үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй 7 заалт, бусад байгууллагын эрхлэх асуудлын хүрээний 24 заалт байгаа бөгөөд нийт 222 заалтын хэрэгжилтийг тооцон үнэлэхэд 91.0 хувьтай байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад 2023 оны эхний хагас жилийн байдлаар 108 шийдвэр, 292 заалтын хүрээнд үүрэг даалгавар өгсөнөөс хэрэгжилт 82.1 хувьтай байна. Дээрх 292 заалтын хэрэгжилтийг тооцон үнэлэхэд бүрэн хэрэгжсэн 159 заалт, хэрэгжих шатандаа 72 заалт, хэрэгжилт хангалтгүй 38 заалт, хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй, бусад байгууллагын эрхлэх асуудлын хүрээний 23 заалт байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, танилцуулга, зөвлөмжийг дотоод албан бичгээр 2, албан мэйлээр 3 удаа яамны газрын дарга нарт хүргүүлж ажилласан. Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан эсэх талаар өмнөх хэрэгжилтийн тайлантай арга хэмжээ тус бүрээр харьцуулж, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй арга хэмжээ болгонд анхаарах болон хэрхэн сайжруулах талаар тусган, ХШҮДАГ, ЗГХЭГ-ын Хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн зөвлөмжийг жагсаалт бүрт оруулж, Төрийн захиргааны газарт хүргүүлсэн. Түүнчлэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай зүйл, заалтуудын хэрэгжилтэд явцын хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээний жагсаалтыг гарган Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. Хууль | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны болон 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг удирдлагуудад танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хугацаанд нь оруулж ажилласан. | |
| 162. | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 20 үзүүлэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 96.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 14 үзүүлэлт зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, 6 үзүүлэлт 69.9-98.0 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>БШУЯ-нд шилжсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын 2 үзүүлэлт үнэлэх боломжгүй байна. Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| 163. | Төсвийн тухай хуулийн дагуу ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтэд, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 2 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан СЯ-нд хүргүүлсэн байна. | Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрсэн үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.<br>Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад Хөдөлмөр, нийгмийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | | | хамгааллын салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт нийт 6 чиглэлийн 23 үзүүлэлт туссанаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн биелэлттэй 12, 90 хувийн биелэлттэй 7, 70 хувийн биелэлттэй 4 арга хэмжээ байна.<br>Нийт үнэлгээгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 91.7 хувьтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж газар, нэгжийн төлөвлөгөөнд тусган ажилласан байна.<br>Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан СЯ-нд хүргүүлсэн. | |
| 164. | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна. | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өглөө.<br>Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээ туссан байна.<br>Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 4 төсөл туссанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар 90 хувийн биелэлттэй 1, 70 хувийн биелэлттэй 1, 30 хувийн биелэлттэй 1, холбогдох шалтгааны улмаас хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна. Нийт дундаж үнэлгээгээр Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>байдлаар 63.3 хувийн биелэлттэй байна.<br>Тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй 1 төсөл, арга хэмжээг дундаж үнэлгээнд оруулан тооцоогүй болно.</td><td></td></tr>
<tr><td>165.</td><td>Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.</td><td>Үйл ажиллагааны зардал</td><td>-Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 5 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.</td><td>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.</td><td>Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан СЯ-нд хүргүүлсэн байна.</td><td>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт ХНХЯ үндсэн хэрэгжүүлэгчээр ажиллаж байгаа 4 төслийн нийт санхүүжилтын гүйцэтгэл 2022 оны эцсийн байдлаар 116,254,200.0 USD /мэдээлэл ирүүлээгүй төслүүдийн санхүүжилтын дүн ороогүй болно/ бөгөөд төслүүдийн ирүүлсэн мэдээллээс үзвэл гүйцэтгэл 80,0%-тай байна. Төслүүдийн хөрөнгө оруулалт 2022 оны эцэст 51,9 тэрбум төгрөг байна.<br>Танхимын болон цахим хэлбэрээр нийт 454 удаагийн сургалт зохион байгуулж 12964 хүнийг хамруулсан байна.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн 2022 оны жилийн хэрэгжилт салбарын хэмжээнд нэгтгэн авч үзвэл 75.1%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж байна.
<table>
<tr><th>Д/Д</th><th>Төслийн нэр</th><th>2022 оны үнэлгээ</th></tr>
<tr><td>1</td><td>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл</td><td>99.5%</td></tr>
<tr><td>2</td><td>Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл</td><td>36.0%</td></tr>
<tr><td>3</td><td>Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2</td><td>77.5%</td></tr>
<tr><td>4</td><td>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл</td><td>87.5%</td></tr>
<tr><td></td><td>Дундаж</td><td>75.1%</td></tr>
</table></td><td>100</td></tr>
<tr><td colspan="8">Байгууллагын үйл ажиллагаа, хамтран ажиллах гэрээний гүйцэтгэл, үр дүн, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх</td></tr>
<tr><td>166.</td><td>Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.</td><td>Үйл ажиллагааны зардал</td><td>-Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 2 тайлан<br>-Засгийн газрын 2020</td><td>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ,</td><td>Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т</td><td>Яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | үнэлгээ хийсэн. | хүргүүлсэн байна. | ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 хэсэг зорилт, арга хэмжээний нийт 207 арга хэмжээ туссан байна. Үүнээс 123 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 28 арга хэмжээ, 70 хувьтай 21 арга хэмжээ, 50 хувьтай 13 арга хэмжээ, 30 хувьтай 6 арга хэмжээ, хугацаа болоогүй 15 арга хэмжээ, хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна. Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо хугацаа болоогүй арга хэмжээг оруулан тооцоогүй болно.<br>Яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт эхний хагас жилийн байдлаар 90.0 хувьтай үнэлэгдлээ. ХШҮ-ний дүнг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлж ажилсан.<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар хэрэгжилт хангалтгүй байгаа 37 арга хэмжээний жагсаалтыг ТЗУГ-т гарган өгсөн. | |
| 167. | Харьяа агентлаг, төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 18 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ТЗУГ-т хүргүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу ХНХЯ-ны харьяа агентлаг, байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэлээ.<br>1. Харьяа агентлагын үнэлгээний дүн<br>№ \| Нэр \| Биелэлтийн хувь<br>1 \| Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар \| **93.0**<br>2 \| Нийгмийн даатгалын ерөнхий газар \| **92.0**<br>3 \| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар \| **90.7**<br>4 \| Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар \| **75.6** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Харьяа байгууллагын үнэлгээний дүн<br><br>№ \| Нэр \| Биелэлтийн хувь<br>1 \| БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв \| **90.8**<br>2 \| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ , судалгааны иниститут \| **87.7**<br>3 \| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв \| **82.9** | |
| 168. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 44 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагч Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний жилийн ецсийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгтгэн тайлан танилцуулгыг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т 2023 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 03/520 тоот албан бичгээр хүргүүлэв.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагч Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний эхний жилийн эцсийн биелэлт салбарын хэмжээнд нэгтгэн авч үзвэл гэрээний гүйцэтгэл 84.3 хувьтай үнэлэгдсэн байна. Аймаг, нийслэлийн Засаг дарга нар гэрээний хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн байна.  Тус гэрээний 2023 оны хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж удирлдагуудад танилцуулсан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хагас жилийн хэрэгжилт салбарын хэмжээнд нэгтгэн авч үзвэл гэрээний гүйцэтгэл 69.1 хувьтай үнэлэгдсэн байна. Гэрээний хэрэгжилтийн | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>дундаж үнэлгээгээр 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.3-т заасны дагуу “ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ” гэж дүгнэгдсэн.<br>Мөн Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр гэрээний хэрэгжилтэд явцын хяналт тавьж ажиллах талаар холбогдох газруудад зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар гэрээний төлөвлөлтөд ТЗУГ-н санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс, болон хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран ажиллаж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг хянаж санал өгсөн.</td><td></td></tr>
<tr><td>169.</td><td>Яамны нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.</td><td>Үйл ажиллагааны зардал</td><td>-Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 18 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.</td><td>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.</td><td>Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ТЗУГ-т хүргүүлсэн байна.</td><td>ХНХЯ-ны нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд Монгол Улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлээ.
<table>
<tr><th>№</th><th>Нэгж</th><th>Биелэлтийн хувь</th></tr>
<tr><td>1</td><td>Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар</td><td>95.2</td></tr>
<tr><td>2</td><td>Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>94.0</td></tr>
<tr><td>3</td><td>Бодлого төлөвлөлтийн газар</td><td>92.2</td></tr>
<tr><td>4</td><td>Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>91.7</td></tr>
<tr><td>5</td><td>Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>91.7</td></tr>
<tr><td>6</td><td>Салбарын хяналтын газар</td><td>91.2</td></tr>
<tr><td>7</td><td>Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>91.0</td></tr>
<tr><td>8</td><td>Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>91.0</td></tr>
<tr><td>9</td><td>Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</td><td>91.0</td></tr>
<tr><td>10</td><td>Төрийн захиргааны удирдлагын газар</td><td>90.0</td></tr>
</table></td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 170. | Яамны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлан хүргүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хүргүүлсэн. | Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралтын дагуу дүгнэхэд ерөнхий үнэлгээ 91.0 хувь буюу 4.55 оноотой байна. Үнэлгээний тайланг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| 171. | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2 зорилт, 7 үйл ажиллагаанд 13 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхэд 2022 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 10, 90 хувийн биелэлттэй 3 үйл ажиллагаа байна. Нийт үнэлгээгээр Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтлөбөрийн зорилт, үйл ажилагааны хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 97.7 хувьтай байна.<br>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг зорилт тус бүрээр харуулбал:<br>-Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын 3 үйл ажиллагаа 97.1 хувь,<br>-Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын 4 үйл ажиллагаа 98.3 хувьтай үнэлэгдлээ. Үнэлгээний тайланг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн.</td><td></td></tr>
<tr><td>172.</td><td>Байгууллагын ил тод байдлын үнэлгээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.</td><td>Үйл ажиллагааны зардал</td><td>-Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 1 тайлан<br>-Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.</td><td>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.</td><td>Үнэлгээний тайлан, зөвлөмжийг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.</td><td>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэллээ.<br>Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 91.3 хувьтай үнэлэгдлээ.<br>- "Бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан буюу 100 хувьтай 34 арга хэмжээ;<br>- "Хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа буюу 70 хувьтай -11 арга хэмжээ;<br>- "Хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй буюу 30 хувьтай- 1 арга хэмжээ;<br>Шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг тус бүрт нь авч үзвэл:<br><table><tr><th>№</th><th>Шалгуур үзүүлэлт</th><th>Шалгуур үзүүлэлтийн тоо</th><th>Хэрэгжилтийн хувь</th></tr><tr><td>1</td><td>Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал</td><td>10</td><td>91.0</td></tr></table></td><td>100</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td>2</td><td>Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал</td><td>6</td><td>100.0</td></tr>
<tr><td>3</td><td>Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал</td><td>15</td><td>91.3</td></tr>
<tr><td>4</td><td>Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал</td><td>2</td><td>100.0</td></tr>
<tr><td>5</td><td>Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал</td><td>13</td><td>86.2</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td>46</td><td>91.3</td></tr>
</table>
</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>173.</td>
<td>Төв, орон нутаг, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, холбогдох газар, албан тушаалтанд тайлагнана.</td>
<td>Үйл ажиллагааны зардал</td>
<td>Батлагдсан удирдамжийн дагуу холбогдох эрх зүйн актыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.</td>
<td>Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтэд 2022 онд дотоод хяналт, шалгалт хийсэн.</td>
<td>Харъяа байгууллагууд болон аймаг, дүүргийн газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, холбогдох арга хэмжээний саналыг Сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан байна.</td>
<td>ХНХ-ын Сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Өнөр бүл хүүхдийн төвийн 2021, 2022 оны үйл ажиллагаа, Хөдөлмөр,нийгмийн хамгааллын дэд сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн А/32 дугаар тушаалаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021, 2022 оны үйл ажиллагаа, ХНХ-ын сайдын 2023.06.13-ний өдрийн А/87 дугаар тушаалаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны үйл ажиллагаа, дотоод хяналт, салбарын хэмжээнд хийсэн хяналт шалгалт болон өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил, үр дүнд хяналт тавьж, холбогдох арга хэмжээний саналыг Сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж ажилласан. Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /ГБХЗХГ/-ын харьяа Хүүхдийн тусламжийн 108 утас, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр /ХХХҮТХБ/-нд үйлчилгээнд хамрагдсан бага насны хүүхэд бусдад зодуулсан тухай мэдээлэл 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 23 цагийн орчим олон нийтийн сүлжээ, цахим сайтуудаар цацагдсантай холбоотой тухайн мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах, ХХХҮТХБ-ны үйл ажиллагаа, ХНХЯ-наас 2022 онд тус хамгаалах байрны засвар тохижилтод зориулан шийдвэрлэсэн хөрөнгө санхүүжилтээр хийгдсэн ажлыг газар дээр нь үзэж шалгах</td>
<td>100</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорилгоор 2023 оны 03 дугаар сарын 31-ний түр хамгаалах байранд очиж ажилласан. Үүний дагуу бодит байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг Сайд, Дэд Сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарт танилцуулан саналыг авч ГББХЗГазар-т хүргүүлсэн. | |
| 174. | Сайдын тушаал, Сайдын зөвлөлийн хуралдаанаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 2 тайлан<br>-Холбогдох эрх зүйн актыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, зөвлөмж, холбогдох арга хэмжээний саналыг ТЕЗ-д танилцуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 онд гаргасан А тушаалын жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр тайлангийн маягтын сайдын туслахад хүргүүлэн үнэлгээ хийж байна. | 30 |
| 175. | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардал | -Танилцуулга, хавсралт бүхий үнэлгээний 2 тайлан<br>-Холбогдох эрх зүйн актыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн 2022 онд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Үнэлгээний тайлан, зөвлөмж, холбогдох арга хэмжээний саналыг ТШЗ-д танилцуулсан байна. | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 95.7% хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.<br>2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг авч үзвэл:<br>• “зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 100 хувьтай -257;<br>• зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарсан 70.0 хувьтай -4;<br>• “зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны жил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн 50.0 хувьтай 5;<br>• зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгаа 30.0 хувьтай 1;<br>• зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй -0 хувьтай 7 тушаал байна;<br>Тайлант хугацаанд гарсан 274 тушаалаас дугаар алгасч олгосон 5 тушаал, тодорхой шалтгааны улмаас хэрэгжээгүй 6 тушаал байна.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт 95.4% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.<br>2022 онд А/47, А/127, А/135, А/181, А/223, зэрэг тушаалын дугаар алгасч дугаарласан нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 8.1.12-т /Байгууллагаас боловсруулан баталгаажуулаагүй захирамжлалын болон зохион байгуулалтын баримт бичигт урьдчилан он, сар, бүртгэлийн дугаар олгохыг хориглоно/ заасныг зөрчсөн байна.<br>Хариуцсан мэргэжилтнүүд тушаалын хэрэгжилтийг заалт бүрээр гарсан үр дүнг оновчтой тодорхой тайлагнаагүй байгаа нь үнэлгээ хийхэд хүндрэл учруулж байна. | |
| ***Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах*** | | | | | | | |
| 176. | Дотоод аудитын хорооноос баталсан төлөвлөгөөний хүрээнд төсөвт байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтад дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмж, цаашид авах арга хэмжээний санал гаргана. | Үйл ажиллагааны зардал | Төсвийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм” | Баталсан төлөвлөгөөний хүрээнд төсөвт байгууллагуудад хяналт, шалгалт хийсэн. | -Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг ТЕЗ-ын баталсан удирдамжийн хүрээнд гүйцэтгэсэн байна.<br>-Дотоод аудитын үр дүнг Дотоод аудитын хороо болон ТЕЗ-д танилцуулсан | 1. ХНХ-ын Сайдын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу БНСУ дахь ХНХҮТ-ийн үйл ажиллагаатай холбогдох өргөдөл, гомдлыг судлах, 2020, 2021, 2022 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын хэсэг 2023.02.27-ны өдрөөс 2023.03.06-ны өдрүүдэд БНСУ-д томилолтоор ажиллан хяналт шалгалтын тайлан, дүгнэлт болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ТЕЗ-д танилцуулсан. Тайлангийн төслийг БНСУ дах ХНХҮТ-д 2022.03.24-ний өдөр хүргүүлж тайлбар, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна.<br>-Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | санал хүлээн ТЕЗ-д танилцуулсан. Хяналт шалгалтаар нийт 484,3 сая төгрөгийн зөрчил илэрсэн, илэрсэн асуудлуудын 70-аас дээш хувь нь байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл үүсгэх нөлөө ихтэй, ажлын хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатайг үндэслэн “Сайжруулалт шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн. Хяналт шалгалтаар илэрсэн асуудлыг арилгах, дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр 28 зөвлөмж өгсөн.<br>2. БНСУ дахь ХНХҮТ-д ажиллаж байсан иргэн Х.Золгэрэлээс тус төвийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл гомдлыг хяналт шалгалтын явцад судалж холбогдох дүгнэлт, саналыг 2023.04.10-ны 02/92 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>3. ХНХ-ын Сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Өнөр бүл хүүхдийн төвийн 2021, 2022 оны үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудит хийж тайлан, дүгнэлт болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ТЕЗ-д танилцуулсан. Тайлангийн төслийг хамрагдсан байгууллагад хүргүүлж 2023.05.24-ний өдрийн 223 дугаар албан бичгээр тайлбар санал хүлээн авч ТЕЗ-д танилцуулсан. Дотоод аудитаар нийт 475.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн, илэрсэн зөрчлийн 70-аас дээш хувь нь байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл үүсгэх нөлөө ихтэй, ажлын хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах, холбогдох хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатайг үндэслэн “Сайжруулалт шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн. Дотоод аудитаар илэрсэн асуудлыг арилгах дахин гаргахгүй байх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 24 зөвлөмж өгсөн.<br>4. ХНХ-ын дэд сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/32 дугаар тушаал, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 52 дугаар тушаалаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлагдсан ажлын хэсэг Хүүхдийн хөгжил хамгааллын 2020-2022 оны батлагдсан төсөв, зарцуулалтад хяналт шалгалт, дотоод аудит хийх ажлын хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Өмнөговь, Дундговь аймгийн ГБХЗХГ-ын хүүхэд хамгааллын зардлын 2020-2022 оны төсвийн зарцуулалт үр дүнд дотоод аудит хийж, аудитаар илэрсэн нийтлэг зөрчил, дутагдал, тайлан дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагчид танилцуулан цаашид анхаарах асуудалд санал хүргүүлсэн.<br>5. ХНХ-ын сайдын 2023.06.13-ний өдрийн А/87 дугаар тушаалаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 төсвийн хөрөнгийн зарцуулалт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалт хийх удирдамж, хөтөлбөр боловсруулан батлуулж 2023.06.14-ны өдрөөс хяналт шалгалтын ажил эхлэн хийн цаашид авах арга хэмжээний санал, дотоод аудитын хорооны тогтоолын төсөл бэлтгэн ТЕЗ-д танилцуулсан.<br>Дотоод аудитаар нийт 95,6 сая төгрөгийн зөрчил илэрсэн, илэрсэн зөрчлийн 80-аас дээш хувь нь байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл үүсгэх нөлөө ихтэй, ажлын хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах холбогдох хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатайг үндэслэн “Сайжруулалт шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн. Дотоод аудитаар илэрсэн асуудлыг арилгах дахин гаргахгүй байх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 13 зөвлөмж өгсөн.<br>6. Иргэн Г.Түмэнжаргалын 11-11 төвд гаргасан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Аами Таами тасагт хэвтэн эмчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд Номин ХХК-аас олгосон хандивын хоол, хүнсийг зориулалт бусаар зарцуулж байна гэх гомдлын дагуу 2023 оны 10 дугаар сарын 09-нөөс 16-ны өдрүүдэд ажилтан, албан тушаалтантай уулзаж ярилцах, тус тасгийн үйл ажиллагаа болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүнсний агуулах, гал тогооны хэсэгт хандив, тусламжаар ирсэн хоол хүнсний материалын хадгалалт, олголт, бүртгэлд тусгасан байдал, хэрхэн хяналт тавьж байгаатай танилцаж холбогдох анхан шатны баримт, материалыг татан авч түүврийн аргаар хяналт шалгалт хийж иргэн Г.Түмэнжаргалд ТНБД-ын 2023.10.18-ны өдрийн 3/410 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>Гомдлын хүрээнд зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, дотоод хяналт, хариуцлагыг сайжруулах, хандив, тусламжийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авах, бүртгэх, зарцуулах журмыг шинэчлэн мөрдөж ажиллах хугацаатай үүрэг даалгаврыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхбатад 2023.10.18-ны өдрийн 3/411 дугаар албан бичгээр, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Ц.Нямсүрэнд 2023.10.18-ны өдрийн 3/412 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>7. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудит хийх ажлын удирдамж, хөтөлбөрийг сайдын тушаалаар батлуулан аудитын ажлыг 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 177. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллана. | Үйл ажиллагааны зардал | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих | Шилэн дансны тухай хуулийн дагуу хяналт тавьж ажилласан. | ХНХ-ын салбарын харьяа төсөвт байгууллага, тусгай сангуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавин, зөвлөмж, үүрэг даалгаврын | 1. Ерөнхий Сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 албан даалгаврын дагуу ЦХХЯ-тай хамтран Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа тусгай сангууд болох Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн зарцуулалтыг 2012 оноос, Халамжийн сангийн зарцуулалтыг 2008 оноос, Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарцуулалтыг 2008 оноос, Хүүхдийн төлөө | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” | | биелэлтэд хяналт тавьж удирдлагыг мэдээллээр хانган ажилласан байна. | сангийн зарцуулалтыг 2020 оноос тус тус ил тодоор шилэн дансны цахим хуудсанд нээлттэйгээр байршуулан ажилласан.<br>2. Шилэн дансны цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбогдуулан харьяа агентлаг, байгууллага төсвийн шууд захирагч нартай цахим уулзалтыг 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж шинэ цахим хуудсанд мэдээлэл байршуулах зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн ажилласан.<br>3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа байгууллагууд болон яамны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд сар бүрийн 05-07-ны өдрийн хооронд дотоод сүлжээгээр холбогдох албан хаагчдад хуулийн хугацаанд мэдээллээ байршуулахыг сануулан ажилласан.<br>4. ТЕЗ-ийн хамрах хүрээний агентлаг, харьяа байгууллага, тусгай сан, төсөл хөтөлбөрүүд болох 24 байгууллагын 2023 оны эхний 9 сарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цахим хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдлыг хянан үзлээ. Салбарын хэмжээнд 2023 оны эхний 9 дүгээр сарын байдлаар нийт 3299 мэдээлэл байршуулахаас 3020 мэдээллийг хуулийн хугацаанд, 133 мэдээллийг хугацаа хоцроосон, 48 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулаагүй байгууллагууд руу холбогдож, мэдээллийг 12 дугаар 05-ний өдрийн дотор байршуулах чиглэлийг хүргүүлсэн. ХШҮДАГ-аас 12 сард хийх хяналт шалгалтын удирдамжид шилэн дансны хуулийн хэрэгжилт, мэдээлэл байршуулсан байдлыг нотлох баримтаар тулган шалгана. Салбар байгууллагуудын 2023 оны шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн дундаж 97 хувьтай байна. | |
| 178. | Төрийн аудитын байгууллага болон дотоод аудит, хяналт шалгалтаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний | Үйл ажиллагааны зардал | ҮАГ, Сангийн яам, Дотоод аудит, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, акт, албан | Үндэсний аудитын газар, Сангийн яам, дотоод аудит, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, | Үндэсний аудитын газар, Сангийн яам, дотоод аудит, хяналт шалгалтаар | 1. ДАХ-нд 2022 оны дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэсэн аудитаар өгсөн зөвлөмж болон Дотоод аудитын хорооны 2022 оны 2022/01, 2022/02, 2022/03 дугаар тогтоолоор ХНХЯ-ны холбогдох газар, хэлтэс, агентлагийн дарга нарт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт тавих, уялдаа холбоог хангах, дүн шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тайлагнана. | | шаардлага | албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тухай бүр тайлагнаж удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна. | өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулга бэлтгэн Сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарт танилцуулсан.<br>2. Сайдын 2023 оны А/59 дүгээр тушаалаар батлагдсан “Төрд учирсан хохирлыг барагдуулах ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа аймаг, дүүргийн газар, хэлтсийн удирдах ажилтан, албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон ажилтан, албан хаагчдын мэдээлэл, шүүхийн шийдвэрийн огноо, дугаар, тухайн шийдвэр гаргасан албан тушаалтны хаяг, төрд учирсан хохирлын нөхөн төлбөрийн мөнгөн дүн зэргийг тодруулан агентлаг тус бүрээр шинэчлэн гаргасан.<br>Нийт 48 албан тушаалтны буруу шийдвэрийн улмаас 94 төрийн албан хаагчид 602,324.6 мянган төгрөгийн нөхөн олговор олгох шүүхийн шийдвэрээс 78,946.5 мянган төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж 515,767.6 мянган төгрөгийн төрд учирсан хохирлыг барагдуулах албан бичиг, мэдэгдэл хүргүүлээд байна.<br><br>Албан бичгийн дагуу хохирлыг барагдуулаагүй тохиолдолд хуулийн байгууллага, Төрийн албаны зөвлөлтэй хамтран хохирол барагдуулах ажил зохион байгуулахаар ажиллаж байна.<br>3. ХНХ-ын сайдын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн тайлан, харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан, салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийсэн аудит болон Сангийн яамны “Дотоод аудитын хороо”-ны 2022 оны 14, 15 дугаар тогтоолоор өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангах, он дамжин хуримтлагдсан авлагыг барагдуулах, дотоод хяналтыг сайжруулах зэрэг чиглэлээр төлөвлөгөө боловсруулан Сайдын 2023.06.09- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ний өдрийн А/86 дугаар тушаалаар батлуулж ХХҮЕГ, НДЕГ, ХБХХЕГ, ГБХЗХГ-т 2023.06.13-ны өдрийн 12/1576 дугаар албан бичгээр хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж биелэлтийг Үндэсний аудитын газрын fas.audit.mn цахим программд оруулж хүргүүлсэн.<br>Сайдын тушаалаар батлагдсан төлөвлөгөө болон ҮАГ-аас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэн 2023 оны 11 дүгээр сарын 16-26-ны өдрүүдэд харьяа агентлаг, төсөвт байгууллагын дотоод аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмж, албан шаардлага, акт, үүрэг даалгаврын хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарч ажиллах, урт хугацаанд хуримтлагдсан авлага барагдуулалтын талаар санал солилцон, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж өгч мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан.<br>4. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд Үндэсний аудитын газраас 2022 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 3/537 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>5. Сангийн яамны “Дотоод аудитын хороо”-ны 2022 оны 14, 15 дугаар тогтоолоор өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2023.06.08-ны өдрийн 12/1546 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| **4.3. ЭРСДЭЛД СУУРИЛСАН САЛБАРЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТЫГ МӨРДҮҮЛЭН МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ИРГЭДИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГУУЛАХ, ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД ХӨДӨЛМӨРЛӨХ ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ БҮХИЙ ҮР ДҮНТЭЙ ЦОГЦ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| 179. | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, асуудлыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулна. | Улсын төсөв | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хувь | 2022 онд шийдвэрлэлт 95.8% байсан. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 100 хувьд хүргэсэн байна. | Салбарын хэмжээнд нийт 844 албан бичиг, 596 өргөдөл гомдол хүсэлт хүлээн авч, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 1516 заалттай 155 улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, нийт зөрчлийн 1578 /75%/-ийг арилгуулж үйлдвэрлэлийн ослын 25 дүгнэлт гаргаж ажиллалаа. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн улсын байцаагчийн 84 акт үйлдэж 2.910.640.800 төгрөгийн нөхөн төлбөр, 64 ААНБ, иргэнд 123.100.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа. | |
| 180. | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийнэ. */Хяналт шалгалтын нийтлэг журмын 3.8.3-т заасан нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн/* | Улсын төсөв | Эрсдэл үүсэх магадлалын хувь бууруулах:<br><br>Зөрчил арилгуулалтын хувийг нэмэгдүүлэх:<br><br>Хууль сахин мөрдөлтийн түвшин 65%-д хүргэх | 2022 онд хяналт шалгалтын хүрээнд нийт зөрчил 3486 илрүүлсэний 942 буюу 27%-ийг арилгуулсан.<br><br>2022 онд хяналт шалгалтын дүнгээр эрсдэл үүсэх магадлал 35.9%<br><br>Хууль сахин мөрдөлтийн түвшин 63.3% | Эрсдэл үүсэх магадлалын хувь 2%-оос дээш хувиар буурсан байна.<br><br>Зөрчил арилгуулалтын хувийг 5-иар нэмэгдүүлэх<br><br>Хууль сахин мөрдөлтийн түвшин 65%-д хүрсэн байна | 2023 онд хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөсөн объектын 1721 буюу 71.3%-ийг хамруулж ажилласан байна.<br>Хяналт шалгалт хийгдээгүй 692 шалгалтын шалтгаан нөхцлийн харвал: Дэлхий нийтийг хамарсан цар тахлын дараах нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалтай холбоотойгоор үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан, хөрөнгө оруулалт, санхүүжилт зогссон 250 /36.1%/, Хаяг байршил тодорхойгүй 145 /21%/, барилга байгууламжийг улсын коммист хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан 117 /16.9%/, хуулийн этгээдийн бүртгэлийг бусдад шилжүүлсэн, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн 91 /13.2%/, улсын байцаагчгүйн улмаас хяналт шалгалтын ажил хийгдээгүй 89 /3.6%/ байна.<br>Хяналт шалгалтад хамрагдсан объектуудад хяналтын хуудсаар үнэлгээ хийхэд:<br>• Хууль сахин мөрдөлтийн түвшин 64.8%<br>• Эрсдэл үүсэх магадлал 33.6%<br>Мөн хяналтын хуудсаар үнэлэгдсэн объектуудын эрсдэл үүсэх магадлалын хувь 33.6% болж, 2.3 пунктээр буурсан, салбарын хууль сахин мөрдөлтийн түвшин 64.8% болж, 1.5% пунктээр өссөн сайн үзүүлэлттэй байна.<br>Хяналт шалгалтын явцад хяналтын хуудсаар 20334 зөрчил илрүүлж газар дээр нь 4510 /22.1%/-ийг арилгуулж, улсын байцаагчийн 15607 заалттай 1154 албан шаардлага хүргүүлж нийт илрүүлсэн зөрчлийн 76.1%-ийг арилгуулж ажилласан байна.<br>Улсын хэмжээнд 2023 оны байдлаар нийт 207,750.0 сая.төгрөгийн торгууль ногдуулж 100% биелэлттэй, 7,107,400,362 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн актуудыг тогтоосон бөгөөд актын барагдуулалтын хугацаа болоогүй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 181. | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд эрүүл ахуйн хэмжилт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. | Үйл ажиллагааны зардал | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой зөрчил, дутагдал, гаргасан дүгнэлтийн тоо | 2022 онд нийт 251 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт шинжилгээ хийж, улсын /ахлах/ байцаагчийн 251 дүгнэлт гаргасан байна. | Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөл, стандарт шаардлага хангагдсан байна. | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийдэг 7 аж ахуй нэгж байгууллагад урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийлээ.<br>Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар нийт 30 зөрчил илрүүлэн, 7 зөрчлийг газар дээр нь арилгуулж, улсын ахлах байцаагчийн 26 заалт бүхий 4 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулж ажиллалаа. | 100 |
| 182. | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | Улсын төсөв | -Шалгалт хийсэн объектын тоо;<br><br>-илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь;<br><br>-эрсдэлийн түвшин буурсан объектын тоо. | -2017 онд Нийгмийн халамжийн байгууллагуудын нийгмийн халамжийн сангийн Тэтгэвэр, тэтгэмжийн санд хийсэн шалгалтаар нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч нийт 23 иргэн 1 сараас 6 жил хугацаанд 34.9 сая төгрөгийн тэтгэвэр давхар авч байсан зөрчлийг илрүүлж улсын байцаагчийн 12 акт тогтоож, зөрчлийг арилгуулахаар 64 заалттай 16 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Үүнээс хойш дахин шалгалт хийгдээгүй болно.<br>-2021 онд зөвхөн | -ХХҮЕГ, нийслэлийн ХХҮГ, 21 аймгийн ХХҮГ, 9 дүүрэг ХХҮХ-т хяналт, шалгалт хийсэн байна.<br>-Шалгалтын дүнг үндэслэж, холбогдох арга хэмжээ авсан байна. | Салбарын хяналтын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр баталсан 07/09 тоот урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу ХХҮЕГ, Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /хэлтэс/-т урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ.<br>Шалгалтаар Нийгмийн халамжийн сангаас 2021, 2022 онуудад үзүүлсэн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээтэй холбоотойгоор 2719 иргэнд хамааралтай 457,350.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.<br>Дээрх зөрчлүүдийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 62 актаар 183,083.5 мянган төгрөгийн нөхөн төлбөр, 145,239.8 мянган төгрөгийн зөрчлийг 115 заалт бүхий 30 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 74,705.0 мянган төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулахаар, 54,321.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, зөвлөгөө өгч зөрчлүүдийг гаргахгүй байх чиглэлээр зааварчилгаа өгч ажиллалаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүнсний эрхийн бичгийн олголт, зарцуулалтад хяналт шалгалт хийгдсэн. | | | |
| 183. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ. | Улсын төсөв | -Шалгалт хийсэн объект /Хөтөлбөр/ -ын тоо,<br>-илрүүлсэн зөрчил арилгуулалтын хувь | 2018 онд ХЭД сангийн зарцуулалтад төлөвлөгөөт хяналт шалгалт хийснээс хойш дахин шалгалт хийгдээгүй болно. /зассан/ | -ХЭҮЗ-ийн тогтоолоор баталсан 7 хөтөлбөрөөс 3 хөтөлбөрийг сонгон хяналт шалгалт хийсэн байна.<br>-Шалгалтын дүнг үндэслэж, холбогдох арга хэмжээ авсан байна. | Салбарын ерөнхий байцаагчийн 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдөр баталсан 07/22 тоот урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021-2022 оны бүрдүүлэлт, зарцуулалт, Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, “Оролцоо” төсөл, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн (Старт-ап төсөл) хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн санхүүгийн холбогдох баримт материал, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнд Агентлаг, нийслэл, 18 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 28 улсын /ахлах/ байцаагч нар хийж гүйцэтгэлээ.<br>Шалгалтаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийг хугацаандаа төлөөгүй, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж нь төслөө зориулалтын дагуу хэрэгжүүлээгүй, хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэлтийн сургалтад иргэдийг давтан болон ажил хөдөлмөр эрхэлдэг иргэдийг хамруулсан, нийтийг хамарсан ажилд ажил хөдөлмөр эрхэлдэг иргэдийг (түр ажлын байранд) хамруулсан, сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан зэрэг зөрчилтэй холбоотой агентлаг, 7 аймаг, нийслэл, 9 дүүрэгт нийт **3,725.9 сая** төгрөгийн зөрчил илэрсэн.<br>Илэрсэн зөрчлийн 19,7 хувь буюу **734.7** сая төгрөг Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжих хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийг хугацаандаа төлөөгүй, Хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэлтийн сургалттай холбоотой 0.4 хувь буюу **15.0 сая** төгрөг, түр ажлын байранд шаардлага хангахгүй иргэдийг хамруулсан 0.1 хувь буюу **4.7 сая** төгрөг, урамшууллаас НДШ ногдуулж төлөөгүй, Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг зориулалтын бус, үр ашиггүй зарцуулсан 1,5 хувь буюу **55.2 сая** төгрөг, Ахмадын, Эмэгтэйчүүд, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой баримтын бүрдүүлэлт дутуу 78,3 хувь буюу **2,916.2** сая төгрөг тус тус зээлж байна.<br>Шалгалтаар улсын (ахлах) байцаагчийн **75** заалттай **26** актаар **809,7 сая** төгрөгийг санд нөхөн төлүүлэхээр тогтоож, зөрчлийг арилгуулахаар **57** заалттай **47** албан шаардлага гаргаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах талаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан мэргэжилтэн, холбогдох албан тушаалтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>ХХҮЕГ нь Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийн хэрэгжүүлэх зорилгоор ХНХ сайдын Эрх шилжүүлэх тухай 2021 оны 77 дугаар тушаалаар Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарим арга хэмжээний худалдан авах ажиллагааг БХЯаманд эрх шилжүүлэн **2,916.2** сая төгрөгийн санхүүжилтийг ХЭД-аас шилжүүлсэн байх боловч гүйцэтгэл, хяналт тавих, тайлагнах үүргээ биелүүлээгүй, анхан шатны баримт бүрдүүлээгүй зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч гүйцэтгэлийг хангуулахаар тус тус ажилласан.<br>Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн Өвөрхангай аймгийн 21 иргэний 8.8 сая төгрөг, Залуучуудын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 4 иргэний 9.8 сая төгрөг, Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 7 иргэний 3.4 сая төгрөг нийт 22,0 сая төгрөг, мөн санхүүгийн дэмжлэгийн гэрээний мөнгөн дүн болон хугацаа засвартай, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу (батлан даагчийн баримт бичиггүй) байхад санхүүжилт олгосон, төслийн явцын тайлан ирүүлээгүй зэрэг Ховд аймгийн 8 зөрчлийн 30,0 сая төгрөг, Дархан-Уул аймгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан 13 иргэний 3,2 сая төгрөг зэрэг нийт **92,6** сая төгрөгийн 73 зөрчлийн 53 зөрчил буюу 55,2 сая төгрөгийн зөрчлийг газар дээр нь арилгуулан санд буцаан төвлөрүүлж, 4,4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын (ахлах) байцаагчийн хугацаатай 5 заалт бүхий 1 албан шаардлага гаргаж, Ховд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлд 3 заалт бүхий 1 дүгнэлт хүргүүлсэн. Хяналт шалгалтын явцад Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 10 сарын Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд олгогдсон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн дутуу болох 34.0 сая төгрөгийг төлүүлэхээр материалыг бүрдүүлэн Шүүхийн эвлэрүүлэн зуучлахад шилжүүлсэн.<br>Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад Дорнод аймгийн ХХҮГ нь нэг байгууллагад давуу эрх олгож олон төрлийн дэмжлэгүүдийг олгосон, зориулалт бусаар ашигласан, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, төсөл хөтөлбөрүүд эзэн холбогчдодоо хүрээгүй, баримтгүй гүйлгээ гарсан, цар тахлыг далимдуулж хэрэгслүүд авсан гэх боловч тодорхойгүй, хөтөлбөр төсөлд зориулсан гэх бензин, бичиг хэргийн зардлууд их зарцуулагдсан, хүний бичиг баримтыг ашигласан, өнгөрсөн оны баримт хуулбарлаж бүрдүүлсэн, танил тал найз нөхдөө хамруулсан, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүний лангуу дэлгүүр үзүүлж эргэн төлөгдөх чадваргүй хүнд зээл олгож өр үүсгэсэн, хөтөлбөр төсөлд хамрагдсан иргэнээс 50 хувийн санхүүжилтыг буцаан авсан зэрэг ноцтой зөрчлүүд илэрсэн. Дээрх зөрчил дутагдлууд болоод өмнөх онуудын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар байгууллага, удирдлагын зүгээс авсан арга хэмжээ байхгүй, ашиглал, зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг давтан гаргуулахгүй байх, төсвийн хөрөнгийг хуулийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулахын тулд 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 392 албан тоот бичгээр Дорнод аймгийн Цагдаагийн газарт шалгуулахаар шилжүүлсэн байна. | |
| 184. | Уул уурхай, тээвэр, хүнд үйлдвэрийн салбарт хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ. | Улсын төсөв | Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ | шинээр хийх ажил | Ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийхгүй байгаа шалтгааныг тодруулж, зөрчлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Тоос, шуугианы зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн зөрчлийг арилгуулсан байна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 07/13 дугаартай удирдамжаар уул уурхай, зам тээвэр, хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 18 аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 150 аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 1898 зөрчил илэрснээс 197 буюу 10.2 хувийг газар дээр нь арилгуулж, 164 аж ахуй нэгж байгууллагад 1863 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлж, 17 аж ахуйн нэгж, байгууллагад 312,742,525.0 төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, 40 хуулийн этгээдэд 51,250,000.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Хөдөлмөрийн тухай хуулийн сахин мөрдөлтийн хувь 63,6, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн сахин мөрдөлтийн хувь 64,4 хувьтай үнэлэгдсэн. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар дээрх 2 хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь тус бүр 5 хувиар өссөн байна. | 100 |
| 185. | Барилга, замын салбарт урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ. | Улсын төсөв | -Шалгалт хийсэн объектын тоо, -илрүүлсэн | шинээр хийх ажил | -Нүүрсний тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгчдийн | Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж буй аж ахуйн нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. Шалгалтад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зөрчил, арилгуулалтын хувь, -эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | | нийгмийн баталгааг хангуулах, хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд хамтарсан урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн байна. -Шалгалтаар илэрсэн зөрчлийг 100% арилгуулсан байна. -Торгууль, нөхөн төлбөрийг бүрэн барагдуулсан байна. | 448 аж ахуй нэгж, байгууллагыг хамруулж, нийт 4207 зөрчил илрүүлж , илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 2991 заалттай 266 албан шаардлага хүргүүлж, 25 аж ахуй нэгж, байгууллагуудад 25800,0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж 100% барагдуулсан. Мөн 2 байгууллагад 25200.0 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн нөхөн төлбөрийн акт тогтоож, 2 ААНБ-д Зөрчлийн тухай хуулийн заалтаар тус бүр 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний шийтгэлийн арга хэмжээ авч 3.000 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж ажилласан байна. | |
| 186. | Морь унаач хүүхдийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ. | Улсын төсөв | “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” MNS 6264:2018 стандартын хэрэгжилт, эцэг эх, даатгалын байгууллага, морь уяачдын хоорондын гурвалсан гэрээ, 8-аас | Нийт уралдаанд оролцсон хүүхдүүдийн 98% хувь нь хантаазтай, 70 хувь нь стандартын малгайтай, 90 хувь нь стандартын өвдгөвч тохойвч өмссөн байв. Уралдааны үед 48 хүүхэд мориноос унаж, 37 бэртэлгүй, 11 хүүхэд хөнгөн гэмтэж эмчлүүлсэн. | Шалгалтаар илэрсэн зөрчлийг 90-с доошгүй хувиар арилгуулсан байна. | Салбарын ерөнхий байцаагчийн 2023 орны 05 дугаар сарын 01-ний өдрийн 07/10 дугаар удирдамжаар Үндэсний их баяр наадам, улс, аймгийн бүсийн наадам, аймаг сумын ойн болон тусгай тэмдэглэлт баяр наадам зэрэг хурдан морины 408 уралдаанд хурдан морины унаач хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллалаа. Дээрх хурдан морины уралдаануудад давхардсан тоогоор 29717 хүүхэд 59954 хурдан морийг унаж, уралдаанд оролцлоо.<br>Хууль тогтоомжийг зөрчсөн 25, 3353 хүүхэд хамгаалах хэрэгсэл өмсөөгүй, 6182 хүүхэд хамгаалалтын дуулга өмсөөгүй, 514 хүүхэд морины хэрэгсэл стандартын шаардлагад нийцээгүй зөрчилүүдийг газар дээр нь арилгуулж ажилласан. Мөн газар дээр нь арилгуулах боломжгүй зөрчил 6898 хүүхэд буюу даатгалгүй, 8580 хүүхэд уяач, эцэг эх, асран хамгаалагч нарын гурвалсан гэрээгүй, 25 хүүхэд 8-аас доош насанд хүрээгүй, 6182 хүүхэд буюу 21% нь | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | доош насны хүүхэд морь унаагүй байх | | | хамгаалах хэрэгслийг солих, өөрчлөх боломжгүй гэх мэт/ гаргасан уралдаанч хүүхдүүдийг уралдааны замд гаргалгүй, үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа. Мөн холбогдох байгууллагуудад 118 албан бичиг, 1142 зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.<br>Улсын хэмжээнд давхардсан тоогоор 31709 зөрчил илрүүлж, 100% арилгуулж ажиллалаа. | |
| 187. | Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ашиглаж буй тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангасан байдлыг хянан баталгаажуулж, гэрчилгээ олгоно. | Үйл ажиллагааны зардал | Хянан баталгаажуулж олгосон гэрчилгээний тоо | 2021 онд 513 байгууллагад үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээ олгосон. | Үйлдвэрлэл, үйлчилгээний машин механизм, тоног төхөөрөмжийн баталгаат засвар үйлчилгээг тогтмол хийж, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал хангагдсан байна. | “Үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, гэрчилгээ олгох журам”-ыг сайдын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/26 дугаар тушаалаар батлуулж ажиллалаа. Тайлант хугацаанд 78 аж ахуй нэгж, байгууллагын хүсэлтээр 823 тоног төхөөрөмж, машин механизмд 78 гэрчилгээ олгосон байна. | 100 |
| 188. | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актыг хянан баталгаажуулах арга хэмжээ авна. | Үйл ажиллагааны зардал | Хянан баталгаажуулж олгосон гэрчилгээний тоо | 2021 оны 11 сарын 29-ний байдлаар 250 үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт баталгаажуулсан. | Үйлдвэрлэлийн осол хурц хордлогын акт хугацаандаа баталгаажиж, холбогдох байгууллагад мэдээлэл бүрэн хүрсэн байна. | 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар үйлдвэрлэлийн осол хурц хордлогод нийт 157 хүн өртөж, үүнээс 13 хүн нас барсан, 77 хүн хүнд бэртсэн, 67 хүн хөнгөн гэмтсэн байна. Нийт осолд нас баралтын эзлэх хувь 8.2 хувь буюу 12 осол тутмын нэг нь нас баралтад хүргэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ослын нийт тохиолдол 186, нас баралт 35, хүнд гэмтэл 88, хөнгөн гэмтэл 63 тохиолдолоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.<br>-Тайлант хугацаанд уул уурхай, олборлолтын салбарт 31 осол бүртгэгдэж, үүнээс 1 хүн нас барж, 11 хүн хүнд, 19 хүн хөнгөн гэмтсэн байна. Нийт бүртгэгдсэн ослын 19,7 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт гарсан байна.<br>-Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 21 осол бүртгэгдсэн нь нийт ослын 13,3 хувийг хамаарч байна.<br>-Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 21 осол бүртгэгдсэн нь нийт ослын 13,3 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувийг хамаарч байна.<br>-Барилгын салбарт 12 осол бүртгэгдэж, үүнээс 1 хүн нас барж, 5 хүн хүнд, 6 хүн хөнгөн гэмтсэн нь нийт ослын 7,0 хувийг хамаарч байна.<br>Унаж, бүдрэх халтирсны улмаас үйлдвэрлэлийн осолд өртсөн нь нийт шалтгааны 36,3 хувийг, эд зүйлд хавчуулагдах шалтгаан 16,5 хувийг, унаж байгаа эд зүйлд цохигдох шалтгаан 8.9 хувийг тус тус эзэлж байна.<br>Тайлант хугацаанд баталгаажуулсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоо 157, нас барсан хүний тоо 13, 10,000 хүнд ногдох ослын коэффицент 1,308, 10,000 хүнд ногдох хүндрэлийн коэффицент 0,108 байна. | |
| **5. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 189. | Асрамж, халамжийн төвүүд, НЦҮТ, ТХБ-ын нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйн сургалт хийж гарын авлага боловсруулна. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Сургалтын хөтөлбөр<br>Гарын авлага-1 | Арга зүйн сургалт хийгдсан байна.. | Бүх асрамж, халамжийн төв, НЦҮТ, ТХБ-ууд хангагдсан байна. | 1. Асрамж, халамжийн төвүүд, НЦҮТ, ТХБ-ын нийгмийн ажлын үйлчилгээний төвийн ажилтнууд зэрэг 60 албан хаагчдыг “Нийгмийн ажлын стандарт, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний журмын хэрэгжилтийн арга зүйн сургалт”-д хамруулж, “Хүүхдийн эрхийн стандартын эмхэтгэл” гарын авлагыг олгосон.<br>2. Асрамж халамжийн төвүүдийг судалгаанд хамруулж, үйлчилгээний зардлын нормативыг шинэчэн боловсруулах хэлэлцүүлгийг зохион байгуулж, саналыг тусган “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын норматив”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу анхан шатанд ажилладаг 21 аймаг, 9 дүүргийн 765 Хамтарсан багийн 6008 гишүүнээр дамжуулж иргэн бүрийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллаж байна. Хамтарсан багийн гишүүдэд зориулсан арга зүйн 12 цуврал гарын авлагыг боловсруулж, НҮБ-ын Хүн амын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр 2023 оны 05 дугаар сараас эхлэн 9 аймаг, 4 дүүргийн 1599 Хамтарсан багийн гишүүд, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу чиг үүргийг хариуцан гүйцэтгэдэг 168 холбогдох албан хаагчдийг чадавхжуулах кейс менементийн сургалт зохион байгуулсан. 5 дүүрэг, 12 аймгийн сургалтыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.<br>4. Тус яамнаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, зохицуулагч нарт “Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид ээлтэй үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, 70 албан хаагчийг хамруулсан. Энэхүү сургалт нь Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвд ирсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх арга зүйг эзэмшүүлэх зорилготой зохион байгуулагдсан.<br>5. Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны сэтгэл зүйч нарт зориулсан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон даван туулагч эмэгтэйчүүдэд тулгамддаг сэтгэл зүйн зөвлөгөөний цогц сургалт”-ыг 2023 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 21 аймаг 9 дүүргийн ТХБ, НЦҮТ-ийн 40 сэтгэл зүйч, ГБХЗХГазар, хэлтсийн мэргэжилтнийг хамруулсан. Тус сургалтаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв болон аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтсийн сэтгэл зүйч нарт сэтгэл зүйн зөвлөгөөний цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, мөн сэтгэл зүйн зөвлөгөөний цогц багцыг хүлээлгэн өгсөн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 190. | Хүүхдийн эрхийн статистик үзүүлэлтийг мөрдүүлэх чадавхи бэхжүүлэх үндэсний сургалт зохион байгуулна. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Сургалтын төлөвлөгөө-1 Сургалтад хамрагдсан хүний тоо | Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар 169 үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж, ҮСХ-ны даргын 2022 оны А/172 дугаар тушаалаар баталсан. | Сургалтыг зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 02 дугаар сарын А/25 тоот тушаалаар “Хүүхэд, залуучуудын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, мэдээлэл цуглуулах маягт, маягтыг нөхөх заавдрыг шинэчлэн боловсруулах” ажлын хэсэг байгуулсан. Уг ажлын хэсгийн хүрээнд дараах ажил хийв.<br>-Хүүхдийн дотоодын 2 зөвлөхтэй хамтран дэд ажлын хэсгээр 7 удаа уулзалт, хурал зохион байгуулж, Тогтвортой хөгжлийн зорилт, ЮНИСЕФ болон бусад олон улсын хүүхдийн статистикийн үзүүлэлт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн хүүхдийн эрх, хамгааллын 175 үзүүлэлтийн аргачлалын төслийг эцэслэн боловсруулсан. Төслийг ҮСХ-ны аргазүйн байнгын зөвлөлийн хурал болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. | 30 |
| 191. | Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний стандартыг мөрдүүлнэ. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | ТНБД тушаал-1<br><br>Сургалтанд хамрагдсан ЗХТ-ийн ажилтнуудын тоо | Сургалтын хөтөлбөр батлагдсан байна. | 21 аймаг, 9 дүүрэг, сумдын 35-аас доошгүй ЗХТ-ийн ажилтнуудыг хамруулсан байна. | Залуучуудын үйлчилгээний төвийн үйлчилгээний стандартын төсөл болон хүүхэд, өсвөр үеийн хөгжил, хамгааллын бусад холбогдох стандартын төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний 03/131 дүгээр гэрээний үр дүнд "Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төв, үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 7012:2023 стандарт" батлагдсан. Стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд ЗХТ-үүдэд стандартын шаардлагыг хангаж буй байдалд үнэлгээ хийх, үнэлгээнд үндэслэн стандартын шаардлагыг хангахад шаардагдах арга хэмжээний хөтөлбөр, хөрөнгө оруулалтын төсөвлөлтийг боловсруулах арга хэмжээг 12 дугаар сард төлөвлөсөн. | 100 |
| 192. | Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлнэ. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Батлагдсан төлөвлөгөө-1 Хэрэгжилтийн тайлан-1 | 2022 онд ЗХТ-ийн сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг цахимаар хүргэж эхэлсэн. | Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд “Unitel hub” цахим сургалт, мэдээллийн цэгийг аймгийн Залуучуудын хөгжлийн төвийн дэргэд байгуулахад ХНХЯ болон “Юнител” групп хамтран ажиллаж байна. Залуучууд “Unitel hub” цахим сургалт, мэдээллийн цэгээр үйлчлүүлснээр цахим орчноос шаардлагатай мэдээллээ авах, ном унших, сонсох, Mplus аппликэйшн ашиглах, Look TV болон бүх төрлийн цахим хичээлүүд үзэх, англи хэл, мэдээлэл зүй, монгол бичиг, код бичих сургалтад хамрагдах, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Кино цаг”, “Амжилт” өглөөний ярилцлагад оролцох боломжтой. Төвийг туршилтаар Дархан-Уул аймагт 2022 онд байгуулсан. 2023 онд Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай, Дорнод, Дорноговь, Увс, Орхон, Өмнөговь, Хөвсгөл зэрэг 11 аймагт байгуулсан. 2024 онд бусад бүх аймагт, цаашид алслагдсан дүүргүүдэд байгуулахаар төлөвлөсөн. Төв байгуулах арга хэмжээний цар хүрээг тэлэх, талуудын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс Харилцан ойлголцлын Санамж бичгийг ХНХЯ, “Юнител групп” 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан. Санамж бичгийн хүрээнд электроникийн суурь ойлголт олгох, бичил программчлалын АРДУИНО хавтан дээрх Электрокид сургалт, робот угсралт, код бичих программчлалын Робокид сургалтуудыг орон нутагт зохион байгуулах сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж, 12 аймгийн 22 сургагч багш, залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг хамруулсан. | |
| 193. | Хөдөлмөрийн зуучлагч, арбитрчдыг бэлтгэх, чадавхижуулах ажлыг ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үндэсний байгууллагатай хамтран зохион байгуулна. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | Сургалтын хөтөлбөр Зуучлагч, арбитарчдын жагсаалт | “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”, “Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам” | Зуучлагч, арбитарчдыг сургаж бэлтгэх хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн дагуу бэлтгэсэн байна. | -Хөдөлмөрийн тухай хуулийн 147.3-т заасны дагуу “Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам” болон “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг Засгийн газрын 2023 оны 04, 05 дугаар тогтоолоор, “Хөдөлмөрийн зуучлагчийн ёс зүйн дүрэм”, “Хөдөлмөрийн арбитрчийн ёс зүйн дүрэм”-ийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2023 оны 03 дугаар тогтоолоор тус тус батлууллаа.<br>Нийслэлийн хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитрчдын нэрсийн жагсаалтыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2023 оны 04, 05 дугаар тогтоолоор тус тус батлуулав.<br>“Хөдөлмөрийн зуучлагчдад зориулсан сургалтын модуль”, “Хөдөлмөрийн арбитрчдад зориулсан сургалтын модуль”-ийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэй боловсруулан, хөтөлбөрийн дагуу нийслэлийн 22 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн зуучлагч, 7 хөдөлмөрийн арбитрчийг сургаж бэлтгэлээ.<br>Хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитрчдын нэрсийн жагсаалтыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 08, 09 дүгээр тогтоолоор тус тус баталлаа. | |
| 194. | Хөдөлмөрийн хууль тогтоомжийг ажилтан, ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, сургалт зохион байгуулна. | Олон улсын байгууллагын санхүүжилт | Сургалт-3 | Зарим орон нутагт хуулийн сургалтыг зохион байгуулсан. | Улаанбаатар хотод болон зарим орон нутагт сургалт зохион байгуулсан байна. | -“Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд ажилтан, ажил олгогчдын оролцоо” сургалт, хэлэлцүүлгийг Завхан, Говь-Алтай, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Дундговь, Баян-Өлгий аймгийн төлөөллийг оролцуулан 2023 оны 10-11 дүгээр сард зохион байгуулж, ажилтан, ажил олгогч байгууллагуудын нийт 250 төлөөллийг хамруулав.<br>-Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ/ ажил олгогчдод зориулсан “Хүүхэд, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцаа” гарын авлагыг 2023 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр боловсруулан, аж ахуйн нэгж, байгууллага хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлдэг эсэх талаарх судалгааг хийж, 90 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, хүний нөөц, захиргааны ажилтнуудыг хамруулсан сургалтыг 3 удаа зохион байгуулсан. | 100 |
| 195. | Хөдөлмөрийн маргааны чиглэлээрх сургалтын хөтөлбөр боловсруулна. | Олон улсын байгууллагын санхүүжилт | Сургалтын хөтөлбөр | “Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны дүрэм”-ийг батлуулсан. | Хөдөлмөрийн маргааны хөтөлбөр гарсан байна. | Хөдөлмөрийн маргааны 5 багц сургалтын модулийг ОУХБ-ын дэмжлэгтэй боловсруулан гаргалаа. Тухайлбал “Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтын модуль”, “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын гишүүдэд зориулсан сургалтын модуль”, “Сум дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны гишүүдийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтын модуль” боловсруулан гарын авлага болон түгээсэн. Модуль, хөтөлбөрийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд сургалтыг зохион байгууллаа. Сургалтад хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, дүүргүүдийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны гишүүд, аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн маргаан таслах комиссын гишүүд 200 орчим хүн хамрагдсан. Мөн Хөдөлмөрийн маргаан зохицуулалтын асуудлаар “Сургагч багш” бэлтгэх сургалтын модулийг боловсруулан, модулийн дагуу сургалтыг ОУХБ-ын дэмжлэгтэйгээр 2023 оны 11 дүгээр сарын 22-24-ний хооронд зохион байгуулж, 21 сургагч багшид гэрчилгээ олгов. Сургалтад хөдөлмөрийн эрхийн маргаан ихтэй 5 аймгийн ХХҮГ-ын албан хаагч, нийгмийн түншлэлийн төлөөллүүд, хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитрчдын төлөөллөөс хамруулав. | |
| 196. | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах, шалгалт авах журам”-ын дагуу үндэсний хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулна. | ҮОМШӨДС 40.0 сая.төг | Сургалт – 4 удаа | 195 сургагч багш бэлтгэсэн байна. | 280 орчим сургагч багш бэлтгэсэн байна. | Сургагч багшийн сургалтыг 12 дугаар сард багтаан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 30 |
| 197. | Салбарын албан хаагчдад мэдээллийн технологи, статистикийн ойлголт, хэрэглээг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагааны зардал | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 сургалт зохион байгуулсан. | 4 сургалт зохион байгуулсан байна. | “21-р зууны Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл (ПАРИС 21)”-ийн ОУ-ын уулзалт, хэлэлцүүлгээр “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бүртгэл, статистик, мэдээллийн сангийн өнөөгийн байдал” сэдэвт сургалтыг ҮСХ-той хамтран зохион байгуулсан.“21-р зууны Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл (ПАРИС 21)”-ийн ОУ-ын уулзалт, хэлэлцүүлгээр “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бүртгэл, статистик, мэдээллийн сангийн өнөөгийн байдал” сэдэвт сургалтыг ҮСХ-той | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран зохион байгуулсан.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд дотоод удирдлагын систем шинээр нэвтрүүлсэнтэй холбоотой бичиг хэрэг, архив болон тушаал шийдвэр хариуцсан албан хаагчдад болон нийт албан хаагчдад системийг хэрхэн ашиглах талаарх сургалтыг ганцаарчилсан болон бүлэг хэлбэрээр 4 удаа зохион байгуулсан. | |
| 198. | Салбарын статистикийн болон танилцуулга, тайлан мэдээг боловсруулах, холбогдох албан хаагчийг мэдээллээр хангана. | Үйл ажиллагааны зардал | Боловсруулсан илтгэл, танилцуулга, товхимлын тоо | 38 постер, илтгэл, ном товхимол бэлтгэсэн. | 20 постер, илтгэл, ном товхимол бэлтгэсэн байна. | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, мөн Төрийн захиргааны болон төрийн тусгай албаны ангилал зэрэглэл, цалингийн сүлжээг шинэчлэлтэй шинэчлэлтэй холбогдуулах нөлөөллийн ажлын хүрээнд 67 постер болон 31 танилцуулга, 1 ном бэлтгэсэн.<br>Нийгмийн халамжийн маягт шинэчлэгдсэнтэй холбоотой Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн нийгмийн халамжийн сан хариуцсан ахлах болон олголт хариуцсан мэргэжилтнүүд сургалт зохион байгуулсан. Хамрагдсан албан хаагчдын тоо Танхимаар-313, Цахимаар-320 Статистик, тоон өгөгдөл хариуцсан нэгжийн удирдлага, албан хаагчдад Өгөгдлөөс олж авах анхан шатны мэдээллүүд, Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй, Статистикийн дүн шинжилгээ хийх арга зүй, тайлан мэдээ гаргах урсгалын талаар сургалтуудыг тус тус зохион байгуулсан. | 100 |
| 199. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ (хөтөлбөрүүд)-г олон нийтэд сурталчилан таниулах нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна. | ХЭДС, НҮБХХ, ДБ-ы төсөл 125.0 сая төг. | Арга хэмжээ -1 | Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөр 2022-2023 оны хууль, тогтоожийн эмхтгэлийг хэвлүүлсэн. /300 ширхэг/, видео шторк хийгдсэн. | Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр олон нийтэд сурталчилан таниулах нөлөөлийн ажил хийгдсэн байна. Үүнд: 15 Видео, 50,000 брошур, гарын авлага 7,000, плакат 1,500 хийгдсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр олон нийтэд сурталчлан таниулах нөлөөллийн ажлын хүрээнд Европын холбооны санхүүжилттай “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр 5 төрлийн видео, 7 төрлийн брошур, плакат, гарын авлага, эх бэлтгэлийн дизайн гаргахад хамтран ажиллаж, эх бэлтгэлийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. Үүнээс нэг төрлийн гарын авлага болох “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж”-ийг албан хэрэгцээнд зориулан 6000 ширхэг хэвлүүлж, аймаг, дүүргийн хөдөлмөрийн мэргэжилтнүүдэд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр олон нийтэд сурталчлан таниулах нөлөөллийн ажил хийх төлөвлөгөө боловсруулан яамны хэвлэлийн албатай хамтран ажилласан. Энэ хүрээнд Жижиг зээл олгох арга хэмжээ, И-Жоб платформын хөгжүүлэлтийн явц болон иргэдэд үзүүлэх үйлчилгээний танилцуулга, Профайлинг үйлчилгээ, Өмнөх мэдлэг ур чадварыг хүлээн зөвшөөрүүлэх төсөл /RPL/ гэх мэт ажлуудыг видео, брошур хэлбэрээр яамны вэб сайт пэйж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевизээр дамжуулан сурталчилсан.<br>Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдрийг угтан Сүхбаатарын талбайд салбарын “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг 2023 оны 5 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уг өдөрлөгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаа, үйлчилгээг иргэдэд хүргэж, иргэдийг бүртгэх, ажилд зуучлах, төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, салбарын цахим үйлчилгээний талаарх заавар зөвлөгөө гэх мэт олон талын үйлчилгээг нэг дор хүргэж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг сурталчлан таниулсан.<br>Мөн түүнчлэн ажлын байрны зуучлал, танхимаар явагдах хэлэлцүүлэг арга хэмжээ нь байршил үл харгалзан, Expomongolia.org платформоор цахимаар давхар явагдаж, “Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөл” болон “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг танилцуулж, бүртгэл хийсэн.<br>Нэгдсэн өдөрлөгийн нээлтийн дараа залуучуудын хөдөлмөрийн өдөрлөгийг 10 их, дээд сургуулиудад 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл аян хэлбэрээр үргэлжлүүлэн зохион байгуулж, уг арга хэмжээний үр дүнд 2131 цагийн ажлын байрыг санал болгосноос 606 оюутан бүртгүүлж, 418 оюутан цагийн ажилд зуучлагдав.<br>Мөн хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль тогтоомжийн мэдээлэл, зөвлөгөөг 2200 орчим залуучуудад хүргэж ажиллалаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 200. | Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангаж, сурталчилан таниулна. | ХЭДС 100.0 сая төг. | Арга хэмжээ -1 | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хууль дагаж гарах журам, Засгийн газрын тогтоолыг боловсруулан батлуулах бэлтгэл хангасан. | Хуулийн сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна. Журмын хэрэгжилтийг хангаж, зохицуулалт хийн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг дагаж гарах журмын тухай хуулийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинэчлэн авсан 47 байгууллагад 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хуулийн танилцуулга, цаашид анхаарах асуудлын талаар сургалт, уулзалт зохион байгуулсан.<br>Түүнчлэн НҮБ-ийн ОУ-ын Шилжилт Хөдөлгөөний байгууллага болон “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсад хүчин чармайлалтыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад "Олон улсын хөдөлмөр зуучлалын нэгдсэн системийн ёс зүйтэй хөдөлмөр зуучлал" сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад оролцсон 40 тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон дагаж гарах журмуудын талаар танилцуулсан.<br><br>Мөн 2023 оны 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотод “Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн санхүүжилтээр зохион байгуулагдсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалтад Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, түүнийг дагаж гарах дүрэм журмууд, хуулийн хэрэгжилтэд анхаарах асуудлын талаар танилцуулсан. Сургалтад нийт 130 салбарын хяналтын улсын байцаагчид хамрагдсан.<br><br>-Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан дараах журмууд дагаж гарсан. Үүнд:<br>-Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуулийн 32.8-д “Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхтэй холбоотой журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу журмын төслийг хуулийн нэмэлт, өөрчлөлтэй уялдуулан боловсруулж холбогдох журмын дагуу яамдуудаас санал авч Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор батлуулсан.<br><br>-Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 24.6-д “Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг эрүүл мэндийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу “Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ыг боловсруулан хамтарсан тушаал батлуулахаар Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. | |
| 201. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг олон нийтэд таниулан сурталчлах, эмхэтгэл боловсруулж, хэвлүүлнэ. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр 40.0 сая төг. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн эмхэтгэл-1 | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн эмхэтгэлийг боловсруулж хэвлүүлсэн. /300ш/ | Төлөвлөгөөнд тусгасны дагуу 1 эмхэтгэл боловсруулан хэвлүүлсэн байна. | Нийгмийн даатгалын тухай хуулийн тогтоомжийн эмхтгэлийн эхийг 714 хуудастай шинэчилж боловсруулсан. | 100 |
| 202. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөө-1 | 2022 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулсан. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулсан байна. | 1. Олон улсын Хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр” болгон Олон улсын хэмжээнд тэмдэглэж байхаар шийдвэрлэсэнтэй уялдуулан жил бүрийн 4 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ний хугацаанд зохион байгууллаа.<br>Сарын аяны хүрээнд Аймаг, нийслэлийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаанд нийт 1200 гаруй ААНБ-ын 21000 гаруй ажилтан, албан хаагчдыг хамрууллаа. Аяны хүрээнд 3302 гарын авлага, 1039 зурагт хуудас, 1500 брошур танилцуулгыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түгээлээ. Мөн 5 сайтад мэдээлэл өгч 14134 иргэнд хүргэж, 48 удаа FB хуудсаар мэдээлэл гаргаж, 1 видео, контентоор сурталчилгаа хийж 12 дахь жилдээ амжилттай зохион байгуулж ажиллалаа.<br>2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтран баталсан “Барилгын байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” аяныг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, техник, технологийн аюулгүй байдал, учирч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах зорилгоор зохион байгуулсан.<br>Аяны хугацаанд нийт 842 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, 3846 зөрчил илрүүлэн 217 байгууллагад 2836 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, 46850,0 мян.төгрөгийн нөхөн төлбөр, 2390,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан.<br>Ажил олгогч, инженер техникийн ажилтнуудыг байлцуулан танхимын сургалтыг 2 удаа, аймаг, нийслэл, дүүрэгт 23 удаагийн сургалтыг зохион байгуулж 1814 хүнийг хамруулсан байна. | |
| 203. | Олон Улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллана. | Тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулсан төсвийн дэмжлэгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл | Хөдөлмөрийн нөхцөл, туршилт шинжилгээний төв /ХНШТ/-өөс хамгаалах хэрэгслийг баталгаажуулах лабораторийг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ. | 2022 онд лабораторийг бүрэн хэмжээгээр ажиллуулах боломжийг бүрдүүлсэн. | -Хөдөлмөрийн нөхцөл, туршилт шинжилгээний төв /ХНШТ/-өөс хамгаалах хэрэгслийг баталгаажуулах лабораторийг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг жигдрүүлсэн байна.<br>-Лабораторийг ашиглалтад | Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81, “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцуудад Монгол Улс нэгдэн орох талаархи судалгааны үр дүнг танилцуулах, санал авах хэлэлцүүлэгийг зохион байгуулсан.<br>Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81, “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцуудад Монгол Улс нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад санал авахаар ГХЯ, ХЗДХ яамдад 01/2341 тоот албан бичгийг тус тус хүргүүлж ажиллалаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оруулах хүрээнд хэмжилт, шинжилгээний 2 стандартыг Мэргэжлийн холбоодтой хамтарч боловсруулсан байна. | - Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран “хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт”-ыг 2023 оны 05 дугаар сарын 16-17, 19-ний өдрүүдэд нийт 130 албан хаагчдыг /одоо ажиллаж байгаа нийт улсын байцаагчид/ хамруулан зохион байгуулсан.<br>Мөн Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагатай хамтран 2023.09.27-2023.09.28-ны өдрүүдэд ХХҮЕГ, НДЕГ, Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нийт 60 улсын ахлах байцаагчдыг хамруулан 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. | |
| 204. | Иргэд, ААНБ-ыг соён гэгээрүүлэх мэдээ мэдээллийг хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах суваг, сонирхолд тулгуурлан ойлгомжтой байдлаар хүргэнэ. | Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр | -Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br><br>-Хамрагдсан ААНБ. иргэдийн тоо | 2022 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх видео зөвлөмж 3 ширхэгийг бэлтгэн МХЕГ-ын http://inspection.gov.mn/ вебсайтад байршуулан олон нийтэд хүртээл болгосон. Видео зөвлөмжийн хандалт нийт 2358 байна. | Иргэд, ААНБ-ыг соён гэгээрүүлэх мэдээ мэдээллийг хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах суваг, сонирхолд тулгуурлан хэрэглэгч, олон нийтэд сошиалаар лайв, боршур, гарын авлага контент хүргэсэн байна. | - Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр Европын холбоо, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр Хөдөлмөрий хууль тогтоомжийн эмхэтгэлийг хэвлүүлэн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч нарын хэрэгцээнд хүргүүлсэн.<br>- СХГ, ХХҮЕГ-ын улсын /ахлах/ байцаагч нар ХНХЯ-наас зохион байгуулж буй “Олон нийтийн цаг” цуврал 5 удаагийн цахим ярилцлагад оролцож Хөдөлмөрийн хяналтын бодлого, үйл ажиллагааны чиглэлээр иргэдэд тодорхой ойлголт, мэдээллийг өгч ажиллалаа. | 90 |
| 205. | -Шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа Зөрчлийн хэрэгт салбарын байгууллагыг төлөөлөн оролцоно. | Үйл ажиллагааны зардал | -Хуулийн хэрэгжилтийг хангах<br><br>-Арга хэмжээний тоо | 2022 онд хуулийн байгууллагаар шийдвэрлэгдсэн Зөрчлийн хэрэгт салбарын байгууллагыг | -Шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа Зөрчлийн хэрэгт салбарын | 2023 онд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан эрх бүхий албан тушаалтануудын үйл ажиллагаа болон шийдвэрийн талаар прокурор болон шүүхийн байгууллагаас хүчингүй болгож шимйдьэрлэсэн маргаан бүхий асуудал үүсээгүй тул дүүхэд төлөөлөх шаардлага гараагүй болно.<br>Харин төрийн хяналт шалгалтын тухай хуулийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | -Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтныг хууль зүйн мэдээллээр хангах, эрх зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлнэ. | | | төлөөлөн 32 удаа хуралд оролцсон. | байгууллагыг төлөөлөн оролцсон байна.<br>-Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтныг хууль зүйн мэдээллээр хангах, эрх зүйн зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлсэн байна. | хэрэгжилтийн талаарх улсын байцаагчийн актыг хүчингүй болгуулах “АЕИА” ХХК-ны маргаан бүхий асуудалд байгууллагыг төлөөлөн итгэмжлэлээр оролцож, нэхэмжлэгчийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн.<br>Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хүрээнд ХХҮЕГ, НДЕГ, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Булган, Дорноговь, Хэнтий аймгийн болон нийслэл, дүүргийн зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг удирдах болон эрх бүхий 23 албан тушаалтанд утсаар, цахимаар болон биечлэн зөвлөгөө өгч ажиллав.<br>“Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн явуулах талаарх мэдлэг олгох” сургалтыг НДЕГ, ХХҮЕГ, аймаг нийслэл, дүүргийн удирдах албан тушаалтан болон улсын байцаагч нарт цахим болон танхимаар 9 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 120 гаруй хүн хамрагдсан байна. | |
| 206. | Албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн талаар чадавхижуулах сургалт зохион байгуулна. | АНУ-ын Төрийн департаймент, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хүрээнд | МХЕГ, аймаг, нийслэлийн МХГ-ын хөдөлмөрийн хяналтын 80 улсын байцаагчийг чадавхижуулах | 2021 онд .“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, албадан хөдөлмөр, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн тухай” сэдэвт сургалтыг танхимаар 30, онлайнаар 115 нийт 145 улсын байцаагчдад 06 сарын 11-ний өдөр зохион байгуулж чадавхижуулсан. | Хөдөлмөрийн хяналтын 80 улсын байцаагчийг чадавхижуулсанаар, тэдний албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн талаарх ойлголт нэмэгдэж, хүүхдийн хөдөлмөрийн талаарх хяналт шалгалтын үр дүн нэмэгдсэн байна. | Олон улсын Хөдөлмөрийн байгууллага (ILO), Европын холбоо, Азийн сан, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага хамтран “Нийгмийн шударга ёсыг бэхжүүлье. Хүүхдийн хөдөлмөрийг устгая!” уриатай бодлогын зөвлөгөөн, Албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн талаар чадавхжуулах 2 өдрийн сургалтыг хөдөлмөрийн хяналтын 69 улсын (ахлах) байцаагчдад 2023 оны 06 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд танхимаар амжилттай зохион байгууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 207. | Бизнес эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад зориулсан салбарын сургалтыг зохион байгуулна. | ОУХБ | Сургалтанд хамрагдсан аж ахуйн нэгж /тоо/ | 250 ААНБ болон 250 ажилтан тус тус хамрагдсан. | 2023 онд 150 улсын байцаагчийг чадавхижуулах сургалтанд хамруулсан байна. | - Барилга хот байгуулалтын яамтай хамтран нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар 64 ААНБ-ын 100 ажил олгогч, инженер техникийн ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулсан.<br>- Барилга хот байгуулалтын яамтай хамтран Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд баригдаж байгаа Ногоон нуур 1088 орон сууцны хорооллын барилгын талбайд шинээр үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа ПАЖА шатны аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдал, анхны тусламж үзүүлэх сэдвүүдээр 150 аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч, инженер техникийн болон ХАБЭА ажилтнуудыг хамруулан үзүүлэх сургуулилт хийсэн.<br>Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн ЗДТГ болон ХХҮХ-үүдтэй хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад ажил олгогчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт 3 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт салбарын хяналтын бодлого үйл ажиллагаа, хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил анхаарах асуудал сэдвээр илтгэл тавьсан. Сургалтад нийт 500 ажил олгогч болон ИТА хамрагдсан. | 90 |
| | | | Сургалтын видео контентын тоо | 0 | 2 | - Нийгмийн даатгалын сангаас олгох Тэжээгчээ алдсан тэтгэмжийн тухай,<br>- "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт",<br>- Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа өндөр насны тэтгэврийн мэдээллийг тус тус сурталчилж нийт 160 гаруй мянган иргэнд хүргэсэн.<br>- Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомж, норм, дүрэм, журам, стандартыг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр БХБЯ, ХАБЭМТ-тэй хамтран 4 төрлийн шторк, ОУХБ-ын санхүүжилтээр 10 төрлийн постер гаргаж ХНХЯ, БХБЯ,ХХҮЕГ-ын вэб сайтуудаар нийтэд түгээж ажилласан.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны олон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийтийн мэдээллийн хэрэгсэл /https://mlsp.gov.mn//-ийн Мэдээ, мэдээлэл цэсний Видео мэдээ булан https://mlsp.gov.mn/content?c=3 –д Хөдөлмөрийн тухай хуулийн богино хэмжээний 10 видеог 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн түгээж байна. 2023 оны 11 сарын 01-ний өдрийн байдлаар нийт 4706 хандалт авсан байна. | |

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД ......................... /Х.БУЛГАНТУЯА/

*Тэмдэг* ............................
*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ......................... /Э.ГАНХҮҮ/

*Тэмдэг*

............................
*(огноо)*